# НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

*Хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

ЗАСАГ ДАРГА (Н.МАНДУУЛ)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*Тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА (Ж.ЛХАГВАСҮРЭН)
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр*

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 10 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая, төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **1.1 ЭРҮҮЛ МЭНД:** | | | | | | | |
| **1.1 Хүн амын халдварт болон халдварт бус өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1 | ***Арга хэмжээ 1.1.1*** “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, дүүргийн ИТХ-д хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллах; | 300.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80% | 100% | “Эрүүл Чингэлтэйчүүд-2024” арга хэмжээний хүрээнд 4 зорилт, 25 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд: Дүүргийн хэмжээнд нийт 136280 иргэн эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдахаас 55908/38% нь эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамрагдсан. “Эрүүл шүд” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 18650 хүүхэд, сургуулийн өмнөх боловсролын 1250 хүүхэд хамрагдсанаас шүдний өвчлөл өндөр дүүргийн Ерөнхий боловсролын 5, 37, 50, 72 дугаар сургуулийн 11280 хүүхдийг үе шаттайгаар шүд, амны хөндийн төлөвлөгөөт үзлэгт зайлшгүй хамруулахаас 1336 хүүхэд эмчилгээнд хамрагдсан. Ахмадын үзлэг, шинжилгээнд нийт 2588 ахмадыг, зорилтот бүлгийн хүүхдийн үзлэг, шинжилгээнд 1889 хүүхдийг тус тус | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулсан. БНСУ-ын “Грийн” эмнэлэгтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд 2024 оны 05 дугаар сард 17 эмч, мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг хүрэлцэн ирж, цус багадалт, дотор, шүдний үзлэг, шинжилгээг 1721 хүүхдэд хийж, хүүхэд бүрийг цус багадалтын эм, мульти витаминаар хангасан. Дүүргийн Эрүүл мэндийн төв 2024-2025 оны хичээлийн шинэ жилийг угтан сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдүүдийн шээс, цагаан хорхойн шинжилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг зөвлөгөөг 2024 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 31-ний өдрүүдэд зохион байгуулсан ба үзлэг, шинжилгээнд хамрагдсан дүүргийн 1-24 хороодын нийт 7125 хүүхдийн эцэг эхэд шүд арчилгаа, чих хамар хоолойн эмчийн зөвлөгөө, хүүхдийн эмчийн үзлэг, улаан бурхан, томуугийн эсрэг дархлаажуулалт зэрэг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлсэн. | |
| 2 | ***Арга хэмжээ 1.1.2***<br>Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалтыг сайжруулах; | | Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдалт, хувиар | 40% | 100% | 2024 онд “Эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ”-нд хамрагдвал зохих нийт 136280 иргэдээс үзлэгт хамрагдсан 55908 буюу 41.02%-тай байна. 0-17 насны хүүхдийн хамрагдвал зохих 47922 хүүхдээс үзлэгт хамрагдсан нийт 30389/63.4%-тай, 18-аас дээш насны хүн амын хамрагдвал зохих 88358 иргэдээс хамрагдсан нийт 25519/28.8%-тай байна.<br>Эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээний хамрагдалтын хувийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдүүлэх зорилгоор дараах эмнэлгүүдтэй хамтран ажиллаж байна. Дүүргийн 17, 18, 19, 23, 24 дүгээр хороодын иргэд Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, 7, 8, 20 дугаар хороодын иргэд Анагаахын Шинжлэх ухааны Үндэсний Их сургуулийн эмнэлэг, 1-24 дүгээр хороодын иргэд Улсын Хоёрдугаар төв эмнэлэг, 1-6, 9-16, 21, 22 дугаар хороодын иргэд дүүргийн Эрүүл мэндийн төвийн “Эрүүл мэндийг дэмжих төв”-д тус тус эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан.<br>Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх зорилгоор дүүргийн Эрүүл мэндийн төв, “Хэлт Рөүд” ХХК-ний “Клинико” эмнэлэгтэй хамтран “Явуулын үзлэг” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд дүүргийн 1-24 дүгээр хороодын хэмжээнд зохион байгуулж байна. Дүүргийн Ерөнхий боловсролын нийт 18 сургуулийн 26594 хүүхдэд хүүхдийн эмч, шүд, чих хамар хоолой, хеликобактер илрүүлэх шинжилгээ, нүдний эмчийн үзлэгт тус тус хамруулж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. | |
| 3 | ***Арга хэмжээ 1.1.3***<br>Товлолт болон товлолт бус дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлж | 30.0<br>Улс, орон нутгийн төсөв | Хамрагдсан хувь | 85% | 100% | Дүүргийн хэмжээнд дархлаажуу-лалтын 17 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд товлолын дархлаажуулалтад давхардсан тоогоор 25250 хүүхэд хамрагдахаас 24250 хүүхэд хамрагдаж 96.04%-тай байна. Тархвар судлалын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болох халдварт өвчний тандалтыг бэхжүүлнэ; | | | | | заалтаар хачигт энцефалитын эсрэг вакцинд эрсдэлт бүлгийн 140 хүнийг 2 тунд хамруулсан. Галзуу өвчний эсрэг вакцинжуулалтад 582 хүн, Сайн дураар вируст гепатитын эсрэг дархлаажуулалтад 1093 хүн хамрагдсан. Томуугийн дархлаажуу-лалтад 15280 иргэн хамрагдахаас 14394 хамрагдаж, 94.2%-тай байна. | |
| 4 | ***Арга хэмжээ 1.1.4*** Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дүүргийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэх ажлыг зохион байгуулж, үр дүнг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх; | Дүүргийн орон нутгийн төсөв | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/181 дүгээр захирамжийн дагуу дүүргийн Засаг дарга, Эрүүл мэндийн төв, 1-24 дүгээр хороодын ӨЭМТ-тэй байгуулсан 2024 оны гүйцэтгэлийн гэрээний хагас, бүтэн жилийн ажлыг дүгнэж, үр дүнг Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж ажилласан. | 100% |
| 5 | ***Арга хэмжээ 1.1.5*** Хүлээн авах яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажилд хяналт тавьж ажиллах; | 150.0 Улсын төсөв | Үйлчилгээ авсан иргэдийн хувь | 50% | 70% | Дүүргийн Эрүүл мэндийн төвийн яаралтай хүлээн авах тасгаар 21657 иргэн тусламж, үйлчилгээ авснаас том хүн 10232, хүүхэд 11425 байна. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн чанар аюулгүй байдлын албанаас “Яаралтай тусламжийг багаар үзүүлэх чадавхыг сайжруулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/814, 2023 оны А/220 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор “Амилуулах суурь тусламж” сэдэвт тохиолдолд суурилсан сургалтыг Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, нийт 113 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмнэлгийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн тэргэнцэртэй, таяг, дугуйтай зөөврийн орыг хүлээлгийн танхим болон хагалгааны тасагт, хэвтэн эмчлүүлэх болон амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн QR судалгааг авахаар тус тус байршуулсан. | |
| 6 | ***Арга хэмжээ 1.1.6*** Азийн Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалтаар баригдах дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын дэд бүтцийн асуудлыг шийдвэрлүүлэх; | Азийн хөгжлийн банк | Хяналт тавьсан ажлын тоо | 2 | 3 | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төслийн 2 дахь үе шат буюу 2019-2029 он хүртэл төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-өөр дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулах ажлын хүрээнд эмнэлгийн барилга барих газрыг 6.5 тэрбум төгрөгөөр 2.8 га газрыг дүүргийн хөрөнгөөр чөлөөлсөн. Тус ажлын 2-р шатны санхүүжилт болон үр дүнг албажуулахаар Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Чингэлтэй дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл нар 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр санамж бичигт гарын үсэг зурсан. Барилгын палан зургийн төлөвлөлтийг уг төслийн эмнэл зүйн зөвлөх баг “Интернейшнл Медикал Сентер” ХХК-ний мэргэжилтнүүдтэй хамтран дүүргийн хэрэгцээ, онцлогт тохирсон нэгдсэн эмнэлгийн барилгын төлөвлөлтийг хийсэн. Нэгдсэн эмнэлгийн дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, харилцаа | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбооны инженерийн дэд бүтцийн ажлыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын тендерт шалгарсан “Ричвелл” ХХК гүйцэтгэж байгаа ба Азийн хөгжлийн банкны төсөл хэрэгжүүлэгч нэгжээс геологийн дүгнэлт, дэвсгэр зураг гаргуулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. | |
| 7 | ***Арга хэмжээ 1.1.7*** Эрүүл мэндийн мобайл технологийн иж бүрдэлтэй ӨЭМТ-үүдийн тоог нэмэгдүүлэх; | 70.0 Дүүргийн төсөв | ӨЭМТ-ийн тоо | 6 | 7 | Эрүүл мэндийн яам, дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр АШУҮИС-ийн Анагаах ухааны сургууль хамтран “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн хүрээнд “Өрх, сумын түвшинд үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ” сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулж, дүүргээс мобайл технологийн багц авч тусламж үйлчилгээндээ ашиглах Мэнд-цолмон, Таны итгэл, Мөнхбаясгалант, Чин хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 11 эмч, сувилагч хамрагдсан. Мобайл технологи ашиглаж байгаа 9, 11, 12, 13, 15, 19 дүгээр хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүд халдварт бус өвчний зорилтот бүлгийн 35-аас дээш насны иргэдэд халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоог амбулаториор болон гэрийн нөхцөлд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Нийт 6 сарын хугацаанд 300 хүнд чихрийн шижингийн шинжилгээ хийж, 58 чихрийн шижинтэй хүн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр илрүүлж, дотоод шүүрлийн хяналтад илгээж, эргэн хянан эрсдэлт хүчин зүйлийг бууруулах урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгч байна. | |
| 8 | ***Арга хэмжээ 1.1.8*** Эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүдийг бэлтгэн, тогтвортой ажиллуулах; | 30.0 Эрүүл мэндийн төв | Сайн дурын ажилтны тоо | 45 | 65 | Дүүргийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 120 сайн дурын идэвхтэн ажиллаж байна. Сайн дурын идэвхтнүүд 6 удаагийн өдөрлөг, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 94161 гаруй иргэдийг хамруулж, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, зөвлөгөө өгч ажилласан. Сайн дурын идэвхтнүүд өдөрт дунджаар 2 цаг ажилладаг. | 100% |
| 9 | ***Арга хэмжээ 1.1.9*** “Эрүүл иргэн, өрх, байгууллага хамт олон”-ыг шалгаруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах; | 6.0 Эрүүл мэндийн төв | Эрүүл иргэн, өрх, байгууллагын тоо | 0 | 2 | ЭМС-ын “Журам батлах тухай” 2024 оны А/472 дугаар тушаал, НЭМГ-ын даргын 2024 оны А/84 дүгээр тушаал, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн өрх байгууллага шалгаруулах журам”-ын дагуу “Эрүүл мэндээ дээдлэгч өрх”, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн” шалгаруулах үйл ажиллагааны мэдээллийг 18 сургууль, 20 цэцэрлэг, албан байгууллагууд, дүүргийн 1-24 хороодын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус тус 3 удаа танилцуулсан. Дүүргийн хэмжээнд “Эрүүл мэндээ дээдлэгч өрх”-1, “Эрүүл мэндийг дээдлэгч иргэн”-ээр 2 иргэнийг шалгаруулан нийслэлийн Эрүүл мэндийн газарт материалыг шалгаруулахаар илгээсэн. ӨЭМТ-үүдийн цахим хуудас, мэдээллийн самбар болон телевизээр Түмэн дасгал, идэвхтэй дасгал хөдөлгөөний ашиг тус, “Идэвхтэй дасгал хөдөлгөөний үр нөлөө”, “Таргалалт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түүний сөрөг нөлөө", Хүзүүний дасгал", зэрэг мэдээллийг бэлтгэн өдөр тутамд гаргаж байна. Дүүргийн Цагдаагийн газрын 76 албан хаагчдад ажлын байрны дасгалын нөлөө, үр дүнг тайлбарлан зөвлөгөө өгч гарын авлага тараасан. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний төв, лавлагаа шатлалын болон нийслэлийн Эрүүл мэндийн 33 байгууллага хамтран "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024" өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулсан ба өдөрлөгийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох зөвлөгөө мэдээллийг нийт 180 хүнд хүргэсэн. | |
| 10 | ***Арга хэмжээ 1.1.10***<br>Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах сургалт сурталчилгааг өргөжүүлэх; | 35.0 | Хийсэн сургалт, үйл ажиллагааны тоо | 2 | 4 | Дүүргийн хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилгоор "Эртэч Чингэлтэйчүүд-2" аяныг зохион байгуулж, 2000 албан хаагчид, иргэд хамрагдсан. Эрүүл мэндийн яамнаас "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан иргэдэд эрүүл зөв амьдралын хэв маягийг төлөвшүүлэх замаар сэргийлж болох халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулах, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ач холбогдлын талаар сурталчлан таниулах үйл ажиллагааг багаар зохион байгуулсан ба арга хэмжээний хүрээнд эрүүл зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, стрессээ даван туулах арга зам сэдэвт зөвлөгөө мэдээллийн үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа зохион байгуулж 215 иргэнийг хамруулан гарын авлага болон үзлэг шинжилгээнд хамруулсан. “Эрүүл идэвхтэй амьдрал” цахим хуудсаар иргэдэд зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, орчны эрүүл ахуй, хорт зуршлын талаар тогтмол зөвлөгөө мэдээлэл иргэдэд хүргэж байна. Эрүүл мэндийн төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдэд идэвхтэй хөдөлгөөний талаар зохион байгуулсан аян, өдөрлөг арга хэмжээ 10 удаа, эрүүл зөв зохистой хооллолтын талаар зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, өдөрлөг 7 удаа, сэтгэцийн эрүүл мэнд болон хорт зуршлын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 5 удаа явагдаж давхардсан тоогоор нийт 8626 иргэд хамрагдсан. | |
| 11 | ***Арга хэмжээ 1.1.11*** Эрүүл мэндийн салбарын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулах; | 20.0 Дүүргийн төсөв | Үйл ажиллагааны тоо | 2 | 3 | Олон улсын Эмч нарын өдрийг тохиолдуулан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй болгох, цаашид харилцан мэдлэг туршлагаа солилцох, тулгамдсан асуудлаа хамтдаа тодорхойлох зорилгоор “Би шинэ зууны эмч” уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж дүүргийн ЭМТ-ийн 106 эмч өдөрлөгт оролцсон. Олон Улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй болгох, цаашид харилцан мэдлэг туршлагаа солилцох, тулгамдсан асуудлаа хамтдаа тодорхойлох зорилгоор “Эрүүл мэндийн салбарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжилд сувилагчийн оролцоо" уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан ба өдөрлөгт дүүргийн ЭМТ болон ӨЭМТ-ийн 146 сувилагч оролцлоо. Эрүүл мэндийн ажилтны өдрийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны А/245 дугаар захирамжаар эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дүүргийн ЭМТ болон хороодын ӨЭМТ-ийн 20 ажилтан, албан хаагчид нийгмийн баталгааг хангах хүрээнд 100 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. | |
| 12 | ***Арга хэмжээ 1.1.12*** "Орбис" ОУ-ын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх хүн амын дундах чихрийн шижин өвчний хяналтыг сайжруулах төслийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Сургалт, үйл ажиллагааны тоо | 1 | 3 | "Орбис" Олон Улсын байгууллагатай хамтран нийт 1400 иргэний чихрийн шижин өвчний хяналтыг хийж, нүдний уг дурандах үзлэг шинжилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. | 100% |
| 13 | ***Арга хэмжээ 1.1.13*** Өсвөр үе, залуусын дунд хар тамхи, мансууруулах бодисын хор уршгаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах; | - | Сургалт, үйл ажиллагааны тоо | 1 | 2 | "Хорт зуршил-Шинэ үеийн сонголт биш аян"-ыг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв, дүүргийн Эрүүл мэндийн төв болон дүүргийн Прокурорын газар, ЕБС-иуд, МСҮТ-үүдтэй хамтран зохион байгуулсан. Аяны хүрээнд "Шинэ иргэншил" МСҮТ, Барилгын коллежийн дотуур байрны суралцагсад болон Ерөнхий боловсролын 12 сургуулийн ахлах ангийн сурагчдад "Утаат болон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | электрон тамхины хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх нь", "Дэлгэцийн донтолт ба өөрийгөө хянах арга зам", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх нь", "Өсвөр үеийн кабинетын танилцуулга, хаяг байршил, цахим хаяг" зэрэг сэдвүүдээр зохион байгуулж, 14 удаагийн сургалтад 2190 хүүхдийг хамруулсан. | |
| 14 | ***Арга хэмжээ 1.1.14*** Дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл"-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | 5.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 30% | 35% | Дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/46 дугаар захирамжаар шинэчилсэн. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг хийж 50-иас доошгүй хувийг нь хүртээмжтэй болгох хүрээнд дүүргийн төрийн байгууллагууд болон төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн гадна талбай, барилга байгууламжид дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар буюу "Түгээмэл хөгжил төв" төрийн бус байгууллагаар хийлгэсэн ба үнэлгээг нийт 40 байршилд буюу ЗДТГ-ын байр, 7-24 дүгээр хороодын байр болон төрийн өмчит Ерөнхий боловсролын сургуулиудын байранд хийсэн. 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр 2/780 дугаар албан бичгээр дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст дүүргийн харьяалах нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 25- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аас дээш ажилтантай төрийн байгууллагууд, төрийн өмчийн оролцоотой компаниуд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж байгаа талаарх судалгааг 2024 оны 04, 10 дугаар сард зохион байгуулж ажиллах чиглэлийг өгсөн. Дээрх чиглэлийн дагуу 2024 оны 04 дүгээр сард дүүргийн хэмжээнд 334 байгууллагын судалгаа гаргаж, хөдөлмөр эрхэлдэг 135 хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээллийг гаргаж, нэгтгэсэн. | |
| 15 | ***Арга хэмжээ 1.1.15*** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах; | - | Үйл ажиллагааны тоо | 2 | 3 | Япон Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдуудын хамтарсан тушаалаар 2021 онд шинэчлэн батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал"-ын дагуу дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт илрүүлэг, оролцоо хөгжлийн дэмжлэгийг цогц байдлаар хэрэгжүүлэх төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба Япон улсын хэрэгжүүлсэн төслийн санаачилгад тулгуурлан хүүхдийн хөгжлийн хоцрогдол, хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, шаардлагатай дэмжлэг, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах зорилгоор дүүргийн 4, 5 дугаар хорооны “Энэрэнгүй-Үйлс” ӨЭМТ, 18 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар цэцэрлэгийг хамруулж, жишиг болгохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 9, 18, 36 сартай хүүхдийн эрт илрүүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг таниулан сурталчлах нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байна. | |
| 16 | ***Арга хэмжээ 1.1.16*** “Хотын хөгжлийн индекс”-ийн 2022 оны маягтуудыг программд шивэлт хийж, холбогдох дээд байгууллагад хүргэн ажиллах; | - | Ажлын гүйцэтгэлийн хувь | 70% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Аргачлал шинэчлэн батлах тухай” 20 дугаар тогтоол, Үндэсний Статистикийн хорооны даргын 2018 оны “Хотын хөгжлийн индекс тооцох аргачлал батлах тухай” А/77 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 1-24 дүгээр хороодын хотын хөгжлийн индексийн анхан шатны мэдээллийн бодит байдал, чанарт үнэлгээ хийж дүгнэлт гаргах, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөн тусалж ажилласан. Дүүргийн 1-24 дүгээр хороодын "Хотын хөгжлийн индекс"-ийн үзүүлэлтүүдийн анхан шатны мэдээллийг 2023 оны жилийн эцсийн байдлаар http://happycity.mn/ программд шивэх чиглэлийг өгч, хяналт тавьж ажилласан ба индексийн холбогдох маягтуудыг баталгаажуулан авч, шалгасан. | 100% |
| **1.2 БИЕИЙН ТАМИР, СПОРТ** | | | | | | | |
| **1.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Чингэлтэй лиг” олон төрөлт уралдаан тэмцээнийг жил бүр зохион байгуулна.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | ***Арга хэмжээ 1.2.1*** Ахмад, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд дүүргийн аварга шалгаруулах спортын тэмцээн уралдааныг зохион байгуулах; | 11.160 Улсын төсөв | Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан иргэдийн тоо | 12/1030 | 12/1050 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аварга шалгаруулах тэмцээнийг суугаа волейбол, бочи, нисдэг таваг гэсэн спортын 3 төрлөөр зохион байгуулж, 6 байгууллагын 90 иргэд хамрагдсан. Ахмадын аварга шалгаруулах тэмцээнийг софт волейбол, волейбол, явган аялал, гранд гольфын спортын 4 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 89 байгууллагын 1100 иргэд тус тус хамрагдсан. | 100% |
| 18 | ***Арга хэмжээ 1.2.2*** Дүүргийн залуучуудын аварга шалгаруулах 3 төрөлт Лигийн тэмцээнийг зохион байгуулж, иргэдийг идэвхтэй хамруулах; | 12.040 Орон нутгийн төсөв | Зохион байгуулагдсан тэмцээний тоо/ хамрагдсан иргэдийн тоо | 3/800 | 3/850 | Дүүргийн Засаг даргын Тамгын газраас “ЗӨВ ЗАЛУУС” уриан дор зохион байгуулагдсан “ЧИНГЭЛТЭЙ ЦОМ-2024” их наадмын тэмцээнийг сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөг, шатар, даам, дартс, нисдэг таваг, олс таталт, Екорн төрлүүдээр зохион байгуулж, нийт 24 байгууллагын 1500 тамирчин хамрагдсан. | 100% |
| 19 | ***Арга хэмжээ 1.2.3*** “Нийслэлийн иргэдийн спортын их наадам”-д дүүргийн иргэдийг оролцуулах; | 20.0 Улсын төсөв | Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо | 8/500 | 8/520 | Дүүргийн Засаг даргын нэрэмжит Иргэдийн спортын XII их наадмыг спортын 9 төрөлт тэмцээнийг зохион байгуулж, нийт 117 байгууллагын 1706 иргэд хамрагдсан. “Нийслэлийн аварга шалгаруулах иргэдийн спортын их наадам”-ын явган аяллын шигшээ тэмцээнд дүүргийн 13 дугаар хорооны 12 тамирчин оролцож, 4 дүгээр байрт шалгарсан амжилт үзүүлсэн. | 100% |
| 20 | ***Арга хэмжээ 1.2.4*** “Улаанбаатар марафон” Олон Улсын гүйлтийн тэмцээнд ажилтан, албан хаагч, иргэдийг оролцуулах; | 2.0 Улсын төсөв | Хамрагдсан иргэдийн тоо | 3500 | 3550 | Дүүргийн иргэдийг биеийн тамир, спортоор хичээллүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” Олон Улсын гүйлтийн тэмцээн 2024 оны 05 дугаар сарын 25- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ны өдөр амжилттай зохион байгуулагдсан. Дүүргээс төрийн болон төрийн бус аж ахуй нэгж, байгууллагуудын ажилтан, албан хаагчид, иргэд, сурагчдаас бүрдсэн нийт 82 байгууллагын 4600 иргэд хамрагдсан. | |
| 21 | ***Арга хэмжээ 1.2.5*** Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар ББХЧТТ Сорил авах, ажилтан, албан хаагчдыг хамруулах; | 8.0 Улсын төсөв 1.0 Орон нутгийн төсөв | Хамрагдсан иргэдийн тоо | 13.800 | 13.850 | Тайлант хугацаанд ББХЧТТ сорил авах арга хэмжээнд нийт 123 байгууллагын 17800 иргэдийг хамруулсан. | 100% |
| 22 | ***Арга хэмжээ 1.2.6*** Төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах; | 30.0 Орон нутгийн төсөв 10.34 Улсын төсөв | Зохион байгуулагдсан тэмцээний тоо, хамрагдсан тамирчдын тоо | 21/2000 | 21/2100 | Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, албан хаагчдын дунд “Спорт-2024” наадмыг спортын 6 төрлөөр зохион байгуулж, 12 сургуулийн 1000 ажилтан, албан хаагчид хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд “Спорт наадам-2024” спортын 4 төрлөөр зохион байгуулж, 36 цэцэрлэгийн 850 ажилтан, албан хаагчид хамрагдсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын хооронд төрийн албан хаагчдын 5 төрөлтийн тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 914 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 23 | ***Арга хэмжээ 1.2.7*** Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж иргэдийг биеийн тамир | - | Зохион байгуулах арга хэмжээ, оролцогчдын тоо | 1500 | 1550 | Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэхээр дүүргийн Засаг даргын дэргэдэх хоккей, тэшүүрийн өсвөрийн шигшээ багийн нийт 50 тамирчин, 2 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн, оролцоог нэмэгдүүлэн ажиллах; | | | | | дасгалжуулагч тогтмол бэлтгэл сургуулилт хийж байна. Мөсөн гулгуурын талбай, усан бассейн, фитнес заал, спорт заал, бүжгийн заалаар 2024 онд давхардсан тоогоор дүүргийн нийт 28000 гаруй иргэд үйлчлүүлсэн. | |
| 24 | ***Арга хэмжээ 1.2.8*** Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн тамирчдыг уралдаан тэмцээнд оролцох нөхцөлөөр хангаж, дэмжиж ажиллах; | 132.960 Орон нутгийн төсөв | Авсан медалийн тоо | 184 | 250 | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/17 дугаар захирамжийн хүрээнд жүдо бөх, чөлөөт бөх, таеквондо, хөнгөн атлетик, волейбол, сагсан бөмбөг, усан спорт, хоккей, үндэсний бөх, шатар, бокс, спортын гимнастик, тэшүүр, хөл бөмбөг, ширээний теннис зэрэг спортын 15 төрлөөр өсвөрийн шигшээ багийн дасгалжуулагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд өсвөрийн шигшээ багийн тамирчид Олон Улсын болон Улсын чанартай 56 удаагийн тэмцээнд оролцож 395 медаль хүртлээ. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 хүрэл медаль, Олон Улсын тэмцээнээс 5 алтан медаль, 3 мөнгөн медаль, 13 хүрэл медаль, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 65 алтан медаль, 49 мөнгөн медаль, 70 хүрэл медаль, хотын аварга шалгаруулах тэмцээнээс 29 алтан медаль, 27 мөнгөн медаль, 20 хүрэл медаль, нэрэмжит тэмцээнээс 42 алтан медаль, 27 мөнгөн медаль, 44 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. | 100% |
| **1.3 БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН** | | | | | | | |
| **1.3 Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын хичээлийн чанарыг ахиулах, сэтгэлгээний өндөр хурдтай иргэнийг төлөвшүүлэх зорилгоор “Оюунлаг Чингэлтэйчүүд” төслийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | ***Арга хэмжээ 1.3.1*** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Оюунлаг Чингэлтэйчүүд” уралдааныг үе шаттай зохион байгуулах; | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2 | 3 | Нийслэлийн Чингэлтэй дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах “ШАТАР“-ын тэмцээнийг 6 насны ангилалд зохион байгуулж, нийт 13 сургуулийн 143 тамирчид оролцож аваргуудыг шалгаруулсан. Нийслэлийн Боловсролын газартай хамтран дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийн 9 дүгээр ангийн 2100 суралцагчдаас математикийн сорил авч ажилласан. Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдэд монгол өв, уламжлал, ёс заншлаа мэдэх, дээдлэх зорилгоор 38 цэцэрлэг ёс заншлын өргөө, сургалтын төв тохижуулан ажилласан. “Би Монгол хүүхэд” аяныг зарлан ёс заншлаа дээдлэн, ардын өв уламжлалаасаа суралцсан үйл ажиллагааг 33 цэцэрлэгийн 150 бүлгийн 3750 хүүхэд, 2500 эцэг эхийн оролцоотой хэрэгжүүлсэн. “Өв соёлоо дээдэлье-Цээрлэх ёс” цахим дүрс бичлэгийг бэлтгэн хүүхэд, эцэг эхчүүдэд танилцуулж, давхардсан тоогоор 654 хүүхэд, 1586 эцэг эх хамрагдсан. ”Би Монгол хүн” ёс заншлын наадмыг 17 сургуулийн бага ангийн 13320 сурагчдын дунд үе шаттайгаар зохион байгуулж 3-р шатанд 72, 149 дүгээр сургуулиуд Нийслэлд 7 төрлөөр оролцсон. | 100% |
| 26 | ***Арга хэмжээ 1.3.2*** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулах; | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2 | 4 | Дүүргийн 37 дугаар сургуультай хамтран "Тэгш хамруулах боловсрол" олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулж дүүргийн хэмжээний 17 сургууль, 38 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэцэрлэгийн нийт 168 багш хамрагдсан. "ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ" хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон эцэг эх асран хамгаалагчдад чиглэсэн зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөгийг “PDC MONGOLIA” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн "Гэгээлэн" төвтэй хамтран зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд 120 хүүхэд хамрагдсан. “Дауны хам шинж” оноштой 6 настай хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс ирүүлсэн цэцэрлэгт үргэлжлүүлэн 1 жил хамруулах хүсэлтийн дагуу Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтыг үндэслэн тухайн цэцэрлэгт үргэлжлүүлэн хамруулсан. | |
| 27 | ***Арга хэмжээ 1.3.3***<br>ЭЕШ-д бэлдэж буй сурагчдад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулах; | | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 3 | 4 | Дүүргийн төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад ЭЕШ-д бэлтгэх Шинэ Алхам-2024 номыг хүргэж, элсэлтийн шалгалтад хэрхэн бэлтгэгдэх талаарх мэдээллийг хүргэж ажилласан. Боловсролын үнэлгээний төвөөс 12 дугаар ангийн 2023-2024 оны хичээлийн жилд төгсөгчдөд зориулсан элсэлтийн шалгалтын зөвлөгөө, мэдээлэл, сургалт зохион байгуулж төрийн ба төрийн бус өмчийн 16 сургуулийн 1360 сурагч хамрагдаж, мэдээлэл авсан. 2024 оны Ерөнхий шалгалтаар 800 оноо авсан 20 сурагч, 17 багшийг орон нутгийн сангаас шагнаж урамшуулсан. Улсын Их | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хурлын гишүүн О.Батнайрамдал ахлах ангийн 1400 сурагчдад ирээдүйн зорилгоо тодорхойлох, мэргэжил сонголт, хувь хүний өсөлт хөгжлийн талаар ярилцан “Ховдоос Харвард” номын танилцуулга хийсэн. | |
| 28 | ***Арга хэмжээ 1.3.4*** Боловсролын байгууллагын багш, ажилчдын ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулах; | 4.0 сая Дүүрэг, ОНТөсөв | Хамрагдсан багш, ажилчдын тоо | 1200 | 1250 | Цэцэрлэгийн багшийн ёс зүйн 2 зөвлөлийг шинэчлэн байгуулж, багш, удирдах ажилтны харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалт үйл ажиллагааг 38 цэцэрлэгийн 360 багш, 75 удирдах ажилтанд зохион байгуулсан. Төрийн өмчийн 38 цэцэрлэг, төрийн бус өмчийн 9 цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт хийж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас санаачлан дүүргийн төрийн өмчит 38 цэцэрлэгийн эрхлэгч, эмч, багш, эцэг эхчүүдэд зориулан “Багш, эцэг эхчүүд хамтдаа оролцъё” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан ба үйл ажиллагаанд 450 эцэг эх, асран хамгаалагч оролцсон. “Гэр бүлийн судалгаа боловсролын үндэсний хүрээлэн” ТББ, дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс хамтран дүүргийн 24 дүгээр сургуулийн 1-5 дугаар ангийн 150 эцэг эхэд “Хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, эцэг, эхчүүдэд гэр бүлийн боловсрол олгох” сэдвээр сургалт явуулсан. | 70% |
| 29 | ***Арга хэмжээ 1.3.5*** Интерактив цахим хичээл явуулах боломж | - | Анги, танхимын тоог | 10 | 12 | Дүүргийн хэмжээнд Ерөнхий боловсролын 17 сургууль 2 цахим ангитай болсон. Мөн номын сангийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлсэн анги, танхимын тоог нэмэгдүүлэх; | | | | | цахим систем болох "Гэрэгэ" системд нэвтэрч, нөхөн хангалтын номын захиалга, тараалт, түрээслэлтийг цахимаар хийх ажлыг хэвшүүлэн ажиллаж байна. AR дэвшилтэт сургалтын хэрэглэгдэхүүнийг 10 цэцэрлэг 12,990,000 төгрөгийн төсөвт өртгөөр авч хэрэгжүүлж ажилласан. Азийн сангийн санхүүжилтээр 30 цэцэрлэгт 5 төрлийн 150 ширхэг цахим ном нийлүүлсэн. Ерөнхий боловсролын 23, 24, 57, 117, 145 дугаар сургуулиуд цахим анги нээж бусад сургуулиуд цахим ангиа техник хэрэгслээр ханган хөгжүүлж байна. | |
| 30 | ***Арга хэмжээ 1.3.6*** “Чадварлаг багш-2024” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хանган ажиллах; | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80% | 85% | Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын “Багш солилцоо хөтөлбөр”-ийн хүрээнд 14 аймаг, дүүргийн цэцэрлэгтэй хамтран ажиллаж, 114 багшийг оролцуулж арга зүй, туршлага хуваалцсан. Үндэсний хэмжээнд сургагч багшаар бэлтгэх 3 удаагийн сургалтад 16 багш суралцсан. Боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний индексийн түвшин ахисан сургууль, цэцэрлэгээр 155 дугаар цэцэрлэг шалгарсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хэрэгждэг IM BRICK Олон Улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгүүдийн багш, удирдах ажилтныг чадавхжуулах, харилцан туршлага судлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа ба 9 багш, эрхлэгч, арга зүйч хамрагдсан. Дүүргийн ЗДТГ, Боловсролын хэлтэс хамтран дүүргийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ерөнхий боловсролын 17 сургуулийн 351 бага ангийн багш нарын төлөөлөл 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа 150 орчим багшийн дунд ур чадварыг дээшлүүлэх уралдааныг зохион байгуулсан. Дүүргийн СӨББ-ын байгууллагын 50 цэцэрлэгийн 364 багшид Виртуал картыг олгосон. СӨББ-ын багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний 2022-2024 оны үр дүнд харьцуулсан дүн шинжилгээ хийсэн. Ерөнхий боловсролын 17 сургуулийн 351 бага ангийн багш нарын төлөөлөл 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа 150 орчим багшийн дунд ур чадварыг дээшлүүлэх уралдааныг зохион байгуулсан. Дүүргийн СӨББ-ын байгууллагын 50 цэцэрлэгийн 364 багшид Виртуал картыг олгосон. 2023-2024 оны багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд ЕБС-ийн 20 сургуулийн 1322 багш, СӨББ-ын 38 цэцэрлэгийн 307 багш хамрагдсан. Олон Улсын 2 хөтөлбөрийг 31 цэцэрлэг нэмэлтээр авч 10 багшийг БНСУ-д туршлага судлуулсан. | |
| 31 | ***Арга хэмжээ 1.3.7*** Боловсролын байгууллагын удирдлага, багш, ажилчдын дунд илтгэл, ур чадвар, урлаг, спортын тэмцээн зохион байгуулах; | 100.0 сая Дүүрэг, орон нутгийн төсөв | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 3 | 4 | Боловсролын Ерөнхий газраас зохион байгуулсан "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын байгууллагын менежментэд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалт"-ыг төрийн өмчийн 38 цэцэрлэгийн эрхлэгч, 34 арга зүйчид зохион байгуулсан. Дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулиудад 1-5 дахь | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилдээ ажиллаж байгаа багш нарын дунд “Бага ангийн залуу багш нарын ур чадварын уралдаан”-ыг 3 үе шаттай зохион байгуулсан. Дүүргийн Боловсролын хэлтэс “Монголын Чинад мэдрэхүй утга зохиол”-ын холбоотой хамтран Дашдоржийн Нацагдоржийн нэрэмжит Өсвөрийн найрагчдын “Хүрэл тулга-2024” наадмыг зохион байгуулсан. Нийслэлийн багш, удирдах ажилтнуудын дунд зохион байгуулсан “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь” илтгэлийн уралдаанд дүүрэг, нийслэлээс шалгарч, Улсын багш нарын Үндэсний эрдэм шинжилгээний хуралд 103, 291 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч илтгэлээ хэлэлцүүлсэн. IM BRICK Олон Улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгүүдийн багш, удирдах ажилтныг чадавхжуулах, харилцан туршлага судлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж 9 багш, эрхлэгч, арга зүйч хамрагдсан. Засаг даргын нэрэмжит “Спорт наадам-2024” тэмцээнд СӨББ-ын 38 байгууллагын 400 гаруй, ЕБС-ийн 17 сургуулийн 800 багш ажилтан оролцсон. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд 19 ангиллаар “Ур чадвар-2024” уралдааныг зохион байгуулж дүүргийн шатны шалгаруулалтад давхардсан тоогоор 450 гаруй багш оролцсон. “Багшийн ур авьяас” ур чадварын уралдааныг 5 бүсийн 38 багшийн дунд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулсан. Дүүргийн 20 сургуулийн 37 сургалтын менежер Япон Улсын 6 хотын 4 сургуулийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан. Мөн цэцэрлэгүүдийн 35 арга зүйч Япон Улсын Токио хотын 2 цэцэрлэг, Насан туршийн Суралцахуйн төв, 1 сургуультай танилцан туршлага судалсан. | |
| 32 | ***Арга хэмжээ 1.3.8*** Дүүргийн шилдэг багш, ажилтан, сургууль цэцэрлэгийг шалгаруулж урамшуулал олгох; | - | Урамшуулал авсан байгууллага, хүний тоо | 8 | 10 | IMBRICK Олон Улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч цэцэрлэгүүд арга зүй туршлагаа хуваалцан амжилттай ажилласан багш, арга зүйч, удирдлагын 9 албан хаагч БНСУ-д богино хугацааны сургалтад хамрагдсан. Дүүргийн 220 дугаар цэцэрлэг нийслэлийн Тэгш хамруулан сургагч байгууллагаар, 275 дугаар цэцэрлэгийн слесарь Б.Тэргэлсайхан үйлчилгээний чадварлаг ажилтан, 5 дугаар цэцэрлэгийн хөгжмийн багш н.Тэгшбуян зөвлөгч багшаар, 293 дугаар цэцэрлэг “Нийслэлийн шилдэг менежменттэй байгууллага”, 23 дугаар сургууль “Шилдэг менежменттэй ментор сургууль”-аар тус тус шалгарсан. | 100% |
| 33 | ***Арга хэмжээ 1.3.9*** Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх; | - | Хамрагдсан байгууллагын тоо | 18 | 33 | Ерөнхий боловсролын 18 сургуульд Олон Улсын “Эдүтэн болон Пийрсон” хөтөлбөрүүдийг үргэлжлэн хэрэгжиж 8900 сурагч хамрагдаж байна. Дүүргийн Засаг даргын санаачилгаар төрийн өмчийн 38 цэцэрлэгт Олон Улсын “STEAM”, “IM BRICK”, “Монтессори” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 3 удаагийн арга | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээг 152 багш, 3800 суралцагч, 2800 эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулан сургалт, үзүүлэх ажлыг зохион байгуулсан. Steam хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэгч 200 гаруй цэцэрлэгээс шалгарсан 30 багийн хүүхдүүд оролцсон “GREEN MECH” Олон Улсад зохион байгуулагддаг тэмцээн Монгол Улсад зохион байгуулагдсан ба тэмцээнд 103, 258, 291, 298 дугаар цэцэрлэгүүд оролцсоноос 291 дүгээр цэцэрлэг 3 дугаар байрт шалгарч, Индонез Улсад зохион байгуулагдсан Азийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон. Монтессори амьдрах ухааны боловсрол олгох хөтөлбөрийг 5, 293 дугаар цэцэрлэг, нийслэлийн 2 дүүрэг, 3 аймгийн 680 орчим багш нарт хэрэгжүүлэн, туршлага солилцсон. | |
| 34 | ***Арга хэмжээ 1.3.10*** Багш, сурагчдын дунд гадаад хэлний олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах; | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 0 | 1 | Дүүргийн ЕБС-иудын гадаад хэлний олимпиад хуваарийн дагуу явагдаж, шалгарсан сурагчдыг Нийслэлийн олимпиадад амжилттай оролцуулсан. | 100% |
| **1.4 ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ДААТГАЛ** | | | | | | | |
| **1.4 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэн хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| 35 | ***Арга хэмжээ 1.4.1*** Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах; | 41.0 | Хамрагдсан иргэний тоо | 756 | 1000 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжийн 3.4.7, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2017 оны А/161 “Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанд тавигдах шалгуур үзүүлэлтийг тогтоох аргачлал батлах тухай” тушаалын дагуу дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй хөдөлмөрийн биржийг стандартын шаардлага хангасан эсэхэд дүгнэлт гаргуулахаар хүсэлт гаргасан. “Итгэлт бүтээмж төв” ТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн бирж, “Вест метод” ХХК-ний дэргэдэх Хөдөлмөрийн биржийн суурь баримт бичгийг боловсруулан нийслэлийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газарт хүргүүлсэн. Эрх бүхий 7 хөдөлмөрийн биржтэй гэрээ байгуулан дүүргийн хэмжээнд 2000 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтуудыг зохион байгуулсан. Сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 915, ажил идэвхтэй хайж буй 800 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 567 иргэнийг тохирох ажлын байранд зуучилсан. Ажил хайгч 450 иргэнд хөдөлмөр эрхлэх чадавхын үнэлгээ хийж, үнэлгээнд хамрагдсан 35 иргэнтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөөг боловсруулсан. Шинээр бий болсон 370 ажлын байрыг бүртгэн хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем И-жоб программд оруулсан. | |
| 36 | ***Арга хэмжээ 1.4.2*** Хүн амын бүлгийн хөдөлмөр эрхлэх | 25.8 | Хамрагдсан иргэний тоо | 344 | 1000 | Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй болон зорилтот бүлгийн 70 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөх, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; | | | | | өөрсдийнх нь онцлогт нийцсэн ажил, мэргэжлийн сонголт, чадвар, чадавхыг тодорхойлон хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. Дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөл 35 иргэнд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, цахим шилжилт И-жоб программ, иргэн аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг, ажил олгогчийг дэмжих үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээллийг хүргэсэн. Сул чөлөөтэй байгаа ажлын байрны захиалга 550, ажил идэвхтэй хайж буй 755 иргэнийг бүртгэж, ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхлыг харгалзан 356 иргэнийг тохирч тэнцэх ажлын байранд зуучилсан. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн захиалгыг Чингэлтэйн ажил хайгчдын нэгдсэн групп болон хэлтсийн дотоод группт байршуулан хороо хариуцсан мэргэжилтнүүд болон ажил хайж буй иргэдэд түгээн нийт 85 гаруй байгууллагын 750 гаруй захиалгыг түгээн ажилласан. | |
| **1.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулна.** | | | | | | | |
| 37 | ***Арга хэмжээ 1.5.1*** Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах; | - | Нэвтрүүлсэн үйлчилгээний тоо | 72-үйлчилгээ нээс 64 нэвтэрсэн | Ehalamj.mn системд 72 төрлийн үйлчилгээн ээс 64 | Нийгмийн халамжийн үйлчилгээ нь 2020 оноос эхлэн ehalamj.mn цахим системд шилжсэн ба 2020 онд 6 үйлчилгээ, 2021 онд 20 үйлчилгээ, 2022 онд 38 үйлчилгээ 2024 онд нийт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ. | 64 үйлчилгээ цахим системд шилжсэн. Эрх бүхий 7 хөдөлмөрийн биржтэй гэрээ байгуулан 2000 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг зохион байгуулж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем И-жоб платформд мэдээллийг шивж оруулсан. Шинээр бий болсон 550 ажлын байрыг бүртгэн хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн систем И-жоб программд оруулсан. | |
| **1.6 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүн амд үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 38 | ***Арга хэмжээ 1.6.1*** Нийгмийн даатгалын архивын үйлчилгээг иж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтын системийн нэвтрүүлэх; | Дүүргийн төсөв 70.6 сая.төг | Цахимаар лавлагаа олгосон иргэдийн тоогоор | - | НД-н архивын лавлагааг 1000 иргэнд олгоно | 2024 оны жилийн эцсийн байдлаар:<br>• 1992-1994 оны байгууллагын шимтгэл төлөлтийн лавлагаа – 240<br>• 1995-2005 оны шимтгэл төлөлтийн лавлагаа – 730<br>• 2006-2024 оны шимтгэл төлөлтийн QR лавлагаа – 195<br>• 1990-2000 оны нөхөн даатгалын лавлагаа-296<br>• Шимтгэл төлөөгүй тухай лавлагаа– 95-г тус тус архивын баримтад тулгуурлан олгосон.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар:<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдаас<br>2023 оны архивын баримтыг стандартын дагуу шалган хүлээн авсан.<br>2023 оны Байнга хадгалах хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж, Түр хадгалах хадгаламжийн нэгж бүхий нийт 750 гаруй баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалттай тулган | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүртгэлдүүлж, дугаар өгч, нягтруулсан шүүгээнд байршуулсан.<br>Архивд хадгалагдаж байгаа 1992-2023 оны баримтуудыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэж, дугаарлаж, нягтруулсан шүүгээнд хайрцаглан байршуулсан.<br>Газрын архивд 11 төрлийн бүртгэл бүхий нийт 12,107 гаруй хадгаламжийн нэгж бүхий баримт хадгалагдаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар:<br>Абле программаар бусад аймаг, дүүргүүдээс ирсэн хүсэлтийн дагуу нийт 558 иргэний шимтгэл төлөлтийн лавлагааг гарган хүргүүлж, архивын лавлагаа авах хүсэлтийг бусад аймаг дүүргүүдэд 504 хүсэлт хүргүүлж, 558 хүсэлтийн хариуг иргэдэд хүлээлгэн өгч ажилласан байна.<br>Эдок программаар Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсээс ирсэн 100 албан бичгийн хариуг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажилласан.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар:<br>Газрын дотоод үйл ажиллагаанд шаардагдсан 305 ширхэг архивын баримтыг байцаагч, ажилчдад түр ашиглуулан, бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж бүрэн хүлээн авч ажилласан байна.<br>Тус газар нь Чингэлтэй дүүргийн Тэтгэвэр авагчдын Тэтгэврийн хувийн хэргийн материалыг бүрэн цахимжуулах үйл ажиллагаа явуулж байна. Мөн 2024 онд шинээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоогдсон 1410 Тэтгэврийн материалыг цахимжуулсан байна. | |
| 39 | ***Арга хэмжээ 1.6.2*** Тоон гарын үсэг ашиглан тайлан илгээдэг аж ахуй нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэх; | - | Тоон гарын үсэг ашиглан тайлан илгээж байгаа байгууллагын тоогоор | 1698 ажил олгогч тоон гарын үсэг ашиглаж байна. | Нийт ажил олгогчдын 60-иас дээш хувийг хамруулна | Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2024 оны байдлаар нийт 619 аж ахуйн нэгж, байгууллагыг сургалтад хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 100% |
| 40 | ***Арга хэмжээ 1.6.3*** Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлэх; | - | Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, даатгуулагчдын тоо | 547/3501 | 600/3800 | 2024 оны тайлант хугацаанд тус газар нь иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2021-2024 онд газрын даргын баталсан хуваарийн дагуу газрын албан ёсны цахим хуудсаар сард хоёр удаа дамжуулан, 47 удаагийн цахим шууд бичлэг хийж, нийт 68228 гаруй иргэд үзсэн хандалттай байна. Цахим хуудсаар дамжуулан нийт 98 удаагийн Нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг шинэчлэн пост оруулж, иргэд даатгуулагч, ажил олгогчид мэдээллийг тухай бүрд хүргэн мэдээлж байна. Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлт, нэмэлт өөрчлөлт, чиглэл, заавар, зөвлөмжийг цаг тухайд нь сургалт мэдээллээр өгч 439 аж ахуйн нэгж байгууллага, 428 сайн дурын даатгуулагч, 24 удаагийн гадаад сургалтаар 896 даатгуулагч иргэнд мэдээлэл өгч хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх QR код 2000, шинэ аж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгж байгууллага бүртгүүлэх QR код 1950, тэтгэвэр тэтгэмжийн цахим зөвлөгөө бүхий 51500 гарын авлага брошюр бэлтгэн, тараан сурталчилж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. 2021-2024 оны байдлаар “Нээлттэй хаалганы өдөрлөг” 20 удаа зохион байгуулагдаж, нийт 13851 даатгуулагч иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 2021-2024 “ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ” явуулын үйлчилгээг 12 удаа зохион байгуулж, нийт 2080 иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулж, 2021- 2024 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүсэж буй нийт 14875 иргэд тэтгэвэр тогтоолгох талаарх зөвлөгөө, мэдээлэл, өгч ажилласан. Ажил олгогчдын зөвлөгөөнийг 2021-2024 оны байдлаар нийт 5 удаа зохион байгуулж 1700 аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогчдыг хамруулан арга зүйн мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. 2021-2024 онд Нийгмийн даатгалд хамрагдаагүй 41722.1 сая төгрөгийн цалингийн сан бүхий 1793 аж ахуйн нэгж, байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, шинээр бүртгэж, албан журмын даатгалд 3250 даатгуулагчийг шинээр хамруулсан. | |
| 41 | ***Арга хэмжээ 1.6.4*** Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол | - | Шинээр даатгалд хамрагдсан иргэдийн тоо, хувиар | 4369 иргэн хамруулан | 4500-аас доошгүй, 10 хувиар нэмэгдүүлнэ | Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамрагдалтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж, сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх; | | | ажилласан. | | байгуулах албан бус хөдөлмөр эрхлэгчдийг шинээр хамруулах ажлын хүрээнд 2024 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 9410 сайн дурын даатгуулагч хамрагдсан байна. Үүнээс сайн дурын даатгалд 8100 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эх 780 даатгуулагч, сайн дурын даатгалын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх 135 даатгуулагч, малчин, туслах малчин 12 гэрээ байгуулан сайн дурын даатгалд хамруулсан ба тайлант хугацаанд нийгмийн даатгалын санд 12762.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 10.209.6 сая төгрөг төвлөрүүлэн ажиллалаа. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах чиглэлийн хүрээнд дүүргийн Нийгмийн даатгалын газар Нийгмийн даатгалын багц хууль, сайн дурын даатгалын асуудлаар /цахим шууд бичлэг/ зөвлөгөө мэдээллийг 2024 оны 4, 5 дугаар сард зохион байгуулж иргэд, даатгуулагчдад хүргэн ажилласан. | |
| **1.7 ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД** | | | | | | | |
| **1.7 Гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “Гэр бүл-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 42 | ***Арга хэмжээ 1.7.1*** “Гэр бүл-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг хангаан ажиллаж, дүүргийн ИТХ-д хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллах; | - | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 70% | 100% | Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр бүл-2024” арга хэмжээний хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж тайлагнаж ажиллаж байна. Тайлант хугацаанд дүүргийн 1-24 дүгээр хороод, дүүргийн Цагдаагийн газрын 1, 2 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлтэстэй хамтран архины хамааралтай иргэдийн зан үйлийг засах "Урам" сургалтын үйл ажиллагааг долоо хоногт 3 удаа зохион байгуулж, 200 орчим иргэдийг хамруулсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, архи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах эрүүл зөв амьдралыг төлөвшүүлэх чиглэлээр "Бид хамтдаа", "Хамтдаа" дэмжих бүлэг байгуулан сургалт, зөвлөгөө, нөлөөллийн ажлыг тогтмол хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. "Бид хамтдаа" зорилтот төсөлд хамрагдаж байгаа 50 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийсний дагуу өрх бүрд "Бие даасан амьдралд бэлтгэх" хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөө гарган батлуулж, төлөвлөгөөний дагуу 12 модуль сургалтыг 7 хоног бүр зохион байгуулж ажилласан. | |
| 43 | ***Арга хэмжээ 1.7.2***<br>Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, зорилтод бүлгийн иргэдийг сэтгэл зүйн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах; | 4.0 Улсын төсөв | Хамрагдсан иргэдийн тоо | 280 | 400 | Гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв нь тайлант хугацаанд нийт 72 хүүхэд, 1 насанд хүрэгч, нийт 73 иргэнд үйлчилгээ үзүүлсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, зорилтот бүлгийн иргэдийг сэтгэл зүйн үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, бусад шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах чиглэлээр үйлчилгээ үзүүлсэн. Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн "Эрэгтэйчүүдэд нийгэм, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв", | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Хамтдаа” сэтгэл зүйн төвөөр дамжуулан зорилтот бүлгийн 50 гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй эрчүүдэд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалтын өрөө, ганцаарчилсан өрөө, хүлээлтийн өрөө гэсэн 3 өрөөнд 4 сэтгэл зүйч эрчүүдэд сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тус төвөөр нийт 156 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 108, насанд хүрэгч 48 байна. Давхардсан тоогоор 658 иргэнд хүрч ажилласан. | |
| 44 | ***Арга хэмжээ 1.7.3*** “Гэр бүлийн боловсрол” олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулах; | 4.0 Улсын төсөв | Хамрагдсан гэр бүлийн гишүүдийн тоо | 132 | 150 | Гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр нийт 7 сургалт арга хэмжээг зохион байгуулж, 350 хүн хамруулсан. Олон Улсын гэр бүлийн өдөрт зориулан дүүргийн Цагдаагийн газрын албан хаагчдад гэр бүлийн харилцааг дэмжих, ажлын ачааллаас үүдэлтэй гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэх арга замыг олоход туслах, өдөр тутам хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх “Бид нэг гэр бүл” үйл ажиллагааг зохион байгуулж, 100 хүнийг хамруулсан. Гэр бүлийн угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг зохион байгуулж 100 орчим гэр бүлийн гишүүдийг хамруулсан. Угийн бичиг хөтлөлтийн дэлгэрүүлэх, хөтлөх арга зүй олгох чиглэлийн хүрээнд нийт 89 албан хаагчдад угийн бичгийн хөтлөхийн ач холбогдлын тухай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад хамруулж, нийт 15 өрхөд хөтлөх арга зүй зөвлөгөө өгч ажилласан. “Гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, монгол ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Аз жаргалтай гэр бүл-гэрлэх ёслол”-ын арга хэмжээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Гэрлэх ёслолын ордонтой хамтран зохион байгуулж, дүүргийн 8 гэр бүлийн Алтан, Мөнгөн хуримыг зохион байгуулсан бөгөөд дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчид, дүүргийн иргэдээс шаардлага хангасан нийт 8 гэр бүлийг шалгаруулах, гэрлэх ёслолыг зохион байгуулахад иргэд, албан хаагчдад мэдээллийг хүргэж, холбогдох материалыг хүлээн авч, бэлтгэл ажлыг ханган хамтран ажилласан. Хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй эрчүүдэд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх мөн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалтын өрөө, ганцаарчилсан өрөө, хүлээлтийн өрөө гэсэн 3 өрөөнд 4 сэтгэл зүйч эрчүүдэд сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Тус төвөөр нийт 156 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 108 насанд хүрэгч 48 байна. | |
| 45 | ***Арга хэмжээ 1.7.4*** | 4.0 | Хамрагдсан хүүхдийн тоо | 240 | 300 | Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг Олон Улсын өдрийг тохиолдуулан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хүүхдийн өөрөө удирдах байгууллага, сургуулийн өөрөө удирдах байгууллагатай хамтран хүүхдийг хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх; | Орон нутгийн төсөв | | | | Чингэлтэй дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 оны 11 дүгээр тогтоолоор “Шийтгэл бол шийдэл биш” аяныг зарласан. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/83 дугаар захирамжаар “Шийтгэл бол шийдэл биш” аяныг 1 сарын хугацаанд зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, аяны хүрээнд дэргэдэх хэлтсүүдийг оролцуулсан төлөвлөгөө батлуулж, 8 арга хэмжээг дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, 1 арга хэмжээг Боловсролын хэлтэс, 3 арга хэмжээг дүүргийн Цагдаагийн газар, 2 арга хэмжээг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж, нийт 16 арга хэмжээнд давхардсан тоогоор 7000 орчим хүнийг хамруулсан. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан олон талт арга хэмжээ зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын 2024 оны А/106 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, арга хэмжээ зохион байгуулах 14 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө, бэлтгэл ажлын төлөвлөгөө, Засаг даргын Тамгын газрын даргын А/160 дугаар тушаал, удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Дүүргийн хүүхэд багачуудад зориулсан тус арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр дүүргийн Тусгаар тогтнолын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбайд 10.00 цагаас 18.00 цагийн хооронд нэгдсэн соёл урлаг, танин мэдэхүйн, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүүхдийн өөрөө удирдах байгууллага болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, худалдаа үйлчилгээг үзүүлж, хүүхэд, иргэдийн аюулгүй байдалд чиг үүргийн дагуу хяналт тавьж ажилласан. Хүүхдийн зөвлөлтэй хамтран “Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлье”, “Нэгдүгээрт шалга” аяныг зохион байгуулж, хүүхдийн зөвлөлийн гишүүд өөрсдийн амьдарч буй орчин, оршин суугаа газар, гэрээс сургууль хүрэх зам дахь орчны аюулгүй байдалд үнэлгээ хийж, эрсдэл бүхий байршлыг холбогдох газруудад мэдээлж ажилласан. | |
| 46 | ***Арга хэмжээ 1.7.5*** Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжүүдийн дэргэд “Эцэг эхийн зөвлөл” байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх; | 2.0 Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 1 | 2 | Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 03 тоот тогтоолыг үндэслэн Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх замаар ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдийг хөгжлийн үйлчилгээнд хамруулах чиглэлээр 2 байгууллагын 110 албан хаагч, 1 аж ахуй нэгж, байгууллагын 960 үйлчилгээ авдаг иргэд нийт 1060 хүнийг хамруулан хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн үнэ цэнэ сургалтуудыг зохион байгуулсан. Тайлант хугацаанд шинээр 15 аж ахуй нэгж, байгууллага дэргэдээ эцэг эхийн зөвлөл байгуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Тамгын газрын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар Эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан бөгөөд төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Энэ хүрээнд албан хаагчдын хүүхдүүдийг дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулсан. Мөн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албатай хамтран 66 хүүхдийг Чингис хааны музейг үзүүлсэн. | |
| 47 | ***Арга хэмжээ 1.7.6*** Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг зохион байгуулан салбар дундын уялдаа холбоог сайжруулж, дэмжин ажиллах; | 3.0 Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 4 | 6 | Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжихэд хөрөнгө гаргах тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг батлуулж, 1-24 дүгээр хороодын хамтарсан багт 3 дугаар улирлын байдлаар тус бүр 300000 төгрөгийн шатахууны зардал, 150000 төгрөгийн харилцаа холбооны зардлыг олгож ажилласан. Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын сургалтыг хамтарсан багийн гишүүдэд 1 дүгээр улиралд зохион байгуулж, 1-24 дүгээр хороодын хамтарсан багийн гишүүдийг хамруулж, хамтарсан багийн хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулсан. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран гэр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хороодын хамтарсан багийн гишүүдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, кейс менежментийг үр дүнтэй үзүүлэх чадавхыг сайжруулах, Шилдэг хамтарсан багийг шалгаруулж, сайн туршлагыг нэвтрүүлэх зорилгоор удирдамж батлуулан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, арга зүйгээр хангах бэлтгэл ажлыг хангаж байна. Хамтарсан багийн чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна. | |
| 48 | ***Арга хэмжээ 1.7.7*** Дүүргийн "Хүүхдийн төлөө зөвлөл"-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80% | 100% | Дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар 2024 онд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж 3 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөгөөг батлуулан, холбогдох хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавин ажиллаж байна. Хүүхдийг осол гэмтэл, болзошгүй эрсдэл зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх цахим зөвлөмж, гарын авлага, дүрс бичлэг чиглэлээр 100 гаруй цахим иргэдийн бүлгүүдэд түгээж, нийт 136766 хүнд хүргэсэн байна. | 100% |
| 49 | ***Арга хэмжээ 1.7.8*** Дүүргийн "Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл", төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 80% | 100% | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 378 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор дүүргийн залуучуудын хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нэгжийг өөрчилж, хариуцах нэгжгүй болсон бөгөөд салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах шаардлагатайн улмаас салбар зөвлөл хуралдаагүй бөгөөд дүүргийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | залуучуудыг хөгжүүлэх, идэвхжүүлэх, дэмжих, хөгжил оролцоог хангах чиглэлээр “YES Chingeltei” залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг “Шинэ шилдэг эрин” төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлж, уулзалт арга хэмжээг нийт 80 залуучуудыг хамруулан зохион байгуулсан. 2024 оны 08 дугаар сард Монголын Залуучуудын өдрийг тохиолдуулан дүүргийн Залуучуудын холбоотой хамтран залуучуудыг хөгжүүлэх, идэвхжүүлэх, дэмжих, нийгэмд оролцох оролцоог хангах чиглэлээр дүүргийн 250 залуучуудыг хамруулсан уулзалт зохион байгуулж, залуучуудын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | |
| 50 | ***Арга хэмжээ 1.7.9*** Дүүргийн “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-ны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | - | Хяналт тавьсан тоо | 1 | 2 | Дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог 1 удаа хуралдуулж, 2024 онд 3 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг төлөвлөн батлуулж, холбогдох хэлтэст хүргүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллалаа. Өсвөр насны хөвгүүдэд гэмт хэрэг, зөрчлийн талаар болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг өгөх, анхан шатны хууль зүйн мэдлэг олгох зорилгоор “Эдд Мори Консалтинг” хууль зүйн фирмтэй хамтран “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, СУИС-ийн хөгжмийн урлагийн сургуулийн оюутан залууст “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” сургалт зөвлөгөөг зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 10 удаагийн сургалт зөвлөгөөгөөр 1100 хүүхэд залуучуудад хүрч ажилласан. Шүүхийн шийтгэх тогтоол, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдэгдлийн дагуу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан дүүргийн нийт 12 хүүхдэд сургалт нөлөөллийн чиглэлээр сэтгэл зүйчтэй хамтран сургалтын төлөвлөгөө боловсруулж, ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн үйлчилгээг 7 хоног тутам үзүүлсэн. | |
| 51 | ***Арга хэмжээ 1.7.10*** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд багачуудад номын сангийн үйлчилгээг хүргэж ажиллах; | - | Үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо | 20 | 50 | Хүүхэд хөгжлийн цогцолбортой хамтран Magic box явуулын номын сангийн төслийг дүүргийн алслагдсан хороодод хүргэн дэмжин ажиллаж байна. Уг үйл ажиллагааны хүрээнд 7-19 дүгээр хороодын 120 хүүхэд номын сангийн үйлчилгээнд хамрагдсан байна. | 100% |
| 52 | ***Арга хэмжээ 1.7.11*** Дүүргийн алслагдсан хороодод “Явуулын номын сангийн үйлчилгээ”-г хүргэж, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх аяныг зохион байгуулах; | 2.0 Орон нутгийн төсөв | Хамрагдсан хүүхдийн тоо | 100 | 200 | “Ботгохон” явуулын номын сан 7-24 дүгээр хороодод байршин ажиллаж, давхардсан тоогоор нийт 1000 гаруй хүүхэд багачуудад үйлчилсэн. Тус явуулын номын сан нь Монголын уран зохиол, гадаадын уран зохиол, хүүхдийн уран зохиол, түүх, нийгэм, хувь хүний хөгжлийн номуудыг багтаасан 600 гаруй номын фондтойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. | 100% |
| 53 | ***Арга хэмжээ 1.7.12*** Хүүхдийг номтой нөхөрлүүлэхэд чиглэсэн соёл, олон нийтийн ажлыг хуваарийн дагуу | 1.0 Орон нутгийн төсөв | Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо | 350 | 500 | “Мэдлэг олгоё” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад 8 удаа сургалт орж, 338 сурагч хамрагдсан. "Ботгохон" салбар номын сан "Охид хөвгүүдийн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол зохион байгуулах; | | | | | уулзалт" сургалтын хүрээнд "Үе тэнгийн найзаасаа суралцъя" сэдэвтэйгээр, 139-р сургуулийн сурагч Ш.Ану-Үжин "Уран гимнастик"-ийн анхан шатны дасгал хөдөлгөөний мэдлэг олгосон. “Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын авьяасыг нээн хөгжүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх, номыг сонирхолтой аргаар унших аргад суралцуулах, багаар ажиллах, өөрийгөө зөв илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан тус илтгэлийн уралдаанд дүүргийн Ерөнхий боловсролын 10 сургуулийн 50 гаруй сурагчид бүтээлээ ирүүлж, амжилттай оролцлоо. Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 24-р сургуулийн С.Амарзаяа багштай 9ё ангийн 37 сурагчдад Хятадын зохиолч Зян Руны зохиол “ЧОНОН СҮЛД” романыг хэсэгчлэн ярьж тус романаас бүтсэн киног үзүүлж сонирхуулсан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн охидод зориулсан сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, 117, 37, 72, 39-р сургуулийн 30 охин хамрагдсан. “Ботгохон” салбар номын сангийн уншигч охидын дунд Хүний их эмч Ж.Хорлоотой хамтран охидын уулзалтыг зохион байгуулж Чингэлтэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн 117-р сургуулийн 15 сурагч хамрагдсан. | |
| 54 | ***Арга хэмжээ 1.7.13*** Гэр бүлийн хүчирхийллийн гэрч, хохирогчийг дүүргийн “Гэрч хохирогчийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв”-д байрлуулан нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх; | 50.0 Улсын төсөв | Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 24 | 80 | Тайлант хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэрч хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төвд эрэгтэй 79, эмэгтэй 94 буюу 170 хүүхэд, 3 насанд хүрсэн хүнд үйлчилсэн. Дүүргийн хэмжээнд хүүхэд харах үйлчилгээ үзүүлдэг “Боркогийн найзууд” хүүхэд харах төвд 15 хүүхэд, “Монгол холт” хүүхэд харах төвд 5 хүүхэд нийт 20 хүүхэд, 3 хүүхэд харагчийн үйл ажиллагаанд MNS 6540:2015 Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийж шаардлагатай зөвлөмж арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. “Аялгуут өнгөт ертөнцийн хүүхдүүд” төрийн бус байгууллагатай хамтран тус төвөөр үйлчлүүлж буй хүүхдүүдийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх Дуу, бүжиг, хөгжмийн сургалтыг үе шаттайгаар нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байдлаар хүргэн ажиллаж байна. | 100% |
| 55 | ***Арга хэмжээ 1.7.14*** Хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, эрсдэлт нөхцөлд амьдарч буй зорилтот бүлгийн, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх; | 50.0 Улсын төсөв, Орон нутгийн төсөв | Үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо | 250 | 300 | Дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нийт 2 удаа хуралдсан. Шүүхийн тогтоол, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мэдэгдлийн дагуу хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан нийт 17 хүүхдэд сургалт нөлөөллийн чиглэлээр тус хэлтсийн сэтгэл зүйчтэй хамтран сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Үүнээс 3 хүүхдийн шүүхийн шийдвэрээр авагдсан арга хэмжээний хугацаа дууссан бөгөөд одоогоор 14 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Мөн ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн үйлчилгээг 7 хоногт 1 удаа тогтмол үзүүлсэн. Амьдрах ухааны модуль сургалт-12 удаа, Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт-4 удаа, Нийгэм сэтгэл зүй зан үйлийг засах сургалт-10 Хууль зүйн мэдлэг олгох сургалт-7 удаа буюу нийт 54 цагийн сургалтыг зохион байгуулж ажилласан.Хүүхдийн тусламжийн 108 утсанд Дүүргийн хэмжээнд 2024.01.01-2024.11.13-ныг хүртэл нийт 641 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, 582 дуудлага мэдээллийг программд хааж, 61 дуудлага мэдээлэлд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан. Дуудлага хаалтын хэрэгжилтийн хувь 90%-тай байна. 61 дуудлагад кейс нээн хамтарсан багийн хяналтад авч ажилласан. Хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хөрш гурвын холбоо” хяналтыг сайжруулах нь, “Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрт үгүй гэж хэлье”, “Хүчирхийллийг тэвчихгүй хүн байя” зөвлөмж бүхий 200 ширхэг тараах материалыг зах худалдаа, үйлчилгээний төвүүдээр иргэд олон нийтэд түгээсэн. “Ахуйн ослоос урьдчилан сэргийлье”, “Хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулъя”, “Тэжээвэр нохойг уяж байх уриалга” гэх 4 төрлийн зурагт хуудсыг боловсруулан түгээсэн. Өвөр монголын өөртөө засах орны “Халамжийн одон” сайн дурын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагатай хамтран дүүргийн зорилтот бүлгийн 30 хүүхдэд гарын бэлэг хандив өгөх үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. | |
| 56 | ***Арга хэмжээ 1.7.15***<br>Чингэлтэй дүүргийн харьяатай 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст эргэн хяналт тавьж амьдарч буй нөхцөл байдалтай танилцах, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлж түр болон байнгын ажлын байранд холбон зуучлах, МСҮТ болон холбогдох сургалтын төвүүдэд холбон зуучилж мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх; | 2.0 Орон нутгийн төсөв | Хамрагдсан залуучуудын тоо | 2 | 2 | Дүүргийн харьяаллын 18 нас хүрч асрамж халамжийн төвөөс гарч буй залууст асрамж халамжийн дараах үйлчилгээг хүргэх чиглэлээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Асрамж халамжийн 16 байгууллагад Чингэлтэй дүүргийн харьяалалтай 100 хүүхэд үйлчилгээ авч байгаа бөгөөд “Өнөр бүл”, “Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор”, “Хүүхдийн төв сувилал”, “Вербист” хүүхдийн асрамж халамжийн байгууллагад ар гэртээ эргэн нэгтгэх боломжтой хүүхдүүдийн судалгааг нэгтгэн гаргаж, халамжийн үйлчилгээ, гэр бүлд нь эргэн нэгтгэх чиглэлээр тус байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Асрамж халамжийн төвд амьдарч буй дүүргийн хүүхдүүдийн гэр бүлд эргэн хяналт хийх, гэр бүлд нь эргэн нэгтгэх боломжтой эсэхэд үнэлгээ хийх ажлыг 8 дугаар сард зохион байгуулсан. | 100% |
| 57 | ***Арга хэмжээ 1.7.16***<br>Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг судлан, шийдвэрлэж, тэдний эрх | 1.0 Орон нутгийн төсөв | Шийдвэрлэсэн хүсэлтийн хувь | 50% | 100% | Дүүргийн Засаг даргын 2021 оны А/51 дүгээр захирамжаар асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох, хүүхдийн үрчлэлтийн асуудалд хяналт тавих ажлын хэсэг 2024 оны жилийн эцсийн байдлаар 9 удаа хуралдаж 83 захирамжийг гаргуулан ажилласан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж, хяналт тавин ажиллах; | | | | | байна. Асран хамгаалагч тогтоолгосон 15, харгалзан дэмжигч тогтоолгосон 25, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгосон 6, үрчлэлт 31, хүүхдийн мөнгө сэргээсэн 18, хүүхдийн мөнгө зогсоосон 62 байна. | |
| **1.8 ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ** | | | | | | | |
| **1.8 Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 58 | ***Арга хэмжээ 1.8.1*** Дүүргийн хүүхэд, багачуудад зориулсан дугуйлан, секцийн сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах; | - | Дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо | 50 | 60 | Дүүргийн Соёлын төвөөс Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор зохион байгуулагддаг дуу, төгөлдөр хуурын дугуйланд 3, бүжгийн дугуйланд 25, морин хуурын дугуйланд 8, хөөмийн дугуйланд 3, үкүлэлэгийн дугуйланд 8, гитарын дугуйланд 2, төгөлдөр хуурын дугуйланд 3 хүүхэд хамрагдаж байна. Давхардсан тоогоор нийт 49 хүүхэд хамрагдсан. | 100% |
| 59 | ***Арга хэмжээ 1.8.2*** Төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагч, иргэдэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна; | - | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 200 | 250 | Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг 2024 оны 04 сарын 30-аас 05 сарын 10-ны өдрүүдэд дүүргийн 1-24 дүгээр хороодод 10 удаа зохион байгуулсан ба нийт 211 иргэн буюу өрх айлыг хамруулж, 387 гарын авлага тараасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлүүдэд чиглэсэн “Гэр бүлийн харилцаа” сургалтыг дүүргийн Насан туршийн Суралцахуйн төв, 7, 20 дугаар хороотой хамтран зохион байгуулж 40 гаруй иргэн хамрагдсан. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, E-Mongolia Academy УТҮГ, Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар хамтран бүх нийтийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим ур чадварыг дээшлүүлэх, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-н үйлчилгээг сурталчлан таниулах, цахим шилжилтийн бэлэн байдлыг хангах зорилгоор Тусгаар тогтнолын талбайд цахим ур чадварын нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, 500 гаруй иргэд оролцсон. Дэлхийн 90 гаруй улс, 350 гаруй хотыг нэгтгэсэн "Юнеско"-гийн "Бүтээлч хотуудын сүлжээ"-нд нийслэл Улаанбаатар хот нэгдэн орсонтой холбогдуулан, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, 203 хороо, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн дунд зохион байгуулсан "Бүтээл хот" уралдааны чадавхжуулах сургалтыг Нийслэлийн Соёл урлагийн газартай хамтран 2 удаа зохион байгуулж 1-24 хороодын нийгмийн ажилтнуудыг хамруулсан. | |
| 60 | ***Арга хэмжээ 1.8.3***<br>Соёл урлаг, спортын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, иргэдийн оролцоог хангаж ажиллах; | - | Хамрагдсан иргэдийн тоо | 1000 | 1200 | Тулгар төрийн 2233 жил, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний Их баяр наадам, "Үндэсний хувцасны өдөр"-ийг тохиолдуулан "Дээлтэй Монгол наадам-2024" үйл ажиллагаанд дүүргийн 1-24 дүгээр хороодын 1200 гаруй иргэдийг оролцуулж ажилласан. Нийслэлийн төр захиргааны байгууллагаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Даншиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | наадам-Хүрээ цам” шашин соёлын наадмыг 2 өдрийн турш зохион байгуулж, дүүргийн 1-24 дүгээр хороодын 2000 гаруй иргэдийг хамруулж, соёл урлагийн үйлчилгээг үзүүлсэн. Үндэсний бахархал баяр наадмын үйл ажиллагаанд дүүргийн иргэд, гадаад, дотоодын хүндэт зочид, төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлж, үндэсний бахархалт өв соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, 10 ханатай, сийлбэртэй гэр худалдан авч, дүүргийн 1-24 дүгээр хороодын 2000 гаруй иргэдэд үйлчилсэн. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд нийслэлийн 9 дүүрэг, 203 хороо, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн дунд зохион байгуулсан “Бүтээлч хот” уралдаанд оролцож, “ШИЛДЭГ ДҮҮРЭГ”-ээр шалгарсан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Соёлын төв хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Үндэсний өв соёл, ёс заншил, соёлын нандин өв болсон монгол бичгийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сурталчлах, сурагчдын монгол бичгийг сурч, эзэмших, мэдлэгийг дээшлүүлэх зорилготой "Бахархалт монгол бичиг" уралдаан 3 төрлөөр зохион байгуулж, нийт 17 сургуулийн 1200 гаруй сурагчид хамрагдсан. Д.Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын уралдаант наадам”-ын анхан шатны шалгаруулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж ажилласан. | |
| 61 | ***Арга хэмжээ 1.8.4***<br>“Хотын соёл” цуврал контент бий болгож цахим нөлөөллийн аяныг хэрэгжүүлнэ; | - | Арга хэмжээний тоо | 2 | 3 | Дүүргийн түүх, соёлын дурсгалт 18 газрын танилцуулга контент бэлтгэн, Чингэлтэй дүүрэг, Соёлын төвийн цахим хуудсаар түгээж иргэдэд сурталчилж ажилласан. Нийслэлийн Засаг даргын санаачилгаар хоёр дахь жилдээ Сар шинийн баярыг угтан зохион байгуулж байгаа "Амар байна уу 2024" үзэсгэлэн худалдаа “Шинэ 100 айл” худалдааны төвд 2024 оны 01 дүгээр сарын 23-аас 02 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл зохион байгуулагдаж 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дүүргийн уран бүтээлчдийн ардын урлагийн тоглолт толилуулсан. Соёлын төвийн 10 жилийн ойн хүрээнд ахмадын “Дөрвөн цаг” хамтлаг болон Соёлын төвийн уран бүтээлчдийн хамтарсан “Соёлтой Чингэлтэй” уран бүтээлийн тоглолт 2024 оны 03 дугаар сарын 10-аас 17-ны өдрүүдэд 11 удаа тоглогдож, дүүргийн 1-24 дүгээр хороодын нийт 700 гаруй иргэдэд тоглолтоо толилуулсан. Ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийн “Баярлалаа” уран бүтээлийн тоглолт 2024 оны 05 дугаар сарын 10-18-ны өдрүүдэд дүүргийн 1-24 хороодын иргэдэд “Эртэч Чингэлтэйчүүд” арга хэмжээ, “Залуучуудын спорт арга хэмжээ”-ний нээлт, “Хайрхан хөгжлийн төв-1”-ийн “Эрдмийн задгай театр”-т зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж нийт 8000 гаруй иргэдэд тоглолтоо хүргэсэн. Хайрхан хөгжлийн төв-1-ийн Эрдмийн задгай театрт “Залуучуудын спорт арга хэмжээ”-ний үеэр “Open mic” арга хэмжээг зохион байгуулж 50 гаруй хүүхэд залуус оролцлоо. 2024 оны 08 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд “НҮҮДЭЛЧДИЙН ХЭМНЭЛ - ХЭЛ ХУУР МИНУ” сэдвийн дор “ХЭЛ ХУУР ТОГЛОГЧДЫН АНХДУГААР НААДАМ”-ыг Улсын хэмжээнд амжилттай зохион байгуулсан. | |
| **1.9 ЖЕНДЕР** | | | | | | | |
| **1.9 Жендерийн эрх тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Жендерийн салбар хорооны үйл ажиллагааг эрчимжүүлнэ.** | | | | | | | |
| 62 | ***Арга хэмжээ 1.9.1*** Эрэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх жишиг төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ; | 120,0 сая ОУБ-н санхүүжилт /НҮБ/ | Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 200 | 400 | НҮБ-ын санхүүжилтээр дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дэргэд Эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг байгуулсан бөгөөд үйл ажиллагаа амжилттай хэрэгжүүлж байна. “Эрэгтэйчүүд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв” нь нийт 76м2 танхимыг тохижуулан бүлгийн уулзалтын өрөө, ганцаарчилсан өрөө, хүлээлгийн өрөө гэсэн 3 өрөө, 4 сэтгэл зүйчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд 40 иргэнд сургалт, зөвлөгөө өгч ажилласан. | 70% |
| **ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **2.1 САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ: Монгол улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.** | | | | | | | |
| 63 | ***Арга хэмжээ 2.1.1*** Төсвийн орлого, | Дүүргийн татварын | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар, | Улс, нийслэл, | 100% | Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зарлагын төлөвлөлтийг сайжруулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ; | болон татварын бус орлого 220,4 тэрбум төгрөг | орон нутгийн болон нийслэлд төвлөрүүлэх орлогын төсвийн хуваарийн дагуу жигд ханган биелүүлэх | орон нутгийн сарын дундаж биелэлт 70.5%, өссөн дүнгээрээ дундаж биелэлт 99.21% байна., нийслэл, орон нутгийн сарын дундаж биелэлт 70.5%, өссөн дүнгээрээ дундаж биелэлт 99.21% байна. | | өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 23 дугаар зүйл буюу Төсвийн орлогын бүрдэлд өөрчлөлт орж тус өөрчлөлтийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөн ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар өссөн дүнгээр Улсын төсвийн орлого 95,532,301.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 90,555,606.0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 95%, нийслэлийн төсөв 8,720,185.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 9,321,376.0 мянган төгрөг төвлөрүүлж биелэлт 107%, дүүргийн төсөв 233,682,648.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 207,667,154.0 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 89%-тай байна. | |
| 64 | ***Арга хэмжээ 2.1.2*** Дүүргийн төсвийн орлогын төслийг боловсруулах, санал авах, тодотгох, судалгаа тооцоо хийж төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг хэрэгжүүлж ажиллана; | | Төсвийн тухай хуулийн дагуу шаардлага үүссэн тохиолдолд нэмэлт өөрчлөлтийн орлогын дэлгэрэнгүй судалгаа, төлөвлөгөөг боловсруулж, орлогыг | Холбогдох хууль, тооцоо судалгаанд үндэслэн 2024 оны төсвийн төслийг хугацаанд нь боловсру | 100% | Татварын хэлтсээс дүүргийн 2024 оны орлогын санал, тооцоо судалгааг авч нэгтгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 43 дугаар тогтоолоор орлогын хуваарийг боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндэслэлтэй, бодитой төлөвлөсөн байх Чанар: Холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн байна | улсан мөн 2023 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн 12 дугаар, 11 дүгээр сарын 01-ний өдрийн 16 дугаар тогтоолоор тус тус төсвийн орлогод тодотгол хийгдсэн | | | |
| 65 | ***Арга хэмжээ 2.1.3*** Төсвийг төлөвлөх, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад төсвийн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, ил тод, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдлөг болгон ажиллаж, төсөвт байгууллагын төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан. | 100% | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Дүүргийн 2024 оны төсөв батлах тухай” 18 дугаар тогтоолоор баталсан төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хууль, дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийн дагуу орон нутаг болон боловсролын байгууллагуудын 2024 оны төсвийн зарлага, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, Орон нутгийн хөгжлийн сан, төсвийн орлогын сарын хуваарийг боловсруулан Засаг даргын 2024 оны А/07 дугаар захирамжаар батлуулан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урсгал зардалд дүн шинжилгээ хийж, төсвийн үр өгөөжийг сайжруулна; | | | | | өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. | |
| 66 | ***Арга хэмжээ 2.1.4*** Дүүргийн 2024 оны төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулах, санал авах, судалгаа, тооцоо хийж, 2024 оны төсвийн төслийг хуулийн дагуу өргөн барьж, хэлэлцүүлэх, батлуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах; | - | Хуулийн хугацаанд өргөн барьсан байх | 2023 оны дүүргийн төсвийн төслийг хуулийн хугацаанд өргөн барьж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | 2024 оны төсвийн орлого, зарлагын төсвийн төслийг боловсруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байх. | Дүүргийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэж 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 1/1761 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн хянуулж ажилласан. | 100% |
| 67 | ***Арга хэмжээ 2.1.5*** Дүүргийн Орон нутгийн болон Тусгай зориулалтын шилжүүлгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, 2024 оны дүүргийн хагас жилийн нэгтгэсэн тайлан тэнцлийг тус тус гаргаж, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр хянуулж баталгаажуулах, Санхүүгийн нэгтгэсэн 2023 оны тайлан | - | Үйл ажиллагааны хэрэгжилт Аудитын дүгнэлтээр | 2023 оны Чингэлтэй дүүргийн “Санхүүгийн нэгтгэсэн тайлан”-г Нийслэл дэх Төрийн аудитын газраар аудитлуулан ажиллах | 2023 оны Чингэлтэй дүүргийн “Санхүүгийн нэгтгэсэн тайлан”-г Нийслэл дэх Төрийн аудитын газраар аудитлуулан “Өөрчлөлтгүй дүгнэлт” авч ажиллах | Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 718 дугаар тоот Аудитын дүгнэлтээр Чингэлтэй дүүргийн 2023 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан. Тайлант хугацааны хагас жилийн болон жилийн эцсийн байдлаар нийт 85 байгууллагын санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хяналт тавьж нэгтгэн, санхүүгийн нэгтгэсэн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хууль, журамд заасан хугацаанд хүргүүлэн ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэнцлийг Нийслэлийн аудитын газарт өргөн барьж, хуулийн дагуу санхүүгийн тайлангийн аудит хийлгэн дүгнэлт, зөвлөмж гаргуулах ажлыг зохион байгуулах; | | | | | | |
| 68 | ***Арга хэмжээ 2.1.6*** Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжих ажлуудын санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлийг хянан удирдлагыг мэдээллээр хангах; | ДТХО 15,299.3 сая ДТХО он дамжих 20,796.9 сая ДОНХС 1,857.6 сая ДОНХС он дамжих 727.6 сая | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 90% | 90% | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжүүлэх 28 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс: Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 10, бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 15, тендерийн шатандаа байгаа 3 төсөл, арга хэмжээ байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэх 73 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс: Гэрээ байгуулан ажил үргэлжилж байгаа 14, бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 35, тендерийн шатандаа байгаа 11, Гэрээ байгуулах шатандаа байгаа 3, бэлтгэл ажил хийгдэж байгаа 20 төсөл, арга хэмжээ байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023-2024 он дамжин хэрэгжүүлэх 13 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс: бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 10, Тендерийн шатандаа байгаа 3, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэх 25 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс: бүрэн дуусаж хүлээлгэн өгсөн 4, тендерийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шатандаа байгаа 21 төсөл, арга хэмжээ байна. | |
| 69 | ***Арга хэмжээ 2.1.7*** Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудын хагас жил, бүтэн жилийн санхүүгийн тайлан балансыг хүлээн авах, нэгдсэн санхүүгийн тайланг гаргах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах; | - | Нийт байгууллагыг хамруулсан хувиар | 100% | 100% | E-balance: Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг цахим санхүүгийн Е-баланс программаар дүүргийн хэмжээнд 85.7 хувьтай хүлээн авсан.<br>Тайлан хүлээн авалтаар:<br>Нийт тайлан ирүүлэх ёстой–15432 аж ахуйн нэгж, байгууллагаас:<br>Тайлан баталгаажсан-13224 буюу 85.7%<br>Тайлан баталгаажаагүй-2001 буюу 13.0%<br>Тайлан огт гаргаж ирүүлээгүй-207 буюу 1.3%<br>Нийтийн сонирхлын 93 байгууллагын завсрын санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэрийг үндэслэн цахим санхүүгийн программд илгээсэн эхний үлдэгдэлтэй тулган хянаж, баталгаажуулсан. Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагууд болон нийтийн сонирхлын аж ахуйн нэгж, байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан балансыг е-баланс цахим санхүүгийн программаар хүлээн авч, хянаж, баталгаажуулалт хийн ажиллаж байгаа ба тайлан нь алдаатай аудитын байгууллага хүлээн зөвшөөрөөгүй 605 тайланг е-баланс цахим санхүүгийн программ руу өдөр тутам орж, шалган засаж илгээсэн тайланг программ дээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгаажуулан холбогдох байгууллагууд руу холбогдон тайланг засуулан авч баталгаажуулсан.<br>Нийтийн сонирхлын байгууллагуудын дүрмийн сан нэмэгдүүлэх тухай 2024 оны завсрын 97 тайланг Санхүүгийн зохицуулах хорооны даргын тушаал болон тухайн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол шийдвэрийг үндэслэн хугацаанд хянаж, баталгаажуулсан.<br>2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд цахим санхүүгийн программд илгээгээгүй 25-н аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн 11.18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6, 1.25-д заасан заалтаар хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэн торгуулийн арга хэмжээ авч, Төрийн сангийн 100200700956 дансанд 12.4 сая төгрөгийг төвлөрүүлэн хуулийн хугацаанд Прокурорын байгууллагаар хянуулан ажилласан. | |
| 70 | ***Арга хэмжээ 2.1.8***<br>Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн захирагч нарт мэдээлэл хүргэх, санхүү бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинарыг цахим болон танхим хэлбэрээр зохион | | Сургалт, хамрагдсан хүний тоогоор | 2023 онд 1 удаагийн сургалтад давхардсан тоогоор 57 нягтлан бодогчийг хамруулсан. | 100% | Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч болон санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах 2024 оны нэгдсэн сургалтын төлөвлөгөөг батлуулан ажилласан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Е-баланс цахим, санхүүгийн программ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, нягтлан бодогч нарт танхимын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх; | | | | | сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулан нийт 48 хүнийг хамрууллаа. Сургалтаар е-баланс цахим санхүүгийн программ руу аж, ахуйн нэгж, байгууллагуудын захирал болон нягтлан бодогчид хэрхэн холболт хийх, тайлангаа шивж илгээх тухай сургалтыг нэг байгууллагын татвараас авсан захирлын эрх болон нягтлан бодогчийн эрхээр орж бодитоор тайлбарлаж, чиглүүлсэн үр дүнтэй сургалт болсон. | |
| 71 | ***Арга хэмжээ 2.1.9*** Төсөв, санхүүгийн ил тод байдал, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд www.shilendans.gov.mn сайт, дүүргийн цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, төсөвт байгууллагуудын төсөв санхүүгийн мэдээг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд мэдээлэхэд хяналт тавьж ажиллах; | - | Цахим сайтад байршуулсан мэдээний тоо | 100% | 100% | 2024 оны жилийн эцсийн байдлаар *www.shilendans.gov.mn* цахим хуудсанд хариуцсан чиг үүргийн дагуу 7 албан хаагч нийт 145 мэдээ, мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 122 буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100% |
| 72 | ***Арга хэмжээ 2.1.10*** Төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог төрийн сангийн үйл ажиллагааны журам, холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | Төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог санхүүгийн бүрдэл | 100% | "Төсвийн тухай", "Банкны тухай", Татварын багц хууль, Сангийн сайдын 190, 431, 2015 оны 7 дугаар тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам, тэдгээртэй нийцүүлэн гаргасан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | анхан шатны бүрдэл болсон баримтаар зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу хяналт тавин гүйцэтгэх; | | | болсон баримтаар 100 хувь хийж гүйцэтгэсэн | | заавар журмын дагуу төсөвт байгууллагуудын баталгаат гарын үсэг бүхий санхүүгийн бүрдэл болсон баримтаар төлбөр тооцооны мэргэжилтний системд бүртгэсэн төлбөр тооцооны гадаад, дотоод гүйлгээг төлбөрийн хүсэлт, хяналтын хуудсыг үндэслэн он, сар, өдөр, очих банкны код, байгууллагын нэр, дансны дугаар, эдийн засгийн ангилал, хөтөлбөр, зориулалт, мөнгөн дүнг түргэн шуурхай, үнэн зөв алдаагүй шалган баталгаажуулж, төв төрийн санд дамжуулан ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар зарлагын 395.9 тэрбум төгрөгийн нийт 40975 ширхэг гүйлгээ, төлбөр тооцоонд хяналт тавин, гүйлгээг үнэн зөв, алдаагүй шалган баталгаажуулж төв төрийн санд дамжуулан ажилласан. | |
| 73 | ***Арга хэмжээ 2.1.11*** Татварын хэлтсээс ирүүлсэн иргэн аж ахуйн нэгжийн улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт, залруулгын гүйлгээг тухай бүрд нь хийж гүйцэтгэх; | - | Холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн байна | Татварын хэлтсээс ирүүлсэн улсын тэмдэгтийн хураамж буцаан авах нийт иргэн, аж ахуйн нэгжийн 2770 ширхэг 2,915.7 | 100% | Дүүргийн Татварын хэлтсээс ирүүлсэн Улсын тэмдэгтийн хураамж буцаан авах 3142 иргэн, аж ахуй нэгж, байгууллагын нийт 1.9 тэрбум төгрөгийн хүсэлтийг хянан шалгаж, данс бүртгэлтэй материалын 1.9 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээг https://finance.gov.mn/ системд тус бүрд нь шивж буцаан олголтыг цаг тухай бүрд олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сая төгрөгийн гүйлгээг залруулсан болно | | | |
| 74 | ***Арга хэмжээ 2.1.12*** Дүүргийн харьяа төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянан хүлээн авч, дүнг нэгтгэх, дүүргийн орон нутгийн төсвийн орлого, төрийн сангийн орлого, зарлага, өр авлагын дэлгэрэнгүй мэдээг гарган дээд шатны төрийн захиргааны төв байгууллагад хугацаанд нь хүргүүлэх, гүйцэтгэлд нь дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон удирдлагуудыг мэдээллээр хангах; | - | Төсөвт байгууллагын тоогоор | Нийт 71 төсөвт байгууллагуудаас төсвийн гүйцэтгэлийн мэдээг хянан хүлээн авч баталгаажуулан хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн | 100% | Сангийн яамнаас ирүүлсэн мэдээний нэгтгэсэн файлаас Чингэлтэй дүүргийн төсөвт байгууллагуудын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг байгууллага тус бүрээр бүрэн татагдсан эсэхэд хяналт тавьж, тулган Сангийн яамнаас батлагдсан жишиг загварын дагуу Чингэлтэй дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлага, төрийн сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын нэгдсэн тэнцлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон дүүргийн Статистикийн хэлтэст хуулийн хугацаанд нь сар бүрийн 10-ны өдрийн дотор хүргүүлэн ажилласан. | 100% |
| **ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | | | |
| **2.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 75 | ***Арга хэмжээ 2.2.1*** "Чингэлтэйд үйлдвэрлэв-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг | 60.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 5 | 5 | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн дунд зохион байгуулагдсан “Уран үйлчин-2024” оёдлын салбарын уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 02-ноос 07-ны өдөр хүртэлх хугацаанд 3 үе шаттай зохион байгуулж, дүүргийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨТҮГ- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаан ИТХ-д тайлагнаж ажиллана; | | | | | т бүртгэлтэй 870 орчим үйлдвэр эрхлэгч үйл ажиллагаа явуулж байгаагаас 429 үйлдвэр эрхлэгч нь оёдлын салбарт үйл ажиллагаа явуулж, цаашид кластержин хөгжих бололцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй уралдаан болж өндөрлөсөн. Сургалт, өдөрлөг үйл ажиллагааны хүрээнд "Төсөл бичих аргачлал" сургалтад 17 үйлдвэр эрхлэгч, "Энергийн менежмент ба ирээдүйн үр бүтээмжийг нэмэгдүүлэх нь" хувь хүний хөгжлийн сургалтад 27 үйлдвэр эрхлэгч, "Та бол амьдралынхаа гол дүр" хувь хүний хөгжлийн сургалтад 15 үйлдвэр эрхлэгч, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран Улаанбаатар зочид буудлын сургалтын танхимд зохион байгуулж, 55 үйлдвэр эрхлэгч, "Нягтлан бодогчийн мэдлэг олгох" эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох сургалтад 20 иргэн тус тус хамрагдсан."Онлайн бизнес" сэдвээр богино хугацааны ур чадвар олгох сургалтад 30 иргэн, тайлант хугацаанд нийт 9 удаагийн хөгжүүлэх сургалтад хамруулан төслөө хэрхэн бичих, төслийн тооцооллын талаар мэдлэг мэдээлэл олгох, менежментийг сайжруулах чиглэлээр сургалтад нийт 264 үйлдвэр эрхлэгч хамруулсан.<br>Гадаад, дотоод үзэсгэлэн худалдаанд хамрагдсан байдал: Оросын Холбооны Улсын Улан-Үдэ хотноо Буриад Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр "Ид шидийн Цагаан сар-2024"-д 9 иргэн, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | борлуулалт 71,991,000 төгрөг, Ялалтын баярт зориулсан хамтын үзэсгэлэн худалдаанд нийт 8 иргэн, борлуулалт 12,250,000 төгрөг, “Амар байна уу-2024” үзэсгэлэн худалдаа “Шинэ 100 айл” худалдааны төвд 123 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч борлуулалт 760,862,950 төгрөг, “Их хотын бүсгүйчүүд”–д 3 үйлдвэрлэгч-борлуулалт 2,800,000 төгрөг, “МОНГОЛ ГЭР” үзэсгэлэн арга хэмжээнд 5 иргэн, борлуулалт 16,750,000 төгрөг, “Монгол-Оросын хамтарсан Олон Улсын үзэсгэлэн худалдаа”-д 40 иргэн, борлуулалт 13,250,000 төгрөг, "Жаргалтай инээмсэглэл”-2024 үзэсгэлэн худалдаанд 17 үйлдвэрлэгч борлуулалт 7,950,000 төгрөг нийт гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд нийт 885,853.950 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | |
| 76 | ***Арга хэмжээ 2.2.2.*** Нийслэл хотын залуусын дунд үндэсний өв соёл, түүх, ёс заншил агуулсан үндэсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд уриалсан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн нийгэм дэх байр суурийг нэмэгдүүлэх, борлуулалтад эерэг нөлөө үзүүлэх ач холбогдол бүхий | 15.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 60 видео танилцуулгыг цувралаар 2 жилийн хугацаанд хийж жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүн болон байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний давуу талыг олон нийтэд сурталчлан ажилласан. Үүнд:<br>✓ 2022 онд "Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид“ сэдвээр 9 чиглэлийн үйлдвэр эрхлэгчдийн төлөөлөл | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ болон контентын ажлыг хийж гүйцэтгэнэ; | | | | | оролцуулан 50 цуврал видео танилцуулга<br>✓ 2023 онд "Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновац" сэдвээр 10 видео танилцуулгад 30 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг тус тус хамруулсан.<br>Видео танилцуулгууд:<br>Үзэлтийн тоо 52110<br>Хуваалцсан 514<br>Таалагдсан 1236 үзүүлэлттэй байна.<br>Тус видео танилцуулга нь үйлдвэр эрхлэгчдийг гадаад, дотоодын хамтран ажиллагч байгууллага, хувь хүмүүст үйл ажиллагаагаа танилцуулах нэрийн хуудас болсон ба сошиал маркетинг хийх, хэвлэл мэдээлэл олон нийтийн сувгаар цацах, борлуулалтын суваг нэмэгдүүлэх, онлайн захиалгын тоо өсөхөд 20-30 хувийн бодит үр дүнг үзүүлсэн.<br>2024 онд Үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүнийг танилцуулж сурталчлах контент, сэтгүүл бүтээх ажлын хэсэг байгуулан бэлтгэл ажил хангагдаж байна. | |
| 77 | ***Арга хэмжээ 2.2.3.*** Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулж, хөгжүүлнэ; | 20.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Бизнес эрхлэгчдийг бойжуулсан тоо | 10 | 15 | Зөөврийн ажлын байраар хангах хүрээнд зөөврийн ажлын байрны дэмжлэгт хамрагдсан 123 байрнаас 118 байрны үйлдвэрлэгчийн ажлын байраар Ажлын хэсгийн гишүүд хяналт тавин, ажлын байруудыг коджуулан ажилласан ба 12 үйлдвэрлэгчийн гэнэтийн ослын даатгалыг хийлгүүлж ажилласан. Зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаатай 14 үйлдвэрлэгчдэд “Мэдэгдэх хуудас” өгч, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад өргөдөл, хүсэлт ирүүлсэн 7 үйлдвэрлэгчийн хүсэлтийн дагуу, нөхцөл байдлын үнэлгээ хийж, ажлын хэсгийн хурлаар 5 үйлдвэрлэгчийг дэмжин шийдвэрлэж, шилжүүлэн байршуулахаар ажиллаж байна. Нийт 109 зөөврийн ажлын байр хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Хагас жилийн байдлаар хөтөлбөрийн биелэлт 90 хувьтай хэрэгжиж байна.<br>“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны цэг:<br>“Чингэлтэйд үйлдвэрлэв” дэлгүүрт шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн судалгааг хийж, дэлгүүрийн худалдагчидтай 2 удаагийн уулзалт хийж тулгамдаж буй асуудал, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд авах арга хэмжээ, дэлгүүрт бүтээгдэхүүнээ борлуулж буй үйлдвэрлэгчдэд тавигдах шаардлагын талаар санал солилцсон. Тус дэлгүүрийн хагас жилийн борлуулалтын орлого 70.338.500 төгрөг байна.<br>Түрээсийн хөнгөлөлттэй ажлын байраар хангах хүрээнд:<br>Түрээсийн хөнгөлөлттэй ажлын байранд шинээр орохоор хүсэлт гаргасан 4, салбар 3 байрнаас салбар 2 байранд шилжин орох хүсэлтийн ирүүлсний дагуу зөөврийн ба түрээсийн ажлын байранд сонгон шалгаруулалт хийх, хяналт тавих байнгын ажлын хэсгийн гишүүд тухай бүр нөхцөл байдлын үнэлгээ хийж, 3 удаагийн ажлын хэсгийн гишүүдийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурлыг зохион байгуулж, ажлын байрны хүсэлт гаргасан үйлдвэрлэгчдийн өргөдлийг шийдвэрлэн, хариу мэдэгдэж, түрээсийн хөнгөлөлттэй ажлын байрны гэрээг төвийн даргаар баталгаажуулан, гэрээг байгуулж, үйлдвэрлэл эрхлэгчид түрээсийн ажлын байранд орж, үйл ажиллагаагаа явуулж байна. | |
| **2.3 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг дэмжинэ.** | | | | | | | |
| 78 | ***Арга хэмжээ 2.3.1.*** Зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна; | 3.0 Улс, дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 3 | Монголын Тогооч нарын холбооны Ерөнхийлөгчийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Монгол үндэсний хоол, идээ ундааны Улсын аварга тогооч шалгаруулах анхдугаар уралдааны удирдамж”-ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагаас 15 тогооч тус уралдаанд оролцож, туршлага солилцсон.<br>Монголын Ресторан зоогийн газрын холбоо, Баар эрхлэгчдийн холбоо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтарсан Монголд зочлох жил арга хэмжээний хүрээнд зочлох үйлчилгээний салбарын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжилтнүүдийн ур чадварыг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дээшлүүлэх зорилгоор “Олон үндэсний хоолны тогооч бэлтгэх” богино хугацааны сургалтад 2024 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан ажилласан. | |
| 79 | ***Арга хэмжээ 2.3.2.*** Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS4588:2008, Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд ерөнхий шаардлага MNS6043:2009 стандартыг хяналтын хуудасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудлуудад хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, бүртгэл судалгааг сайжруулж, стандартын түвшинд ойртуулна; | 3.0 Улс, дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 3 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран БНСУ-ын Сэжун их сургуулийн зочлох үйлчилгээний мэргэшсэн эксперт багшийг урьж зочлох үйлчилгээний ажиллагсдад зориулсан сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуйн нэгж, байгууллага 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 3 хоногийн хугацаатай хамрагдсан. Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Макс групп” ХХК-ийн “Холидай Инн” зочид буудал ажилтнуудынхаа ур чадварыг дээшлүүлэх, үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүлэх сургалтыг зохион байгуулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх зам талбайг засварлан ашиглалтад оруулан ажилласан байна. | 100% |
| 80 | ***Арга хэмжээ 2.3.3*** Тохирлын гэрчилгээтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээг стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцүүлнэ; | - | Тохирлын гэрчилгээтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо | 20 | 30 | Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн $19^{2.}$.1.1, $19^{2.}$3.2, $19^{2}$.3.3, $19^{2}$.3.6-д заасны дагуу авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд нь тухай үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу үйл ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгох үүрэг хүлээсэн байдаг. Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад авто үйлчилгээний ангиллын хугацаа дууссан болон ангилал тогтоолгоогүй авто үйлчилгээ эрхлэгч 36 иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мэдэгдэл зөвлөмж өгч ажилласан. 2024 оны жилийн эцсийн байдлаар авто үйлчилгээний 9, хоол үйлдвэрлэлийн 11, худалдааны 49, үйлдвэр 2, нийт 71 аж ахуйн нэгж, байгууллага тохирлын гэрчилгээнд хамрагдсан байна. | |
| **2.4 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалангийн бүс нутгийн аймаг, сум, тариалалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | | |
| 81 | ***Арга хэмжээ 2.4.1***<br>Шинэ ургацын төмс, хүнсний ногоо, худалдан борлуулах, мод үр үрслэгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, тариаланч иргэдийг дэмжин ажиллана; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбайд "Мод, бут, сөөгийн суулгац, үр үрслэгээ”-ний үзэсгэлэн худалдааг 2024 оны 06, 10 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 56 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, навчит модны үрслэгээ, мандлын цэцгийн үрсэлгээ, ил талбайн болон хүлэмжийн таримлын ногооны үр, үрсэлгээ зэрэг 60 гаруй нэр төрлийн 120,000 ширхэг мод, бутны үрслэгээ худалдаалсан.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Төмс хүнсний ногооны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, 2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд гарал үүслийн бичиг, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг үндэслэн Сэлэнгэ, Дархан, Өмнөговь, Ховд аймгийн 35 ногоочин иргэдийг хамруулан төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болох "Алтан Намар 2024" арга хэмжээг зохион байгуулж, нийт 77.5 тонн хүнсний ногоо худалдан борлуулж, 300,722,000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | |
| 82 | ***Арга хэмжээ 2.4.2***<br>Ногоо тариалах хүсэлтэй иргэдийг бүлэг үүсгэх замаар төмс, хүнсний ногоо тариалуулж, худаг усжуулалт болон ногоо хадгалах боломжоогоор хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажлын байр бий болгоно; | 10.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Засгийн газраас иргэд, тариаланчдын хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 80 хувийн хөнгөлөлттэй үнээр хүнсний ногооны үр олгосонтой холбогдуулан 10 төрлийн хүнсний ногооны үрийн хуваарийг хүргүүлсний дагуу нийт үнэ болох 225360 төгрөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас гарган шар лууван 1 кг, шар манжин 3 кг, хүрэн манжин 2 кг, урт сонгино 1 кг, байцаа1 уут, ил талбайн хэмх 2 уут, бөөрөнхий сонгины төл үр 1 уут, саримс 10 кг, тарвас 0.1 кг нийт 17.1 кг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй олгох ажлыг 2024 оны 05 дугаар сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 09-ний өдөр 7-24 дүгээр хороодын өрхийн тариалан эрхлэгч 48 иргэнд олгож, зохион байгуулан ажилласан. Үнэ төлбөргүй үр олгосон 48 өрхийн тариаланч иргэдээс 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тариалалтын мэдээг авч 9 төрлийн хүнс ногооны үрийг тариалж, нийт 2.2 тонн ургац хураасан. | |
| 83 | ***Арга хэмжээ 2.4.3*** Өвлийн хүлэмж, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, иргэдийг амин дэмээр баялаг жимс, хүнсний ногоогоор тогтмол хангах боломжийг бүрдүүлнэ; | 15.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Өвлийн хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлсэн тоо | 2 | 2 | Хөгжлийн Шийдэл ТББ-н хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн хүрээнд “Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал”, "Жижиг дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" 2 удаагийн сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо тариалах хүсэлтэй өрхийн тариалан эрхлэгч 12 иргэнийг хамруулан ажилласан. | 70% |
| 84 | ***Арга хэмжээ 2.4.4*** Органик хүнс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг сургалтад хамруулж, зөвлөмж үзүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллана; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 1 | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 118 дугаар тогтоолын дагуу органик хүнсний тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр дүүргийн нутаг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэвсгэрт өрхийн тариалан эрхлэгч, органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 55 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулсан.<br>Олон Улсын Хөгжлийн агентлаг (USAID)-ийн "Жижиг дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" (BEST) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Хөгжлийн Шийдэл ТББ-аас зохион байгуулсан “Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал ба Японы тэргүүн туршлага” сургалтад дүүргийн 18 хорооны "Өрнөх" бүлгийн тэргүүн Ж.Нацагням хамрагдсан. Тус сургалтад хамрагдаж, эзэмшсэн мэдлэгийн хүрээнд “Жамдал мандал” ХХК-г байгуулан, хүнсний ногоог хатааж, боловсруулах үйлдвэрлэл эрхлэн ажиллаж байна. | |
| 85 | ***Арга хэмжээ 2.4.5***<br>Мал, амьтны гоц болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг хамруулж, өвчлөлийг бууруулна; | 10.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Вакцинд хамрагдсан мал амьтны тоогоор | 6500 | 6500 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/07, дүүргийн Засаг даргын 2024 оны А/03 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр, хориглосон бүсэд мал, амьтан орж ирснээр малын халдварт болон гоц халдварт өвчин дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүс нутагт гаргах, эздийг олж тогтоон, хүлээлгэн өгөх, зөрчлийг тухай бүр арилгах зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүртэлх хугацаанд 7 хоногийн 2 өдөр 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хяналт тавьж, нийт 1096 литр шатахуун зарцуулан, 3451 тооны адуу малыг дүүргийн нутаг дэвсгэрээс гарган ажилласан.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/410 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/127 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй гэрийн тэжээвэр амьтдыг халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, туулгалт, боловсруулалт хийх ажлыг дүүргийн мал эмнэлгийн газар болох “Содхан” ХХК-тай хамтран 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 3599 нохой, муурыг вакцинд хамруулан, 7198 мл вакцин зарцуулсан. | |
| **2.5 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшнийг дээшлүүлэх талаар анхаарч ажиллана.** | | | | | | | |
| 86 | ***Арга хэмжээ 2.5.1***<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын чанар хүртээмжийг сайжруулах, зорилгоор худалдаа үйлчилгээний чиглэлээр шинээр гарсан болон дагаж мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудын талаар хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, материал бэлтгэж иргэд, | 6.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 3 | 3 | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох тухай” А/1467 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 186 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 18 нас хүрээгүй иргэнд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аж ахуйн нэгж байгууллагуудад олгоно; | | | | | борлуулахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, захирамжийн хэрэгжилтийг танилцуулан ажилласан.<br>“Онлайн бизнес төв” платформын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-д хэрхэн бүртгүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, бүртгэл үүсгэхэд дэмжлэг үзүүлэн, заавар гарын авлагыг 250 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад, "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам"-ын гарын авлагыг 200 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тараан ажилласан.<br>Техникийн зохицуулалт батлах тухай Засгийн газрын тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор “Мах махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалт” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нийслэлийн Мал эмнэлгийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 171 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулсан. | |
| 87 | ***Арга хэмжээ 2.5.2***<br>Нийслэлийн хүн амын ихээр үйлчлүүлдэг томоохон цэгүүдээс (зах, худалдааны төв, супермаркет) өргөн хэрэглээний бараа | - | Судалгааны давтамж | 52 | 52 | Дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 аж ахуйн нэгж, байгууллагаас гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц болон үнийн нийт 52 удаагийн судалгааг долоо хоног бүрийн баасан гаригт авч, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн судалгааг хийж, үр дүнг боловсруулан, танилцуулан тархаана; | | | | | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Томоохон зах, худалдааны төвөөс авсан гол нэрийн 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийн индекс дунджаар 12.3 хувиар өссөн. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт хэвийн байна. | |
| 88 | ***Арга хэмжээ 2.5.3*** Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн өмчлөлд байгаа халуун усны газруудын үйл ажиллагаа, ашиглалтыг сайжруулах замаар хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын ажил хэрэгжүүлнэ; | 5.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 50% | 70% | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 3/234 дүгээр албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт улс болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр баригдсан нийтийн халуун усны газруудын өмчийн мэдээллийг гарган ирүүлэх хүсэлт илгээсний дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 3/197 дугаартай албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт 6 байршилд нийт 499,842,927.10 төгрөгийн өртөг бүхий нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилгууд бүртгэлтэй байгаа талаар мэдээллийг ирүүлсэн. Дүүргийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8, 10, 14, 17, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах нийтийн халуун усны барилгуудын ашиглалтыг сайжруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2024 оны А/192 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулагдан, шийдвэрлэхээр ажиллаж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 89 | ***Арга хэмжээ 2.5.4***<br>Гэр хорооллын нийтийн ахуйн үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана; | 1.5 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 1 | Дүүргийн гэр хорооллын бүсэд үйл ажиллагаа зогссон 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нийтийн ахуйн үйлчилгээний бичил төвд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсээс нөхцөл байдалтай танилцахад тус нийтийн ахуйн үйлчилгээний төвүүд нь ахуйн үйлчилгээний стандарт хангахгүй, цэвдэгтэй, бохирын шугам хөлдсөн гэх шалтгаанаар үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан. Цаашид зориулалтын дагуу засвар хийж ашиглахад их хэмжээний хөрөнгө шаардлагатай байгаа тул зориулалтыг нь өөрчилж, ашиглалтад оруулахаар дүүргийн Засаг даргын 2024 оны А/192 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулагдан, шийдвэрлэхээр ажиллаж байна. | 70% |
| 90 | ***Арга хэмжээ 2.5.5.***<br>Дүүргийн тэжээвэр амьтадын тооллогыг зохион байгуулах, хяналт мониторинг явуулах, үр дүнг танилцуулах; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Тооллогод хамрагдсан хувь | 100 | 100 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 01 албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/26 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын А/419 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/126 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн мал эмнэлгийн албан хаагчид шувуутай өрхийн судалгааг шинэчлэн гаргаж, 48 өрхийн шувууны байр, орчин 1920 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, мал амьтны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдварт, гоц халдварт өвчний талаар сэрэмжлүүлэн зөвлөмж хүргүүлсэн.<br>Мах хадгалах зоорь агуулах, заал лангуу орчин 1600 м2, мах ангилан худалдаалах, бууз, банш цех 800 м2, дайвар бүтээгдэхүүн ангилал, толгой шийр хуйхлах цэг 400 м2, нийтийн эзэмшил, мал амьтны гаралтай түүхий эдийн хаягдал, сэг зэм 600 м2, талбайд цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг холбогдох журам зааврын дагуу хийж нийт 5320 м2 талбайг хайкоф 1:2000, сүперкелл 1:1000 уусмалаар автомаксаар шүрших, хлорын шохойн бэлдмэлээр хуурай цацаж ариутгаж халдваргүйжүүлсэн.<br>Дүүргийн Статистикийн хэлтэстэй хамтран 2024 оны 08 дугаар сард дүүргийн тэжээвэр амьтны тооллогыг зохион байгуулж нохой 6240, муур 280, тахиа 361 тоологдсон байна., | |
| 91 | ***Арга хэмжээ 2.5.6.***<br>Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид холбогдох дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт, шалгалт зохион байгуулж сургалтад хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана; | 1.25 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалтын удирдамж”-ын дагуу нийслэлийн Нийтийн тээврийн газар, Ус сувгийн удирдах газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран 2024 оны 04 дүгээр сарын 09-15-ний хооронд дүүргийн нутаг нутаг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэвсгэрт авто угаалгын чиглэлээр 28 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 угаалга саарал усны тоног төхөөрөмж ашиглаж, 2 авто угаалга түр хугацаанд ажиллахгүй, 8 авто угаалга зөөврийн ус ашиглаж байна. УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээтэй 14, ОСНААУГ-тай гэрээтэй 1, цэвэр ус, бохир ус зөөврөөр хэрэглэдэг 6, нийт 21 авто угаалгын газарт хяналт шалгалт хийв. Хэрэглэсэн усаа цэвэршүүлэн дахин ашиглах тоног төхөөрөмжтэй 3 машин угаалга байна. Хяналт шалгалтын үр дүнд 4 авто угаалгын хаягийн зөрчил арилгуулж, 6 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ангиллын гэрчилгээ, онлайн бизнес төвд бүртгүүлэн ажилласан. | |
| 92 | ***Арга хэмжээ 2.5.7***<br>Худалдаа, нийтийн хоолны салбарт тавигдах стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт шалгалт, мэргэжил арга зүйн удирдлагаар байгууллагуудыг хангаж ажиллана; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 3 | 3 | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт баар/тайчих клубийн чиглэлээр 9, алжаал тайлах төвийн чиглэлээр 11 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтаар хүнсний аюулгүй байдал хангаагүй 3 аж ахуйн нэгжид тус бүр 3000 нэгж буюу нийт 9,000,000 төгрөгийн шийтгэл оногдуулан хэргийн материалыг прокурорт хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явуулдаг буюу согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт ирүүлсэн нийт 364 хуулийн этгээдэд стандартын хэрэгжилтийг хангуулахад хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 42 иргэн, аж ахуйн нэгжид нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран “Гадна орчны тохижилт”, “Орчны аюулгүй байдал” сэдвээр 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр сургалт зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Сургалт зохион байгуулах тухай” удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлага болох 161 албан хаагчдад “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандарт, шим тэжээлийн байдал, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдээллийг өгөх, хоолны цэс төлөвлөлт, технологийн картыг хоол үйлдвэрлэлд нэвтрүүлэх сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 26-ний өдөр зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2024 оны "Хяналт, шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай" А/289 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгаа төрийн болон төрийн бус өмчийн 20 сургууль, 37 цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, хүнсний эрүүл ахуй, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 93 | ***Арга хэмжээ 2.5.8*** Хүнсний худалдаа, үйлдвэр үйлчилгээний газруудад Хүнсний аюулгүй байдал, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний сонголт, эрүүл ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх нь” салбарын сургалт зохион байгуулна; | 3.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 1 | "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас хэвлүүлсэн "Хүнсний хувьсгал №4" сэтгүүлийг дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тарааж ажилласан. Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлага болох нийт 90 албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын хүрээнд “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандарт, шим тэжээлийн байдал, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдээлэл, хоолны цэс төлөвлөлт, технологийн картыг хоол үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. “Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн зохистой дадал, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүнсний түүхий эд бүтээгдэхүүний сонголт" сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нийслэлийн Мал эмнэлгийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 171 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулсан. | |
| **БАРИЛГА , ХОТ БАЙГУУЛАЛТ** | | | | | | | |
| **Зорилт 2.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч дэд бүтэц, тохижилт, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.** | | | | | | | |
| 94 | ***Арга хэмжээ 2.6.1.*** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч хөтөчтэй явган замыг нэмэгдүүлнэ; | 20 | Хийгдсэн хөтөч хавтангийн м2-аар | 56500 | 60000 | Дүүргийн хэмжээнд 136 у/км явган зам байгаа бөгөөд арчилгаа хамгаалалт засварыг дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байна. Гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн явган зам барих чиглэлийн дагуу 3000м2 хөтөчтэй явган зам байгуулахаар судалгааг гарган Нийслэлийн Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн бөгөөд 2 компани шалгаран явган зам зогсоолын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1, 4, 6, 7, 10, 12, 16, 18, 20 дугаар хороодод 480м2 явган замын ажил хийгдээд байна. | 100% |
| **Зорилт 2.7 Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааны чанар болон тогтолцоог боловсронгуй болгож, олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 95 | ***Арга хэмжээ 2.7.1*** Сууц өмчлөгчдийн холбоод, нийтийн аж ахуйн чиглэлийн үйл ажиллагааны чанар | 0.01 | Аргазүйн зөвлөгөө СӨХ-д өгсөн тоон үзүүлэлтээр | 2023 оны үзлэг шалгалта ар хангалтта | Дүүргийн 50 СӨХ-дод түвшин тогтоох | 2023 оны Түвшин тогтоох үзлэг шалгалт 2023 оны 11 дүгээр сарын 29-12 дугаар сарын 20-ны өдөр хийгдэж дууссан. 2024 оны түвшин тогтоох үзлэг шалгалт хийх удирдамж | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор түвшин тогтоох шалгалт зохион байгуулж үнэлгээ өгч ажиллана; | | | й үнэлэгдсэн. | үзлэг шалгалт явуулна | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөлөөс ирүүлээгүй байна. | |
| 96 | **Арга хэмжээ 2.7.2** Олон жилийн насжилттай орон сууцны барилгуудын дулаан алдагдлыг бууруулна; | 2.000.0 | Орон сууцны байруудын дээвэр, фасад засварын ажлын тоогоор | Дээвэр-6 Фасад-2 | Дээвэр засвар-6 фасад засвар-2 | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд 1-6, 15 дугаар хороодод 11 дээвэр, 3 фасад засвар хийхээр “Интел хаитек” ХХК “Буян нэмэх интер” ХХК-ны түншлэл хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд хийж гүйцэтгэхээр “Эс эм би эм” ХХК шалгарч 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулсан. Мөн 2024 онд 1-6 дугаар хороодод 7 байрны дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэхээр дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 4 удаа тендер зарлагдаж тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна. Зураг, төсвийн ажил: 1-р хороо 3 байрны дээвэр, 3-р хороо 1 байрны дээвэр, 5-р хороо 3 байрны дээвэр засварын зураг, төсвийг "Гранд тех" ХХК хийж гүйцэтгэж хүлээлгэж өгсөн. 2-р хорооны 4 байр, 6-р хорооны 10 байрны дээвэр засварын зураг, төсвийг "ММ архитектур" ХХК, 5-р хорооны 9 байр, 6-р хороо 11 байрны фасад засварын зураг төсвийг "Тэмжин" ХХК, 1-р хороо фасад засварын зураг төсвийг “Онч тэнхлэг” ХХК хийж гүйцэтгэж байна. 2, 3, 4-р | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооны 19 байрны фасад засварын зураг, төсвийн ажил тендер зарлагдсан. | |
| **Зорилт 2.8 Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж хэвийн найдвартай ажиллагааг хангана.** | | | | | | | |
| 97 | ***Арга хэмжээ 2.8.1.*** Орон сууцны барилгуудын ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна; | 50.0 | Орон сууцны засварын ажлын тоогоор | Засварлах шаардлагатай 15 байр | | Мянгат СӨХ, Ногоон нуур СӨХ, Мандах өргөө СӨХ-д сууц өмчлөгчдийн холбооны хуримтлалаар орон сууцны дотор шугамын хэсэгчилсэн засвар үйлчилгээг 2024 оны 08 дугаар сард хийж гүйцэтгэсэн. | 100% |
| **Зорилт 2.9 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж нэгдсэн удирдлага-хяналтын системд холбож, "Жишиг гудамж"-уудын тоог гэр хороололд нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 98 | **Арга хэмжээ 2.9.1.** Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ; | 208 | Хийгдсэн гэрэлтүүлгийн тоо | 11709 | 11809 | Хороод, иргэдээс ирүүлсэн өргөдөл, албан бичгийг үндэслэн дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр "Соён дрийм" ХХК хувьсгалчид, дэнжийн мянга, далан давхар, хайлааст чингэлтэй холбосон зам, зүрх уулийн төв зам дагуух 240 гэрэлтүүлгийн 250 ватт днат гэрлийг 150 ватт лед гэрлээр сольж шинэчлэх ажил болон 1-4, 9-12, 15-24 дүгээр хороодод 124 ширхэг гэрэлтүүлгийг шинээр хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан. 11, 19-р хороо, Чингэлтэй хайрхны ам, дэд станцын трансформатор, тоноглол шинээр сольж засварласан. 18-р хорооны дахин төлөвлөлтийн байршлаас буусан 51 шонг гэрэлтүүлгийн толгой, кабелийг шинэчлэн 24-р хороо Яргайтын амны төв зам дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжүүлэх ажлыг “Соён дрийм” ХХК хийж гүйцэтгэсэн. Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 13-р хорооны 40 ш эрчим хүчний шон дээр байрласан днат гэрэлтүүлгийг лед гэрэлтүүлгээр сольж шинэчилсэн. | |
| **Зорилт 2.10 Үерийн далан суваг, борооны ус болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, сэргээн засварлах, гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган зам, шат, гүүр барьж иргэдийн амьдрах орчныг сайжруулна.** | | | | | | | |
| 99 | **Арга хэмжээ 2.10.1** Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээг шинээр барьж, өргөтгөн шинэчилж, сэргээн засварлана; | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Өргөтгөн шинэчилсэн, сэргээн засварласан, шинээр барьсан борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний тоо хэмжээ | 13,3 км | 13,9 км | Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Гүн нуурын арын жалга, Хайлаастын гудамжинд далан барих” төсөл, арга хэмжээг “Вектор ус дриллинг” ХХК хэрэгжүүлэн 200 у/м үерийн хамгаалалтын далан барих болон хамгаалалтын хашлага суурилуулах ажлыг хийж гүйцэтгэн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр комисс ажиллуулж нийслэлийн Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-т байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Нийслэлийн Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-аас тус дүүргийн 13 дугаар хорооны Хайлаастын үерийн хамгаалалтын 350 у/м даланг шинэчлэн засварлаж, 130 у/м авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээг шинээр хийж гүйцэтгэсэн. Мөн 14 дүгээр хороо, 5 буудал орчим (14-р хорооны байрны урд талд)-д 92 у/м авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлыг шинээр хийж гүйцэтгэж, 1 дүгээр хороо, Улсын их дэлгүүрийн зүүн талын явган гарцын ус зайлуулах 5 у/м | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэмтсэн хуванцар хоолойг шинэчлэн сольж, 24 дүгээр хороо, Санзайн авто зам, Ар согоотын автобусны буудал орчимд нийт 560 у/м авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээг хийж гүйцэтгэсэн. Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сервис центрийн бохирын байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм” төсөл, арга хэмжээг “Төрөлх мөрөн” ХХК хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд авто замын доогуурх сүвэлгээ, 53 у/м шугам хоолойн сувагчлалын ажил болон хөрсний усыг хүлээж авах тунгаагуур хүртэлх /Баянгол дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэр/ 500мм диаметрийн 330 у/м хөрсний ус зайлуулах шүүрүүлийн шугам хоолойн ажил, нийт 383 у/м шугам хоолойн ажил хийж гүйцэтгээд байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "8 дугаар хорооны хөрсний ус зайлуулах, шүүрүүлэх байгууламжийн ажил" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 3 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Уг төсөл арга хэмжээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 100 | **Арга хэмжээ 2.10.2** Гэр хороодын гуу жалга бүхий газруудад шат, гүүрэн байгууламж барих, сэргээн засварлах; | 270.0 | Гүүрэн байгууламж, шатны тоогоор | 58 гүүрэн байгууламж, 22 шаттай | 59 гүүрэн байгууламж, 23 шаттай | Дүүргийн Ерөнхий боловсролын 149 дүгээр сургуулийн урд талд 95 у/м явган хүний зам бүхий шатны ажил хийгдсэн. Дүүргийн 17 дугаар хороо, Сурагчийн 47-59 дүгээр гудамжийг холбосон 15.5 у/м явган хүний гүүрэн байгууламжийг дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-аас хийж гүйцэтгэсэн. | 100% |
| 101 | **Арга хэмжээ 2.10.3** Төмөр бетон гүүрний байгууламжийг шинээр барьж, өргөтгөж, шинэчилнэ; | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Гүүрэн байгууламжийн тоогоор | Төмөр бетон 14 ширхэг авто гүүрэн байгууламжтай | Төмөр бетон 15 ширхэг авто гүүрэн байгууламж | “Дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх 250м автозам, гүүрний ажлын зураг” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр авто зам замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг нийслэлийн Замын хөгжлийн газарт хүссэн. "17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто зам, гүүр" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 3 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Уг төсөл, арга хэмжээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон. Дүүргийн 19 дүгээр хороо, Ерөнхий боловсролын 117 дугаар сургуулийн зүүн талд, Доод салхитын 11 дүгээр гудамжнаас Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Дамбадаржаа 81 дүгээр гудамж хүртэлх төмөр бетон гүүрэн | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууламжийн ажлыг “ЗМЗ” ХХК хийж гүйцэтгэн ажиллаж байна. | |
| **Зорилт 2.11 Хөрсний ус зайлуулах шугам сүлжээг хотын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан шинээр барих болон өргөтгөн шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 102 | **Арга хэмжээ 2.11.1** 8 дугаар хорооны хөрсний ус зайлуулах, шүүрүүлэх байгууламжийн ажил; | 621.3 | Хөрсний ус зайлуулах шугам сүлжээг нэмэгдүүлэх | - | Хөрсний ус зайлуулах шугам сүлжээг 100 у/м-с багагүй хэмжээгээр нэмэгдүүлэх | Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх "8 дугаар хорооны хөрсний ус зайлуулах, шүүрүүлэх байгууламжийн ажил" төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн дүүргийн Худалдан авах ажиллагааны албаас 3 удаа худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Уг төсөл арга хэмжээг Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон. | - |
| **Зорилт 2.12 Инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.** | | | | | | | |
| 103 | ***Арга хэмжээ 2.12.1*** 16 дугаар хороо, Согоотын 26, 40 дүгээр гудамжны айл өрхийг цэвэр, бохир усны шугамд холбох ажлын зураг төсөв; | 60.2 | Зураг төсвийн гүйцэтгэлийн хувь | - | Зураг төсвийг гүйцэтгэн хүлээж авсан байх | "Хайдро дизайн прожект" ХХК-ний боловсруулсан "Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо, Согоот 26-40 дүгээр гудамжны айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөв"-ийг 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс актаар хүлээж авсан. | 100% |
| **Зорилт 2.13 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлж, өндөр хөгжилтэй орнуудын хогны менежментээс туршлага судлан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 104 | **Арга хэмжээ 2.13.1** Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, | 11.000 | Тээвэрлэсэн хог хаягдал тонн, рейс, цэвэрлэсэн талбайн м2 | 29,667 рейс 176,033 | Хог хаягдлын хэмжээг бууруулна. | “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-иуд дүүргийн 1-24 дүгээр хороодод хог хаягдал, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэрлэлтийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, UCS 1706A Барилгын хог хаягдлын менежмент стандартын хүрээнд барилгын хог хаягдлыг ачиж цуглуулах, тээвэрлэх ажлыг хэрэгжүүлнэ; | | | тонн хог хаягдал | | эрчимжүүлэн тогтмол ажиллаж байна. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-иуд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 83250 удаагийн давтамжтай 358950 тонн хог хаягдлыг тээвэрлэн ажилласан Мөн Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн менежмент (УБАХХЦТМ) төсөл нь 2019 оны 4-р сараас эхлэн манай дүүрэгт маш амжилттайгаар хэрэгжээд байна. Дүүргийн 7, 12 дугаар хороонд хэрэгжүүлж буй бөгөөд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах зориулалттай хашаанд суурилуулах хогийн савыг нийт 500 айлд, үүсмэл хог байнга төвлөрдөг, үүсмэл хог үүсдэг цэгүүдэд нарны эрчим хүчээр ажилладаг зөөврийн зориулалттай камерыг нийт 16 байршилд тус тус суурилуулаад байна. Мөн 7 болон 12 дугаар хороонд оршин суугч иргэдийн хог ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, дахин боловсруулах боломжтой дахиврыг иргэдээс худалдан авах, иргэд хог хаягдлын талаар мэдлэг олгох сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор "Recycle shop" цэгийг хороо тус бүрд нэгийг байгуулаад байгаа ба ажил бүрэн хэрэгжиж дууссан. | |
| **Зорилт 2.14 Дүүргийн хэмжээнд золбин муур, нохой устгалын ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулах.** | | | | | | | |
| 105 | ***Арга хэмжээ 2.14.1*** | - | Устгасан нохойны тоо | Сард дунджаар | Золбин нохойны | Хот нийтийн аж ахуйн зарим ажил 2024 оны 03 дугаар сараас эхлэн дүүргүүдэд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Золбин нохой устгалын ажлыг гүйцэтгэгч компанитай хамтран үе шаттай зохион байгуулах; | | | нийт 40-50 золбин нохой устгах | тоог бууруулна. | шилжин ирсэнтэй холбогдуулан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт "Их булаг А ТҮҮК" ХХК-ний гэрээг сунган дүүргийн нутаг дэвсгэрт батлагдсан хуваарийн дагуу нохой усгалын ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 9484 золбин нохойг устгаад байна. | |
| **Зорилт 2.15 Дүүргийн хэмжээнд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг үе шаттай хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 106 | ***Арга хэмжээ 2.15.1*** Нийтийн эзэмшлийн гудам зам талбай, хороодын ажлын байр, төрийн өмчит сургууль цэцэрлэгүүдэд ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан ажиллах; | 200.0 | Ариутгал хийгдсэн талбайн хэмжээ м2 | Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ААНБ, СӨХ, нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, эрсдэл бүхий цэгүүдэд ариутгалын ажлыг зохион байгуулан ажиллах | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | Зуны улиралд бороо ихээр орж хөрс бохирдсон Чингэлтэй дүүргийн 10, 16, 17, 18, 24 дүгээр хороодын нутаг дэвсгэрийн үерт автсан байршлууд болох нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гуу жалга, далан суваг, айл өрхийн бохирдсон нүхэн жорлонгуудад нийт 535569 $м^2$ талбайд ариутгал халдваргүйтгэлийг 2024 оны 05, 08 дугаар сарууддад агаар мананцраар 6 техник хэрэгсэл, 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн. Мөн 2024 оны 10 дугаар сард зохион байгуулсан Орон нутгийн сонгуулийн хэсгийн хороодод ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулсан . | 100% |

| Зорилт 2.16 Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ. | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | ***Арга хэмжээ 2.16.1*** Орон сууц, гэр хорооллын дунд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай, бичил цэцэрлэг, явган болон дугуйн зам барьж, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлнэ. Шинээр хийгдэх тохижилтын ажлуудад шинэлэг санаа, инновац шингээсэн тохижилтын ажил тоглоомын талбайнуудыг шинээр бий болгох. Хотын стандартын газраас гаргасан UCS 1405B хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлагын дагуу тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэх; | 200,0 | Нийт нэмэгдсэн бичил цэцэрлэг, тохижилтын ажлын тоогоор | 76 | 80 | Дүүргийн хэмжээнд одоогийн байдлаар 84 бичил цэцэрлэг, сагсан бөмбөгийн талбай байгаа бөгөөд арчилгаа хамгаалалтыг дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ажиллаж байна. 2024 онд дүүргийн төсвийн хөрөнгөөр 5 бичил цэцэрлэг байгуулахаар ажиллаж байна. Гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн тохижилтын ажил хийх чиглэлийн дагуу Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 6 бичил цэцэрлэг засварын ажил хийж гүйцэтгэхээр тендер зарлан компаниуд шалгаран ажлыг эхлүүлээд байна. Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн тоглоомын талбайн стандартын хэрэгжилтийг хангах засварын ажлын хүрээнд 84 бичил цэцэрлэгээс 15 тоглоомын талбайд хүүхдэд аюултай хашаа хайс засварлах, эвдрэлтэй тоглоомыг солих, гагнуурын ажлууд хийгдээд байна. "Зуршлаас Хэвшил рүү" аяны хүрээнд хөдөлгөөнт амьдралыг хэвшил болгохоор зорилт тавин Бичил Глобус санхүүгийн байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд 9 байршилд "Унадаг дугуйн зогсоол" байршуулсан ба ЧД Ялалтын талбай, 5-р сургууль, Соёл урлагийн их сургууль, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, Өглөөний гудамж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн, Баянбүрд орчим, 24-р сургууль, Компьютер ланд төв зэрэгт тус тус байршууллаа. | |
| **Зорилт 2.17 Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах үүднээс нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 108 | ***Арга хэмжээ 2.17.1*** Нийтийн тээврээр зорчигчдын ая тухтай байдлыг хангах үүднээс нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолуудыг саравч бүхий тохилог орчинтой болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ; | Улс, нийслэл, дүүрэг, Олон улсын зээл, тусламжийн төсөв | Автобусны буудлын тохижилтыг нэмэгдүүлэх | Сүүдрэвч бүхий тохижилттой 54 автобусны буудал | Сүүдрэвч бүхий тохижилт 64 автобусны буудалтай байна. | "149 дүгээр сургуулийн урд талын авто зам, авто зогсоол, автобусны буудал" төсөл арга хэмжээг "Нано экологи" ХХК хэрэгжүүлэн 80 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. "19 дүгээр хорооны автобусны эцсийн буудлын тохижилт" төсөл арга хэмжээг "Нано экологи" ХХК хэрэгжүүлэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 17, 18, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт дулаан зогсоолын 2 байгууламж, сүүдрэвч бүхий задгай зогсоолын 16 байгууламжийг "Таван од" ХХК тус тус хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. | 100% |
| **Зорилт 2.18 Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, автозамын дэд бүтцийг сайжруулна.** | | | | | | | |
| 109 | ***Арга хэмжээ 2.18.1*** Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, автозамын дэд бүтцийг сайжруулна; | 6,393.0 | Хийгдсэн авто замын байгууламжийн урт | 149.6 км | 152.1 км | "17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто зам, гүүр" төсөл, арга хэмжээ, "Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо Хайлаастын гудамжнаас 246-р цэцэрлэг хүртэлх автозам", "Биеийн тамир, спорт хорооноос Дэнжийн 1000-н авто зам хүртэлх автозам", "Баянбүрдийн тойргийн орчим Нандин бизнес төвийн баруун тал М ойл ШТС-ын зүүн талд автозам" төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөсөн ч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2024 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 30 дугаар тогтоолоор хасагдсан тул хэрэгжих боломжгүй болсон. "Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо, Хайлааст-Чингэлтэй холбосон авто замаас 37 дугаар сургууль хүртэлх автозам" төсөл, арга хэмжээний Авто зам замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг Нийслэлийн Замын хөгжлийн газарт хүссэн. "Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Дээд салхит 10 дугаар гудамжны автозам"-240108033 дугаартай, "Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Тахилт 2 дугаар гудамжны автозам"- 240108034 дугаартай Авто зам замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг тус тус дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн. "5 дугаар сургуулийн уулзвараас Их сургуулийн гудамж хүртэлх авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт" ажлын хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, 5 дугаар сургуулийн уулзвараас Сүхбаатарын гудамж хүртэлх 250 у/м, "Зоос гоёл”-ын уулзвараас СУИС-ийн уулзвар хүртэлх авто замын засвар, шинэчлэлт" ажлын хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Хүнсний 1 дүгээр дэлгүүрийн уулзвараас Соёл урлагийн их сургуулийн уулзвар хүртэлх 560 у/м, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Цэцэг төвийн уулзвараас Цаг уур, орчны шинжилгээний газрын уулзвар хүртэлх авто замын засвар, шинэчлэлт" ажлын хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Хүнсний 1 дүгээр дэлгүүрийн уулзвараас Соёл урлагийн их сургуулийн уулзвар хүртэлх 340 у/м авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг нийслэлийн Замын хөгжлийн газраас тус тус хийж гүйцэтгэсэн. | |
| **Зорилт 2.19 Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг үе шаттай судалж, хэрэгжүүлнэ** | | | | | | | |
| 110 | ***Арга хэмжээ 2.19.1*** Эрчим хүчний хүчдэлийн уналттай болон цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг цахилгаанаар хангах ажлыг судалж, мэргэжлийн байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ; | Улс, нийслэл, дүүргийн төсөв | Цахилгаан эрчим хүчинд холбох, эрчим хүчний хүчдэлийн уналтыг бууруулах | 4743 өрхийн хүчдэл сайжирсан | 100 айл өрх | "Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил" төсөл арга хэмжээний хүрээнд 19, 23, 24 дүгээр хороодын 860 айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчинд холбох, эрчим хүчний уналтыг бууруулахаар шинэчлэн сайжруулсан цахилгааны шугамд холбох ажлыг “УБЦТС” ТӨХК-ний Зуслан хэрэглэгчдэд үйлчлэх төвөөс хийж гүйцэтгэн ажиллаж байна. Дүүргийн 20 дугаар хороо, Хувьсгалчдын Г 18 дугаар гудамжны 87 айл өрх нь цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон шон /тулгуур/, тоолуурын нэгдсэн хайрцаггүйн улмаас цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ 200 метрээс багагүй зайнаас авах, айл өрхөөс салаалан авах зэргээр хангаж байгаа тул дээрх айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах, эрчим хүчний уналтыг бууруулах тухай 3/1240 тоот албан бичгийг “УБЦТС” ТӨХК-д | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн. Мөн дүүргийн 22 дугаар хороо, Согоотын 90 дүгээр гудамжны 20 гаруй айл өрх цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдоогүй байгаа тул тус айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбоход дэмжлэг үзүүлэх тухай 3/1991 тоот албан бичгийг "УБЦТС" ТӨХК-д хүргүүлсэн. | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО БЭХЖҮҮЛЭХ /БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД/** | | | | | | | |
| **Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | |
| **Зорилт 3.1 Төрийн албаны үйл ажиллагаа, бүтээмж, чанарын удирдлагын нэгдсэн систем, хяналт хариуцлагын тогтолцоог шинэ шатанд гаргаж, төрийн албан хаагчийн ажиллах орчин нийгмийн баталгааг хангах зорилготой "Хүний нөөц, нийгмийн баталгаа 2024" арга хэмжээг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 111 | ***Арга хэмжээ 3.1.1*** Хүний нөөцийг хөгжүүлж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр үе шаттай сургалтыг зохион байгуулна; | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Давхардсан тоогоор 1100 | Давхардсан тоогоор 800-аас доошгүй | Ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор 2024 онд дараах сургалтуудад дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг хамруулсан.<br>1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс сар бүр зохион байгуулдаг захиалгат сургалтуудад ЗДТГ-н албан хаагчдыг тогтмол хамруулж байна.<br>2.Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалт"-д Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчийг, дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагчийг хамруулсан.<br>3.Удирдлагын академиас зохион байгуулсан "Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт" 16 цагийн цахим, танхим | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хосолсон сургалтад ЗДТГ-н 2 албан хаагч<br>4.Удирдлагын академиас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” 16 цагийн танхимын сургалтад Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн<br>5. Удирдлагын академиас зохион байгуулсан “Удирдах арга барил” богино хугацааны сургалтад ЗДТГ-н 3 албан хаагч<br>6.Авлигатай тэмцэх газраас эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтад Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтнийг<br>7.Нийслэлийн Архивын газар болон Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран зохион байгуулсан “Монгол бичгээр баримт бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад Архивын хэлтсийн 3 албан хаагч<br>8. Удирдлагын академиас “Төрийн албан хаагчийг чадавхжуулах нь: Хүний нөөцийн удирдлага” 40 цагийн сургалтад Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн<br>9.Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, тулгарч буй асуудал шийдэл” сэдэвт сургалтад Тамгын газрын 1 албан хаагч<br>10.ЗГХЭГ, БНСУ-н Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Төрийн захиргааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалтад 2 албан хаагч<br>11.НЗДТГ-ын Мэдээллийн технологийн газрын “Мэдээлэл холбооны салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага” сэдэвт сургалтад 1 албан хаагчийг хамруулсан. | |
| 112 | ***Арга хэмжээ 3.1.2***<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрт хамруулна; | - | Батлагдсан хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо | 20 | 20 | 2024 оны байдлаар “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу гэр бүлийн гишүүний болон өөрийн эмчилгээний зардалд 8 албан хаагчид 41,178,000 төгрөг, албан хаагч өөрөө болон гэр бүл, төрөл садны хүн нас барахад 11 албан хаагчид 108,060,000 төгрөг, амаржсан 9 албан хаагчид 8,967,522 төгрөг, шинээр гэр бүл болсон 5 албан хаагчид 5,240,912 төгрөг, сургалтын зардалд 2 албан хаагчид 5,356,000 төгрөгийг олгосон. | 100% |
| 113 | ***Арга хэмжээ 3.1.3***<br>Ёс зүйн болон сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтан, албан хаагчдад цахим болон ажлын байран дахь сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна; | - | Сургалтад хамрагдсан ажилтан, албан хаагчдын хувь, Ёс зүйн болон сахилгын зөрчлийн тоон мэдээ | - | Ёс зүйн болон сахилгын зөрчлийн тоо буурсан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасантай холбоотой 9 өргөдөл, гомдол ирсэн ба холбогдох албан хаагчид сонсох ажиллагаа явуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлж, хариу тайлбарыг авч сонсох ажиллагааг хийсэн. Хорооны 5 албан хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулж, хорооны 2 Засаг даргад цалингийн 20 хувь бууруулах арга хэмжээг авч, Тамгын газрын нийт 2 албан хаагчдад цалингийн хувь бууруулах арга хэмжээг тус тус авч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | ***Арга хэмжээ 3.1.4*** Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэг бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлж, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна; | - | Урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо,ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчдын тоо | 120 | 120 | 2024 оны жилийн эцсийн байдлаар Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэх үүрэг бүхий нийт 50 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж ажилласан. | 100% |
| **Зорилт 3.2 Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, дүүргийн хөгжлийн талаарх үр ашигтай санал, санаачилгыг дэмжиж ажиллана.** | | | | | | | |
| 115 | ***Арга хэмжээ 3.2.1*** Нийслэл, дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг, даалгаврыг холбогдох хэлтэс, албадад хүргүүлэн, хэрэгжилтийг тухай бүр тооцно; | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 90% | 90% | Тайлант хугацаанд 23 удаагийн Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн 169 үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс албадад хүргүүлж, биелэлтийг хугацаанд нь нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хянуулж, нэгтгэлийг ub.erp системд байршуулан хүргүүллээ. Үүнээс:<br>-100%-ийн биелэлттэй 95 үүрэг даалгавар<br>-90%-ийн биелэлттэй 4 үүрэг даалгавар<br>-70%-ийн биелэлттэй 59 үүрэг даалгавар<br>-30%-ийн биелэлттэй 11 үүрэг даалгавар<br>Дундаж үнэлгээ 84.4%-ийн гүйцэтгэлтэй байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 116 | ***Арга хэмжээ 3.2.2*** Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны эхний хагас жил болон жилийн эцсийн тайлан, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ; | - | Биелэлтийг нэгтгэж, НЗДТГ-т хүргүүлсэн тоо | 2 | 2 | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бодлого, 219 арга хэмжээ тусгагдсан. 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох хэлтэс албадаас нэгтгэн авч Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр үнэлгээ хийлгэн 88.2%-тай үнэлэгдсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг авч Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэхээр нэгтгэн ажиллаж байна. | 100% |
| 117 | ***Арга хэмжээ 3.2.3*** Байгууллагад e.doc нэгдсэн системээр болон цаасаар ирсэн албан бичгийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд бүртгэж шилжүүлнэ; | - | Ирсэн албан бичгийн тоо | 5100 | 5200 | Дүүргийн Засаг даргын Тамгын газарт Edoc.ub.gov.mn нэгдсэн системээр нийт ирсэн 5605, үүнээс: хариутай 340 албан бичиг ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 320, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 20 албан бичиг байна. Хариугүй албан бичиг 5265 ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 5198, хугацаа хоцроож шийдвэрлэсэн 13, зөрчил тооцогдсон 15, судлагдаж байгаа 39 албан бичиг тус тус байна. Албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 5.34 (хоногоор) байна. | 100% |
| 118 | ***Арга хэмжээ 3.2.4*** Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын явуулсан албан бичгийн стандарт, бүрдлийг шалгаж, нэгдсэн систем болон бичгээр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ; | - | E-doc систем, болон бичгээр холбогдох байгууллага, мэргэжилтэнд шилжүүлсэн албан бичгийн тоо | 1750 | 2800 | Дотоодод боловсруулсан-2661 албан бичгээс хариутай-221, хариугүй-2440 байгаагаас Хугацаа хэтэрч хариу ирүүлсэн-0, шийдвэрлэх шатандаа-0 албан бичиг байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 119 | ***Арга хэмжээ 3.2.5*** Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, байгууллагад хөтлөгдөж байгаа баримт бичиг стандартын дагуу үнэн зөв хөтлөгдөж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана; | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 удаагийн давтамжтай 84 албан хаагчдад | 2 удаагийн давтамжтай 84 албан хаагчдад | Мэдээллийн цаг арга хэмжээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу нийт 6 удаагийн мэдээллийн цагаар албан хаагчдад сургалт хийж, мэдээ мэдээлэл болон чиглэл өгч ажилласан. | 100% |
| 120 | ***Арга хэмжээ 3.2.6*** Иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, зөрчлийн тоон үзүүлэлтийг бууруулна; | - | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хугацаа, зөрчлийн тоон үзүүлэлт буурсан хувь | 8 хоног, зөрчлийн тоон үзүүлэлт 53 хувиар буурсан. | 7 хоног, 20 хувиар бууруулна. | Чингэлтэй дүүргийн 2024 оны 04 дүгээр улирлын үйл ажиллагааны хүрээнд 3451 өргөдөл гомдол ирснээс 3308 гомдол, хүсэлт буюу 96 хувийг эцэслэн шийдвэрлэж, 143 гомдол хүсэлт судлагдаж байна. Иргэдийн гомдол хүсэлтийг шийдвэрлэх явцад 760 зөрчил тооцогдсон ба энэ нь өмнөх оны мөн үед 607 байсан ба харьцуулахад 153 зөрчил буюу 20.1 хувиар өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын зөрчил тооцогдсон хэлтэс, тасгийн дарга нарт цаашид анхаарч, хариуцлагатай байх чиглэлийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга мэдэгдсэн. Мөн иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2023 онд 08 хоног 08 цаг 46 минут байсан бол 2024 онд 10 хоног 07 цаг 25 минут болж 01 хоног 23 цаг 39 минутаар өссөн байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | ***Арга хэмжээ 3.2.7*** Дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэж, холбогдох дээд байгууллагад хүргүүлнэ; | - | Биелэлтийн үнэлгээний хувь | 90% | 100% | 2024 оны үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын албан даалгавар, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн ИТХ-ын зарим тогтоол, дүүргийн ИТХ-ын тогтоолын биелэлтийг нэгтгэж, удирдлагад танилцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн бөгөөд 2024 оны 1, 2 дугаар сарын тогтоол шийдвэрийн биелэлтийг дээд шатны байгууллагын хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан. Мөн Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2020-2024 оны тайланг өссөн дүнгээр холбогдох байгууллагуудаас нэгтгэн удирдлагад танилцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн. | 100% |
| 122 | ***Арга хэмжээ 3.2.8*** Төрийн дээд одон медаль, Засгийн газар, яамд, дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, материалыг холбогдох байгууллагад уламжилна; | - | Хүргүүлсэн материалын тоо | Төрийн дээд одон медаль-539, Засгийн газрын шагнал 120, Дүүргийн засаг даргын шагнал-521 | 800 | Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулах болзол хангаж, байгууллага, хамт олноос тодорхойлж ирүүлсэн саналыг дэмжин<br>-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай” 26 дугаар тогтоолоор 171;<br>-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дугаар сарын 26-ны өдрийн “Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай” 33 дугаар тогтоолоор 134;<br>-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн цол, одон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | медалиар шагнуулахаар уламжлах тухай” 33 дугаар тогтоолоор 76;<br>-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн “Төрийн цол, одон медалиар шагнуулахаар уламжлах тухай” 103 дугаар тогтоолоор 103 нийт 484 иргэд, албан хаагчид шагналын болзол ханган батлуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ын дагуу дүүргийн нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжээс Засгийн газрын болон яамдын шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжин тайлант хугацаанд ХХААХҮЯ-95, ЗТХЯ-6, СЯ-25, ЭМЯ-4, БХБЯ-1, ХЗЯ-1, ХНХЯ-12, НЗД-ын шагналд 16 иргэн, албан хаагч нийт 160 иргэн, албан хаагчдын холбогдох материалыг холбогдох дээд шатны байгууллагад албан бичгээр хүргүүлснээс 120 иргэний шагнал дэмжигдсэн. Үүнээс: Сангийн яам, Барилга хот байгуулалтын яам, Зам тээвэр хөгжлийн яамны шагналын материалуудыг тус байгууллагын шагналын программд шивэлт хийсэн. | |
| 123 | ***Арга хэмжээ 3.2.9***<br>Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлыг зохион байгуулна; | - | Хуралдааны тоо | 2 удаа зохион байгуулсан. | 2-с доошгүй удаа | Дүүргийн Засаг даргын А/241 дүгээр захирамжаар Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Дүүргийн Засаг даргын Зөвлөлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулна. | ээлжит хуралдаан тайлант хугацаанд 7 удаа зохион байгуулагдсан ба хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хэлтэс, албадаас авч нэгтгэн тайлагнасан. | |
| 124 | ***Арга хэмжээ 3.2.10*** Дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Нэг цонхны үйлчилгээ"-ээр төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж, иргэдэд мэдээ мэдээллийг хүргэнэ; | - | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | 67225 | 67500 | Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 383927 үйлчилгээ үзүүлснээс иргэний 283173, эд хөрөнгийн эрхийн 51686, хуулийн этгээдийн 49068 үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлэх, цахим орчинд үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Хурдан киоск, Улсын бүртгэлийн ДӨТ машинаар 15156, 24/7 үйлчилгээгээр 12656, Гадаад паспорт захиалах цахим машинаар 324, E-Mongolia портал сайтаар 1200, E-Business сайтаар 9758 улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, үйлчилгээний хураамжийг улсын бүртгэлийн цэгүүдэд байрших Гэрэгэ киоск, гэрэгэ пос машинаар түргэн шуурхай шийдвэрлэж, нийт үйлчилгээний 70% гаруй нь цахимаар төлөгдсөн. Иргэдэд цахим тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд 150 гаруй байгууллагатай хамтран мөн тооны арга хэмжээнд оролцож 55041 иргэнд тоон гарын үсэг олгосон. | 100% |
| 125 | ***Арга хэмжээ 3.2.11*** Дүүргийн 1-24 дүгээр хороодын нэг цонхны үйлчилгээгээр иргэдэд төрийн анхан шатны үйлчилгээг тасралтгүй хүргэнэ; | - | Үйлчлүүлсэн иргэдийн тоо | Үйлчлүүлсэн иргэдийн тоо 69640 | 67500 | Дүүргийн 1-24 дүгээр хороодын нэг цэгийн үйлчилгээгээр нийт 35224 иргэн үйлчлүүлсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай үзүүлэх "20 минутын хот" бодлогын хүрээнд 1-24 дүгээр хороонд төрийн "ХУРДАН" үйлчилгээ нэвтэрч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хороодын зохион байгуулагч нар операторын горимоор ажиллаж байгаа бөгөөд "ГЭРЭГЭ", "ХУРДАН" киоск хороо бүрд ажиллан иргэдэд үйлчилгээ үзүүлснээр түгжрэл, төвлөрөл, хүнд суртал, зардал чирэгдэл буурах, хаанаас ч ойрхон, хурдан шуурхай төрийн үйлчилгээ авах бөгөөд төрийн 43 байгууллагын 478 төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн ажилласан. | |
| **Зорилт 3.3 Засаг захиргааны анхан шатны нэгж хороог бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.** | | | | | | | |
| 126 | ***Арга хэмжээ 3.3.1*** Засаг захиргааны анхан шатны нэгжид төр засгийн хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Засгийн газар, нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж хамтран ажиллана; | - | Хууль тогтоомж бодлого шийдвэрийг хэрэгжүүлсэн хувь | 50% | 50% | Төр засгийн бодлого шийдвэрийг анхан шатны нэгжид хүргэх чиглэлээр дээд шатны байгууллагаас ирүүлсэн 282 албан бичгийг судлан, хороодын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 63 албан бичгийг боловсруулж, 1-24 дүгээр хороодод албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцон ажилласан. Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хороодын үйл ажиллагаа, ажлын цаг ашиглалт, хүнд сурталтай холбоотой 12 өргөдөл, гомдол ирснээс өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн иргэнд хариуг хүргүүлэн ажилласан. Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг дарга, ЗДТГ-ын даргаас 1-24 дүгээр хороодын "Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөн"-ийг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нийт 11 удаа танхимаар, 5 удаа цахимаар /zoom/ зохион байгуулж давхардсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоогоор 400 албан хаагчид оролцож хурлаас гарсан санал, хүсэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, тайлан илтгэх хуудсыг тухай бүр хүлээн авч, нэгтгэн тайлагнасан. | |
| 127 | ***Арга хэмжээ 3.3.2*** Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хороодын олон талт арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах; | Цалин хөлс | Олон талт арга хэмжээ зохион байгуулсан хөтөлбөр удирдамжийн тоо | 85 | 48 | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21, 22, 28, 29, 30, 32, 33 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн хүрээнд анхан шатны нэгж хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр дүүргийн 1-24 дүгээр хороодод 241,000,000 төгрөгийн санхүүжилттэйгээр 95 ажил, арга хэмжээг иргэдэд зохион байгуулах зардлыг олгуулсан. | 100% |
| 128 | ***Арга хэмжээ 3.3.3*** Дүүргийн 1-24 дүгээр хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах, харилцан туршлага судлуулах ажлыг зохион байгуулах; | - | Үйл ажиллагаанд хамруулсан хувиар | 90% | 100% | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 цахим сургалтад Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлогын талаар” сургалтад 20 хорооны зохион байгуулагчийг цахимаар, “Хүүхэд хамгааллын тухай” хуулийн цахим ур чадвар сургалтад 6, “Архив, арга хэрэг хөтлөлт”-ийн сургалтад 8, “Хууль эрх зүй, төрийн албан хаагчийн хариуцах ажил үйлчилгээ, асуудал шийдвэрлэх арга зам” сургалтад 2, “Нийслэлийн түүх, нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц” сургалтад 10 ажилтныг тус тус танхимаар хамруулсан. ISO чанарын менежментийн сургалтад 10,18, 22 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар хороодын Засаг дарга, зохион байгуулагчдыг 1 удаа, Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын сургалтад 14 ажилтныг тус тус хамруулсан. | |
| 129 | ***Арга хэмжээ 3.3.4*** Засаг захиргааны анхан шатны нэгжээс иргэдэд үзүүлж буй үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх замаар төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд ойртуулах, шинэ соёл, стандартыг 1-24 дүгээр хороодод хэрэгжүүлэх; | - | Цахим системээр үйлчилгээ үзүүлсэн тоо, хувь | 90% | 100% | Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ая тухтай үзүүлэх “20 минутын хот” бодлогын хүрээнд дүүргийн 1 давхрын “Нэг цонхны үйлчилгээ”–ний танхимын үйл ажиллагааг хэвийн явуулж, 1-24 дүгээр хороодод төрийн “ХУРДАН “үйлчилгээ нэвтэрч хороодын зохион байгуулагч нар операторын горимоор ажиллаж байгаа бөгөөд “ГЭРЭГЭ”, “ХУРДАН” киоск хороо бүрд ажиллан иргэдэд үйлчилгээ үзүүлснээр түгжрэл, төвлөрөл, хүнд суртал, зардал чирэгдэл буурах, хаанаас ч ойрхон, хурдан шуурхай төрийн үйлчилгээ авах бодитой нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээг анхан шатны нэгжээс үзүүлж буй хэсгийн ахлагч нарын үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх замаар чадавхжуулах, иргэдэд төрөөс үзүүлж буй үйлчилгээг ойртуулах, үйлчилгээний шинэ соёл, стандартыг бий болгох зорилготой “Хэсгийн ахлагчийн систем”-ийг 1-24 дүгээр хороодод нэвтрүүлж нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системд 1-24 дүгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хороодын 218 хэсгийн ахлагч нарын хандах эрхийн тохиргоог хийн 2025 оныг дуустал хугацаанд дата эрхтэй, сүлжээндээ үнэ төлбөргүй ярих эрх бүхий албан утасны дугаарыг “Юнител” ХХК-тэй гэрээ байгуулан 16,940,000 төгрөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын зардлаас санхүүжүүлэн хэсгийн ахлагч нарт олгож, байгууллагын нэр дээр бүртгэн ажилласан. Хэсгийн ахлагч нарын цахим системд 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын 01-06 дугаар сард хийгдсэн ажлын тайлан болон мэдээ, мэдээлэл оруулж, хороодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлан ажилласан. | |
| 130 | ***Арга хэмжээ 3.3.5*** Дүүргийн 1-24 дүгээр хороодын 220 хэсгийн ахлагч нартай “Хөлсөөр ажиллах гэрээ”-г байгуулан, хагас, бүтэн жилээр дүгнэж, урамшууллыг олгох; | - | Урамшуулал олгосон хэсгийн ахлагчдын тоо | 214 | 220 | Дүүргийн 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын 1-11 дүгээр сарын урамшууллыг болон жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, “Хөлсөөр ажиллах гэрээ”-г дүгнэхдээ нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 37 дугаар тогтоолын “Хэсгийн ахлагч нарын ажиллах журам”, “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний шалгуур үзүүлэлтийн дагуу хороодын Засаг дарга нарын үнэлгээг харгалзан хэсгийн ахлагч нарт урамшууллыг зохих ёсоор бүрэн олгосон. | 100% |
| **Зорилт 3.4 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангаж, цахим засаглалыг хөгжүүлнэ.** | | | | | | | |
| 131 | ***Арга хэмжээ 3.4.1*** Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн | - | Мэдээний тоо | 5-аас доошгүй | 10-аас доошгүй | Дүүргийн *http://www.chingeltei.gov.mn/* цахим хуудасны “Хүний нөөцийн ил тод байдал” цэсэд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 32 дугаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг болон Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлын талаарх мэдээллийг дүүргийн цахим хуудсанд байршуулна; | | | | | тогтоолоор батлагдсан “Хүний нөөц, нийгмийн баталгаа-2024” арга хэмжээ, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль, байгууллагын 2024 онд зохион байгуулагдах сургалтын нэгдсэн төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журмыг, 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр дүүргийн 1-24 дүгээр хороодын нийт 10 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 1-24 дүгээр хороодын нийт 15 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг байршуулан ажилласан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г байршуулан ажилласан. | |
| 132 | **Арга хэмжээ 3.4.2** Дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээ бичиж | - | Мэдээний тоо | 959 | 1000-аас дээш | Тайланд хугацаанд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх цаг үеийн мэдээлэл, өдөр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, дүүргийн албан ёсны сайт /www.chingeltei .gov.mn/ цахим хуудас /Chingeltei district/ /Чингэлтэй Дүүргийн Онцгой комисс/ цахим хуудаснуудад байршуулна; | | | | | тутмын мэдээ зөвлөмжийг *Чингэлтэй дүүрэг Chingeltei District* цахим хуудас, "дүүргийн онцгой комисс"-ын цахим хаяг, *Chingeltei.gov.mn вэб* сайтад үнэн бодит мэдээллийг цаг алдалгүй хүргэн ажилласан. Дөрөвдүгээр улирлын тайлан буюу 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл: "Чингэлтэй дүүрэг, Chingeltei District цахим хуудсан дахь мэдээллийг тухай бүр шинэчлэн 753 удаагийн цагаан мэдээ оруулснаас 94489 хандалт авсан байна. Үүнээс: ХМОНХТ 715 мэдээг бэлтгэж, нийслэлийн мэдээ 85 хуваалцаж, бусад 35 мэдээ иргэдэд хүрчээ. Нийт мэдээлэлд 11225 эерэг сэтгэгдэл, 35 сөрөг сэтгэгдэл, 38184 удаа таалагдаж, мэдээг 15947 хуваалцсан байна | |
| 133 | ***Арга хэмжээ. 3.4.3*** Дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зураг авалт, видео дүрс бичлэгийг хийж баримтжуулах; | - | Баримтжуулсан тоо | 29 | 30-аас дээш | Дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааны зураг авалт, дүрс бичлэгийг хийж 118 дүрс бичлэг цахим хуудсанд оруулж, 118 дүрс бичлэгийг баримтжуулж ажиллалаа. Үүнд: Дүүргийн Ногоон бүсийг сурталчлан таниулах тухай дүрс бичлэг 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарын танилцуулга бүхий дүрс бичлэг, ногоон бүс төслийг танилцуулах үеийн дүрс бичлэг, Олон улсын хөтөлбөр болох "Стийм", "монтессори", "ай эм брик" хөтөлбөрүүдийг иргэдэд таниулах агуулга бүхий дүрс бичлэгийг дүүргийн СӨББ-ын 38 цэцэрлэгийг авч дүүргийн цахим хаягт байршуулан ажилласан. Камерын хяналтын нэгдсэн төвийг ЦЕГ-ын удирдлагуудад үйл ажиллагаа танилцуулах үеийн дүрс бичлэг авч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | архивлаж ажилласан байна. Дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэлийн 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд биелэгдсэн ажлуудыг богино бичлэг хийж иргэдэд сурталчлав. 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэгт татлага, дүүргийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй барьсан авто гараашнуудын буулгалтын үеийн зураг бичлэг хийсэн байна. Хууль эрх зүйн хэлтсийн эрх зүйн хөтөч булан цуврал контент нэвтрүүлгийг бэлтгэн дүүргийн цахим хуудсанд байршуулсан. Мөн Эртэч чингэлтэй, Улаанбаатар марафон, Цэвэрлэгээг хэвшил болгоё, хаврын их цэвэрлэгээ, хүүхдийн баяр, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөний дүрс бичлэгийг авч ажиллалаа. Дүүргийн нийтийн эзэмшлийн талбай, явган хүний зам, авто замын цуврал контент бэлтгэсэн. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд дүрс бичлэг болон зураг авч, мэдээ бэлтгэн оруулсан. Засаг дарга дүүргийн ахмадуудтай уулзах уулзалт, 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нартай уулзах уулзалт, дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай уулзах уулзалтуудыг баримтжуулан дүрс бичлэг, зураг авч ажилласан. Мөн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, явган хүний зам, зөвшөөрөлгүй баригдсан объект, эрүүл мэндийн төвийн баригдаж буй барилгын ажлын явцтай дүүргийн удирдлагууд танилцаж буй дүрс бичлэгийг авч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн цахим хуудсанд байршуулсан. | |
| 134 | ***Арга хэмжээ 3.4.5*** УИХ-ын ээлжит сонгууль, нийслэл, дүүргийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагааны зураг авалт, видео дүрс бичлэгийг хийж баримтжуулах; | - | Баримтжуулсан тоо | 0 | 10-аас дээш | Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, албадын албан хаагчдад Сонгуулийн Ерөнхий хорооноос Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуульд сонгуулийн тойрог, тойрогт ноогдох мандатын тоо, E-electicon системийн талаар дүүргийн мэдээлэл технологийн даамлууд болон хэсгийн хорооны ажилчдад сургалт явуулан мэдээ бэлтгэн, зураг авч ажилласан. | 100% |
| 135 | ***Арга хэмжээ 3.4.6*** Дүүргийн удирдлагууд орчны тохижилт, бүтээн байгуулалт бусад ажлуудтай танилцах үед дагалдан явах хэвлэл мэдээллийн байгууллагуудыг зохион байгуулж мэдээллээр хангаж ажиллах; | - | Мэдээний тоо | 483 | 500-аас дээш | Тайлант хугацаанд 504 хурал уулзалт, дүүргээс өрнүүлж буй аян, өдөр тутмын үйл ажиллагааны гэрэл зураг авч мэдээ бэлтгэн дүүргийн “Чингэлтэй дүүрэг” цахим хуудсанд оруулж ажилласан байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн Жендерийн салбар хорооны 2024 оны анхдугаар хуралдаан, дүүргийн Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны 15 хуралдааны зураг мэдээ, сар шинийн баярыг угтаж дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээний зураг мэдээ, дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Чингэлтэй лиг” сагсан бөмбөгийн тэмцээний зураг мэдээ, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Лхагвасүрэн дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга болон ажлын албаны хүмүүсийг хүлээн авч уулзсан мэдээ, дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагч нартай гэрээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан мэдээ, Нийслэлийг бүсчилж хөгжүүлэх асуудлаар Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Чингэлтэй дүүргийн Хайлааст орчмын хороодод ажилладаг төрийн албан хаагчидтай уулзсан уулзалтын мэдээ, дүүргийн хэлтэс албад, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудтай уулзалтын мэдээ, 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага, Эртэч Чингэлтэй арга хэмжээ, дүүргийн 1-24 дүгээр хороодод төрийн цахим үйлчилгээний “Хурдан” төв нээгдсэн мэдээ, цас цэвэрлэгээний мэдээ, Тамгын газраас зохион байгуулж буй спорт тэмцээнүүдийн нээлт, хаалтын зураг мэдээ, 2024 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага, ЕБС-ийн хүүхдийн найрал дууны уралдаан, Бахархалт монгол бичиг, 23, 37 дугаар сургуулийн биеийн тамирын заалны талаарх мэдээ мэдээлэл, Намрын бүх нийтийн их цэвэрлэгээний мэдээ, Чингэлтэй дүүрэг, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан мэдээ мэдээлэл гээд өдөр тутмын үйл ажиллагаанд мэдээ бэлтгэн ажиллаж байна. | |
| 136 | ***Арга хэмжээ 3.4.7*** Тоон гарын үсэг ашиглаж цахим албан хэрэг хөтлөлтийг хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлнэ; | | Тоон гарын үсгийн ашиглалт, хувиар | 90% | Дүүргийн харьяа нутгийн захиргаан ы байгууллаг уудын баримт | Дүүргийн хэмжээнд нэгдсэн систем ашигладаг 106 байгууллагын эрх бүхий 121 албан тушаалтан Edoc нэгдсэн системд тоон гарын үсгээр баталгаажсан баримт солилцож байна. Дүүргийн Засаг даргын Тамгын газар 17, хороо 14, нийт 31 албан тушаалтан шинээр Ньюкомпасс, Тридум кэй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичиг солилцоонд баримт боловсруулалт, тоон гарын үсгийг хэрэглээг 95 хувьд хүргэж, ашиглалтыг сайжруулах | компаниудтай гэрээ байгуулан гэрчилгээ авсан. | |
| 137 | ***Арга хэмжээ 3.4.8*** Архивын сан хөмрөгийг түүх, эрдэм шинжилгээний ач холбогдолтой бүх төрлийн баримт, эх сурвалжаар нөхөн баяжуулах; | | Нөхөн баяжуулалт хийсэн байгууллагын тоогоор | 3 байгууллагын 248 хадгаламжийн баяжилт хийсэн. | 1.Үндсэн эх үүсвэрийн 36 байгууллагын нөхөн баяжилт хийх. | Дүүргийн архивд нөхөн баяжилт хийх хуваарийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 03/76 дугаар албан бичгээр 36 байгууллагад хүргүүлсэн бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн дүүргийн Архивын дэргэдэх БНШАЗК-ийн 1 дүгээр хурлаар 1-24 дүгээр хороодын данс, бүртгэл, жагсаалтыг хэлэлцэн 12 хорооны данс бүртгэлийг баталж хүргүүлэн хуваарийн дагуу 16 хорооны 2014-2021 оны 814 хадгаламжийн нэгжийн 40175 хуудас баримтыг Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 3 дугаар зүйлийн 3.28 дахь заалтын дагуу акт үйлдэн хүлээн авч мэргэжил, арга зүйн удирдлагаар хангасан. | 100% |
| 138 | ***Арга хэмжээ 3.4.9*** | - | Нөхөн баяжилт хийсэн | 98 байгуулл | 2.Дүүргийн хөмрөг | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Засаг даргын эрхлэх хүрээний байгууллагуудын захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн баяжилт хийх; | | байгууллага, баримтын тоогоор | агын 204 хадгаламжийн нэгжийн 10,953 баримтын 18,021 хуудас баримтыг цахимжуулсан. | үүсгэгч байгууллагын 2023 оны үйл ажиллагааны, архивын системд холбосон баримтыг батлан шалгаж, актаар хүлээн авах. | Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Архивын газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлт хийх хуваарь”-ийн дагуу *https://arch.ulaanbaatar.mn/* программын Archive eDoc” системд оруулсан дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын 101 байгууллагын 208 хадгаламжийн нэгжийн 10463 баримтын 17364 хуудас баримтад батлан шалгалт хийж гүйцэтгэсэн. | |
| **ГАДААД ХАРИЛЦАА** | | | | | | | |
| **Зорилт 3.5 Дэлхийн улс орнуудын Нийслэл, дүүрэг болон хотуудтай хамтын ажиллагаа тогтоох, аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулан ажиллана.** | | | | | | | |
| 139 | ***Арга хэмжээ 3.5.1*** Дүүрэгтэй хамтын ажиллагаа бүхий гадаадын улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинээр хамтын ажиллагаа тогтооно; | - | Хамтын ажиллагаа тогтоосон улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагын тоо | Санамж бичиг байгуулсан хот-1 | Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна. | Тайлант хугацаанд Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх зорилгоор 2022 оны 08 дугаар сарын 17-ны өдөр тус дүүргийн Засаг дарга Н.Батсүмбэрэл, Яйзү хотын Засаг дарга Накано Хиромичи нар цаашид илүү олон салбарт хамтран ажиллахаар Харилцан ойлголцлын санамж бичигт байгуулсан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Грийн эмнэлэгтэй 2024 оны 02 сарын 05-ны өдөр Улаанбаатар хотод хамтын ажиллагааны Санамж бичгийг байгуулсан. 2024 оны 03 сарын 28-ны өдөр Япон Улсын Шизуока мужийн Яйзү хоттой байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийг Япон Улсад өргөжүүлэн байгуулав. 2024 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 06 сарын 04-ний өдөр Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотын Бусанжин дүүрэгтэй 2016 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийг Улаанбаатар хотод шинэчлэн байгуулав. БНХАУ, БНСВУ, БНТУ зэрэг улсуудтай жижиг дунд үйлдвэрлэл, гадаад худалдаа, соёл, спорт, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах талаар идэвхтэй харилцан ажиллаж байна. Мөн бусад хамтын ажиллагаатай улс, дүүрэгтэй байнгын харилцаа холбоотой ажиллаж байгаа бөгөөд оюутан, сурагч солилцоо, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих болон эрүүл мэнд, байгаль орчин, ногоон байгууламж, бусад чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан санал солилцон ажиллаж байна. | |
| 140 | ***Арга хэмжээ 3.5.2*** Гадаадын хот, дүүрэг, олон улсын байгууллага, элчин сайдын яамд, дотоодын аймаг, сумд, компанитай, хамтран ажиллах гэрээ хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулна; | - | Гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн тоо Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Нийт 2 санамж бичиг, хамтран ажиллах гэрээ-5 | Хамтран ажиллах гэрээ хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан байна. | 2024 онд нийт 7 гадаадын хот, дүүрэг, Олон улсын байгууллага болон дотоодын байгууллагатай хамтран ажиллах харилцан ойлголцлын Санамж бичгийг шинээр байгуулж, төсөл хөтөлбөрийг боловсруулан тухайн орны хэл дээр орчуулсан. Мөн дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажлын хүрээнд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% |
| 141 | ***Арга хэмжээ 3.5.3*** Гадаадын хот, дүүрэг, олон улсын байгууллага, дотоодын аймаг, сумд, | - | Батлуулсан хөтөлбөр, | 7 удаагийн айлчлалы | Бэлтгэл ажлыг хангаж гадаадын | Холимог тулааны спортыг хөгжүүлэх зорилгоор тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монголын Холимог тулааны холбоотой хамтын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | компанийн Чингэлтэй дүүрэгт айлчлал хийх, зочлох төлөөлөгчдийг хүлээн авах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулах, бэлтгэл ажил болон зохион байгуулалтыг хангана; | | төлөвлөгөөний тоо | г хүлээн авсан | зочид төлөөлөгчд ийг тухай бүр хүлээн авсан байна. | ажиллагааны Санамж бичгийг байгуулав. Мөн дүүргийн иргэдийн амьдрах орчны чанар, нөхцөлийг дээшлүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зорилгоор “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны Санамж бичгийг байгуулав. | |
| 142 | ***Арга хэмжээ 3.5.5*** Хамтын ажиллагаатай улс, хот, дүүргүүдэд айлчлал хийх, томилолтоор ажиллах, хурал уулзалтад оролцох, туршлага судлах ажилтан, албан хаагчдын айлчлал, томилолтын бэлтгэл ажлыг хангана; | - | Айлчлалын тоо | 9 удаагийн айлчлалын бэлтгэл ажлыг хангаж ажилласан | Айлчлалын бэлтгэл ажлыг тухай бүр хангаж ажилласан байна. | 2024 оны 03 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, дүүргийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Япон Улсын Шизүока мужийн Яйзү хоттой байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийг өргөжүүлэн “Найрамдалт харилцаат хот” байгуулах ажлын хүрээнд тус хотод ажиллах томилолтын бэлтгэл хангаан ажилласан. 2024 оны 04 сарын 15-19-ний өдрүүдэд дүүргийн Засаг дарга, Засаг даргын дэргэдэх харьяа хэлтэс, албадын дарга нар Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсү дүүрэгтэй байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд туршлага судлан ажилласан.<br>2024 оны 06 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд дүүргийн Биеийн тамир, спортын хорооны багш, дасгалжуулагчид Засаг даргын дэргэдэх волейболын шигшээ багийн өсвөрийн шигшээ багийн тамирчдын хамт Япон Улсын Шизүока мужийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Яйзү хотод туршлага судлах, хамтарсан бэлтгэл, тоглолт хийх бэлтгэл ажлыг хангасан. | |
| 143 | ***Арга хэмжээ 3.5.6*** Дүүргийн төрийн албан хаагчдыг хариуцсан ажил үүргийн хүрээнд гадаад улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагдах, туршлага судлах уулзалт, семинарт хамрагдахад бүхий л талаар дэмжиж ажиллана; | - | Зохион байгуулагдсан сургалтын тоо Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 53 албан хаагчийг гадаад улсад туршлага судлах сургалтад хамруулсан | Давхардсан тоогоор нийт 55-аас доошгүй албан хаагчдыг гадаад улсад сургалт, туршлага судлах уулзалт, семинарт хамруулсан байна | 2024 оны 03 сарын 25-29-ний өдрүүдэд Япон улсын Шизуока мужийн Яйзү хот, 2024 оны 04 сарын 15-19-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсү дүүрэг, 2024 оны 05 сарын 04-09-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хот, 2024 оны 06 сарын 12-19-ний өдрүүдэд Япон Улсын Шизуока мужийн Яйзү хотуудад тус тус төрийн албан хаагчдыг хариуцсан ажил үүргийн хүрээнд туршлага судлах уулзалт, семинаруудад үе шаттай хамруулан ажиллаж байна. | 100% |
| 144 | ***Арга хэмжээ 3.5.7*** Хамтын ажиллагаатай гадаадын хот, дүүргийн ижил түвшний төрийн байгууллын албан хаагчдыг богино хугацаатай харилцан солилцох хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ; | - | Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо | Нийт 2 удаа төрийн албан хаагчийн харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. | 2-с доошгүй удаа албан хаагчдыг хөтөлбөрт хамруулсан байна | Төрийн албан хаагчдыг чадавхжуулах зорилтын хүрээнд 2024 оны 05 сарын 04-09-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын 1 албан хаагчийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод, 2 албан хаагчийг 2024 оны 04 сарын 15-19-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Ёнсү дүүрэгт тус тус харилцан туршлага судлах хөтөлбөрт хамруулан ажилласан. | 100% |
| 145 | ***Арга хэмжээ 3.5.8*** Гадаадын харилцаа, хамтын ажиллагаатай хот, дүүрэгтэй хамтарсан аливаа урлаг, спортын нөхөрсөг тэмцээнүүдийг | - | Зохион байгуулсан тэмцээн, арга хэмжээний тоо, Хөтөлбөрт | Хамтарсан нөхөрсөг тэмцээнийг 2 удаа зохион | Нөхөрсөг тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион | 2024 оны 04 сарын 15-19-ний өдрүүдэд дүүргийн Засаг даргын дэргэдэх сагсан бөмбөгийн өсвөрийн шигшээ багийн нийт 19 тамирчин Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Ёнсү дүүрэгтэй байгуулсан хамтын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтмол зохион байгуулах, Ерөнхий боловсролын сургуулиудын хичээл, сурлага, урлаг спортоор манлайлдаг тэргүүний сурагчдыг “Сурагч солилцоо”-ны хөтөлбөрт хамруулна; | | хамрагдсан сурагчдын тоо | байгуулж, “Сурагч солилцоо ны хөтөлбөр” -ийг 1 удаа явуулсан. | байгуулж, сурагчдыг сурагч солилцоон ы хөтөлбөрт хамруулса н байна | ажиллагааны Санамж бичгийн хүрээнд тус дүүргийн сагсан бөмбөгийн баг, тамирчидтай хамтарсан бэлтгэл, нөхөрсөг тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын дэргэдэх волейболын шигшээ багийн тамирчид Япон Улсын Шизүока мужийн Яйзү хотын баг тамирчидтай хамтарсан бэлтгэл, тоглолт хийсэн. 2024 оны байдлаар нийт 2 удаа дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын сурлага, урлаг, спортын тэргүүний сурагчдыг ""Сурагч солилцооны хөтөлбөр""-т хамруулсан байна. 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд БНСУ-ын Инчон хотын Ёнсү дүүргийн Засаг дарга И Жэ Ху-гийн урилгаар тус дүүргийн Засаг дарга тэргүүтэй албан хаагчид болон дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн нийт 19 суралцагчийг “Сурагч солилцооны хөтөлбөр”-т хамруулсан. БНСУ-ын Инчон хотын Ёнсү дүүрэгтэй байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд “Сурагч солилцооны хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн 2024 оны 07 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Ёнсү дүүргийн ахлах ангийн 20 сурагч, 3 зочид, төлөөлөгчдийг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч ажилласан. | |
| **Зорилт 3.6 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 146 | ***Арга хэмжээ 3.6.1*** Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт | - | Хяналт шалгалтыг | 100% | 100% | Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Байгууллагын хөдөлмөрийн дотоод | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгалтыг хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгож ажиллах; | | хэрэгжүүлсэн хувь | | | журам болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, батлагдсан удирдамжийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2024 оны 01, 02, 08, 09 дүгээр сарын цаг ашиглалтын үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж албан хаагчдын мэдээллийн цагаар цаг ашиглалтын талаар танилцуулга, мэдээлэл өгч ажилласан. Экологийн цагдаагийн албаны мөрдөгчийн мэдэгдлийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны А/52 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд алт, мөнгөний дарханы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор химийн хорт бодис болон аюултай хорт бодисыг эргэлтэд оруулах, учирч болзошгүй эрсдэл, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, зохих арга хэмжээ авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. 2024 оны үйл ажиллагааны хүрээнд бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт хийснээс:<br>1. Дээд шатны байгууллагын бодлогын баримт бичгийн төлөвлөгөөний дүүрэгт хамаарах-9, дүүргийн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн- | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 14, нийт 23 бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснийг холбогдох хэлтэс, алба, тасгийн дарга нар болон дүүргийн удирдлагуудад тухай бүр үнэлгээг танилцуулж, баталгаажуулан ажилласан. | |
| **Зорилт 3.7 “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 147 | ***Арга хэмжээ 3.7.1*** Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Сар бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 19 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний сар, улирлын хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний сар, улирлын хэрэгжилт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээниий газарт хүргүүлсэн. | 100% |
| 148 | ***Арга хэмжээ 3.7.2*** Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Улирал тутам Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 4 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | “Нийслэлийг 2021-2024 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 149 | ***Арга хэмжээ 3.7.3*** Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Жилд 1 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 1 | Хуулийн хугацаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс дүүрэг хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | 90% |
| 150 | ***Арга хэмжээ 3.7.4*** Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Жилд 2 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 2 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн хэрэгжилтэд 2024 оны гуравдугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Үнэлгээний дундаж 96.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны гуравдугаар улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үнэлгээний дундаж 2024 оны 03 дугаар улирлын байдлаар 91.5 хувьтай байна. 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг хангаан ажиллаж байна. | 100% |
| 151 | ***Арга хэмжээ 3.7.5*** Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Улиралд 1 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 4 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн хүрээнд доорх тайлангуудад Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан. Үүнд:<br>-Монгол Улсын Ерөнхий сайдын “2024 оны эхний хагас жилд хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаврыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангасан байна. | нийслэлд зохион байгуулан, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 93.5%;<br>-Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны тогтоолоор батлагдсан 9 хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 89.5%; | |
| 152 | ***Арга хэмжээ 3.7.6***<br>Нийслэл, дүүргийн удирдах ажилтны шуурхайн зөвлөгөөний хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Тухай бүр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 31 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | Нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2024 оны байдлаар 24 удаа, дүүргийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 15 удаа хуралдаж, хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр тэмдэглэл хөтлөн холбогдох хэлтэс, алба, тасагт хүргүүлсэн. Мөн хуралдааны үүрэг даалгаврын хэрэгжилт, хэрэгжилтийн явцыг тухай бүр авч холбогдох албан тушаалтанд танилцуулан ажиллаж байна. 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг хийж ажилласан. | 100% |
| 153 | ***Арга хэмжээ 3.7.7***<br>Дүүргийн төр, захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс иргүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Улиралд 1 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 4 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад 2024 оны 03 улирал (өссөн дүнгээр)-д ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 78.9% буюу “хэрэгжих шатанд” гэж үнэлэгдсэн бөгөөд 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | 90% |
| 154 | ***Арга хэмжээ 3.7.8***<br>Дүүргийн төр, захиргааны | - | Улиралд 1 удаа Хяналт- | 4 | Хуулийн хугацаанд хяналт- | Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагад ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | | шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/111 дүгээр захирамжаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” систем ашиглах журам”-ыг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газарт 2024 оны эхний хагас жил, 3 дугаар улирлын тайлант хугацаанд ирсэн албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг боловсруулан ажиллаж үнэлгээний дундаж 97.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. 2024 оны үйл ажиллагааны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | |
| 155 | ***Арга хэмжээ 3.7.9*** Дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн тайланд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ; | - | Улиралд 1 удаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 4 | Хуулийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангасан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн тайланд хагас жилээр 2024 оны эхний хагас жилийн байдлаар 88.2 хувь, 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж үнэлгээ 94.8% буюу “хэрэгжилт хангалттай” гэж үнэлэгдсэн байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 156 | ***Арга хэмжээ 3.7.10*** Хяналт шалгалтын мөрөөр өгсөн зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээ авах; | - | Зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтэд тавьсан хяналтын тоо | 11 | 12 | Чингэлтэй дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-70 хувь үнэлэгдсэн, төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээний бодит үр дүнг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтийг сайжруулах зөвлөмжийг хэлтэс, тасгийн дарга нарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/182 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 01, 02, 08, 09 дүгээр сарын цаг ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “хэрэгжилт хангалтгүй” гэж тус тус дүгнэгдсэн ба 6 заалттай зөвлөмжийг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн.<br>Засаг даргын дэргэдэх харьяа байгууллагууд болон Засаг даргын Тамгын газарт 2024 оны 03 дугаар улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 78.93 хувь буюу "хэрэгжих шатанд" гэж дүгнэгдсэн. Тус 1, 2, 8, 9 дүгээр сарын цаг ашиглалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн илтгэх хуудас, зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын “Мэдээллийн цаг” хөтөлбөрөөр тухай бүр танилцуулж, цаашид ажлын цаг | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалтад тогтмол анхаарч хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосон. | |
| 157 | ***Арга хэмжээ 3.7.11*** Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар холбогдох дүрэм журмын хүрээнд албан хэрэг хөтлөх, Архивын тухай хууль заавdefinitely дагуу хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгагдсан холбогдох материалыг архивын хадгаламжийн нэгж болгох; | - | Хуулийн хугацаанд архивд шилжүүлсэн байна. | 1 | Архивласан хадгаламжийн нэгжээр | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 онд үйл ажиллагааны хүрээнд үүссэн Байнга, Түр хадгалах хадгаламжийн нэгжийг байгууллагын архивд хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. | 90% |
| **Зорилт 3.8 Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн үндэслэлийг хянах, иргэдэд сурталчлах, оролцоог дэмжсэн олон талт үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах;** | | | | | | | |
| 158 | ***Арга хэмжээ 3.8.1*** Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянах, санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих; | - | Эрх зүйн актын баримт бичгийн хэрэгжилтийн хувиар | Эрх зүйн актын 1139 төсөл хянагдсан. | Захирамжлалын баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг 100% хянасан байна. | Дүүргийн Засаг дарга, Тамгын газрын даргын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Засаг даргын А захирамж 358, Б захирамж 110, Тамгын газрын даргын А тушаал 340, Б тушаал 325 тус тус захирамжлалын баримт бичгийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тэмдэглэлийн хамт “Санал авах хяналтын дагалдах хуудас”-аар холбогдох зохион байгуулалтын нэгжийн удирдлагад танилцуулан эрх зүйн актын төслийг шат дараатай чиг үүргээр албажуулж ажилласан. | 100% |
| 159 | ***Арга хэмжээ 3.8.2*** Шинээр батлагдан гарсан хууль, эрх зүйн асуудлаар мэдээлэл | Орон нутгийн төсөв | Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан тоогоор | Аян-2 Хэлэлцүүлэг-1 | Сургалт, үйл ажиллагааны үр дүнг | *Хууль сурталчлах ажлын хүрээнд:* Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор *“Мэдье, Сонсъё, Сэргийлье”* сэдэвт сургалтыг Ерөнхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийх, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах; | | | Сургалт, мэдээлэл -11 нийт 678 иргэн 370 аж ахуйн нэгж | нэгтгэн тайлагнах | боловсролын 12 сургууль, урлагийн төрөлжсөн сургалттай “Бадмаараг” ахлах сургуулийн 8-12 дугаар ангийн нийт 45 багш, нийгмийн ажилтан, 2734 сурагчдад Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн алба, дүүргийн Цагдаагийн газартай хамтран зам тээврийн осол, цахим гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар сургалт мэдээлэл өгөн санал хүсэлтийг сонсон асуултад хариулан ажилласан. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай хамтран шүүхийн иргэдийн төлөөлөгчийн оролцоо, эрх, үүрэг, ач холбогдол, иргэдийн төлөөлөгчид олгох цалин хөлсний талаар мэдээллийг 65 иргэнд хүргэв. Дүүргийн Прокурорын газар, дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран “Зөрчлийн тухай хууль”, “Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт”, “Нийтэд тустай ажил хийлгэх ял”, Эрүү шүүлтээс ангид байх эрх, Авлигатай тэмцэх газрын Олон нийттэй харилцах төвтэй хамтран “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”, “Нийгмийн даатгалын ерөнхий хууль”-аар 225 иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан. Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн Ерөнхий газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран “Хариуцлагатай газрын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харилцаа" аянд дүүргийн 1-24 дүгээр хороодын 56 иргэн хамрагдав. 2024 оны байдлаар нийт 12 удаагийн сургалт, мэдээлэлд 3350 иргэн, 1 удаагийн аян 56, нийт 3406 иргэнийг тус тус хамруулсан. | |
| **Зорилт 3.9 "Иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хууль зүйн үндэслэлийг хянах, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 160 | ***Арга хэмжээ 3.9.1*** Бүх шатны шүүх, хууль хяналтын байгууллагад дүүргийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, шүүх хуралдаанд хэрэг маргааныг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах; | - | Зохион байгуулсан хурал, холбогдох хуульд заасан арга хэмжээний тоогоор | Иргэний хэрэг хянан шийдвэрлэх -7, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх -14 нийт ажиллагаа25 | Хууль ёсны эрх ашгийг хамгаалсан байна. | Шүүх, хяналтын байгууллагад итгэмжлэлээр байгууллага, эрх бүхий албан тушаалтныг төлөөлөх, хариу тайлбар өгөх, нотлох баримт цуглуулах, шүүх хуралд оролцох, хэрэг маргааныг шиийдвэрлүүлэх ажлын хүрээнд:<br>1.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа-3<br>2.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 9 нийт 12 хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай нөхцөл байдлыг тодруулах ач холбогдол бүхий баримт цуглуулах, хэргийн талаар үндэслэл бүхий тайлбар гаргах, шүүхийн шийдвэрийг гардан авах зэрэг хуулиар олгосон эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 161 | ***Арга хэмжээ 3.9.2*** Иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг хянах, дугаарлах, бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих; | - | Гэрээний хэрэгжилтийн хувиар | Нийт 200 гэрээний төсөл хянагдаж, баталгаажсан байна. | Гэрээний үндэслэлийг 100% хянан ажилласан байна. | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүргийн хүрээнд иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоомж, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн зохион байгуулж, иргэн, аж, ахуй нэгж, байгууллагатай байгуулсан гэрээг бүртгэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах байгуулах гэрээний төсөлд *“Авилгаас урьдчилан сэргийлэх”* асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд гэрээний төслийг хууль зүйн хүрээнд нийцүүлэн боловсруулахад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, холбогдох хуулийн үндэслэл, заалтыг судлах, агуулга, найруулгыг хянах, бүртгэн дугаар олгох гэрээний хугацаа, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэсэн байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулан холбогдох хэлтэс, албатай хамтран ажилласан.<br>***Гэрээний төрлөөр ангилбал:***<br>1.Хөлсөөр ажиллах гэрээ-12<br>3.Ажил гүйцэтгэх гэрээ-89<br>4.Хамтран ажиллах гэрээ-32<br>5.Худалдах, худалдан авах гэрээ-53<br>6.Түрээсийн гэрээ-11<br>7.Үйлчилгээ үзүүлэх гэрээ-3<br>8.Эрх шилжүүлэх гэрээ-1, нийт 201 гэрээний төсөл хянагдаж, баталгаажсан байна. Үүнээс хугацаандаа хэрэгжиж дууссан 132 гэрээ, хэрэгжиж байгаа 69 гэрээ байна. | |
| **Зорилт 3.10 Төрийн үйлчилгээг түргэн шуурхай холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуг хүргүүлэн ажиллах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 162 | ***Арга хэмжээ 3.10.1***<br>Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн | - | Ирүүлсэн хүсэлт, мэдэгдлийн тоогоор | Жагсаалт, цуглаан | Хүсэлтэд хууль, эрх зүйн | Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Тусгаар тогтнолын | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд жагсаал, цуглаан бусад арга хэмжээ зохион байгуулахаар ирүүлсэн хүсэлтийг судлан шийдвэрлэх; | | | хийх хүсэлт-27 | үндэслэл бүхий хариуг хүргүүлэн ажилласан байна. | талбай", "Барилгачдын талбай", "Хэлмэгдэгсдийн хөшөө", "Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн" "Аргальтай хөшөө" зэрэг газруудад өдөрлөг, арга хэмжээ, жагсаал, цуглаан гэх мэт арга хэмжээ зохион байгуулах нийт 8 хүсэлт /мэдэгдэл/-ийг хуулийн хүрээнд судлан үзэж, холбогдох байгууллагуудын саналыг харгалзан хууль зүйн үндэслэл бүхий хариуг албан бичгээр өгч ажилласан. | |
| 163 | ***Арга хэмжээ 3.10.2***<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах; | Орон нутгийн төсөв | Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулагдсан байдлаар | Сургалт-4 | Ажлын үр дүнг тооцож, холбогдох 4 арга хэмжээг зохион байгуулсан байна. | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нутгийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор 1-24 дүгээр хороодод 23, дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтэст 2, нийт 25 "Олон нийтийн байцаагч"-ийн хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг дүгнэх, тэдний ажлын үр дүн, нөхцөл боломжийг судлах зорилгоор сар бүр ажлын тайлан, хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, хуульд заасан зохих журмын дагуу урамшууллыг олгуулан ажиллаж байна. ОНБ нарын чадавхжуулах, мэдээллийн дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Үүнд: Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын Газрын Хууль, эрх зүйн хэлтсээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар нийтийн хэв журмыг сахиулах чиг үүрэг бүхий 1-24 дүгээр хорооны "Хэсгийн байцаагч", | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Олон нийтийн байцаагч”-ийн хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг нэгтгэх дүгнэх, мэргэжлийн удирдлагаар хангах, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх ажлыг Цагдаагийн газартай хамтран 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн Хурлын танхимд зохион байгуулсан. Олон нийтийн байцаагч нарын эргүүлийн үүргээ гүйцэтгэхэд иргэд, олон нийтэд таних тэмдэг бүхий 4 улиралд хэрэглэн боломжтой гадуур хувцас, зуны улиралд хэрэглэх боломжтой хантаазыг ажиллаж буй нийтийн эргүүлүүдэд шинэчлэн өгсөн. | |
| **ТӨРИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ** | | | | | | | |
| **3.11 “Дайчилгаа удирдах бүлэг, хэсгийн дайчилгааны бэлэн байдлыг хангах болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулж, хэрэгжилтийг хангах, томилгоот бүрэлдэхүүний дадлага, чадварыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд** | | | | | | | |
| 164 | ***Арга хэмжээ 3.11.1*** Дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэгдсэн хүн, техникийн тодотголыг явуулах; | 3.5 Дүүргийн төсвийн хөрөнгө | Дайчилгааны даалгавартай анги /байгууллага/-тай тодотгол хийж, цэргийн бүртгэлийн мэдээллийн санд оруулах | Оногдуулан бүртгэлт хийгдсэн | Дайчилгааны бэлэн байдал дээшилнэ. | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн батласан “Чингэлтэй дүүргийн Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”-ний дагуу хүн, техникийн тодотголыг батлагдсан хуваарийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд хийсэн. Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн байрлалд зохион байгуулагдаж буй нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад дүүргээс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуваарийн дагуу бэлтгэл үүргэтнүүдийг сургалтад хамруулж, Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн командад оногдуулан дансалсан. Дүүргийн батлан хамгаалах товчооны томилгоот бие бүрэлдэхүүнийг мөн хороодын дайчилгааны татан нийлүүлэх төлөвлөгөө, техник оруулалтын журмын дагуу тодотгож байна. 2024 оны цэргийн бүртгэлээр дүүргийн харьяаллаас гарч байгаа болон шинээр шилжин ирж байгаа цэргийн нэгдүгээр болон хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг бүртгэж байна. Үндэсний Батлан хамгаалах Их сургуулийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан бэлтгэл офицерын сургалтад бэлтгэл үүрэгтнүүдийг хамруулсан. | |
| 165 | ***Арга хэмжээ 3.11.2*** Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүн болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах, техник материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх; | 27.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу | Сургалтууд төлөвлөгдсөн. | Дайчилгаа удирдах томилгоот бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийн дадлага, чадвар дээшилнэ. | Орон нутгийн цэргийн отрядын хүн техникийг 2023 оны цэргийн бүртгэл, НЗДТГ-ын Цэргийн штабаас авсан авто техникийн 2024 оны бүртгэлээс оногдуулан бүртгэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2024 оны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Стратегийн команд-штабын сургуульд Цэргийн штабын дарга, дайчилгааны офицер нар хамрагдсан. Дүүргийн цугларах болон шилжүүлэх байруудыг дэлгэх төлөвлөгөө, хавсралтуудад тодотгол хийж, байр, тасгуудад ажиллах бүрэлдэхүүнийг орон тооны дагуу байрын дарга нарын тушаалаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | томилгоожуулан, үүрэг гүйцэтгэхэд бэлнээр ажиллаж байна. Байрын томилгоот бүрэлдэхүүнтэй гүйцэтгэх үүргийн дадлагажуулах сургалт, дадлагыг нэгдүгээр улиралд зохион байгуулсан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойг угтаж дүүргийн Засаг даргын санаачилгаар Чингэлтэй дүүрэгт оршин суудаг 450 цэргийн бэлтгэл үүрэгтнүүдтэй “Эх орны цэрэг” уулзалт, зөвлөгөөнийг 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан. | |
| 166 | ***Арга хэмжээ 3.11.3*** Цэргийн бүртгэлийг зохион байгуулж, бүртгэлд хамрагдаагүй завсардсан иргэдийн судалгааг мэдээллийн санд оруулан, баяжилт хийх; | 15.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Дүүргийн Засаг даргын захирамжийн дагуу | Жил бүр хийгддэг. | Дайчилгааны даалгаврын дагуу оногдуулан бүртгэлт явагдах нөхцөл бүрдэнэ. | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1328, дүүргийн Засаг даргын 2023 оны А/366 дугаар захирамжаар дүүргийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 04-ны өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг E-Mongolia цахим портал, Засаг захиргааны анхан шатны нэгж болох хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулан явуулсан. Дүүргийн Засаг даргын захирамжаар цэргийн бүртгэлийн ажлын хэсгийг байгуулж, цэргийн бүртгэлийн бэлтгэлийг хангах 16 ажил бүхий төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% биелүүлсэн. 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон бүртгэлийн ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавин ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, 1-24 дүгээр хороодын Засаг дарга, зохион байгуулагч нартай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэргийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах, иргэд хэрхэн E-Mongolia цахим порталаар бүртгүүлэх талаар сургалт, семинарыг зохион байгуулсан. Мөн 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр дүүргийн цэргийн штабын мэдээллийн сангийн программ болон хороодын мэдээллийн санд вирусийн эсрэг программыг бүрэн суулган, цэргийн бүртгэл явуулах тухай зөвлөмж, хороодын Засаг дарга нарын үүрэг, удирдамж, цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулж, хяналт тавин ажиллах ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, анкет, маягт, сурталчилгааны материал, зурагт хуудас, зэрэг материалуудыг тарааж өгсөн. Цэргийн бүртгэлийг цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia болон Засаг захиргааны анхан шатны нэгж хорооны Засаг даргын ажлын байранд зохион байгуулж иргэдэд хүрэх зурагт хуудас болон гарын авлага маягтууд, төрийн батлан хамгаалах үйлчилгээний мэдээллийн самбар, хороодын цэргийн бүртгэл хийгдэж буй хаяг, мэдээллийг нэг загварт оруулан ажиллалаа. | |
| 167 | ***Арга хэмжээ 3.11.4*** Халагдсан дайчдыг ажлын байр, сургалтад зуучлах, хугацаат цэргийн алба хааж байгаа дайчдын нөхцөл байдалтай танилцан, дүүрэгт хэрэгжиж байгаа | 20.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Дүүргийн ЗДТГ-ын даргын тушаалын дагуу | Тогтмол хийгддэг | Хугацаат цэргийн алба хааж буй дайчдад сэтгэл зүйн дэмжлэг | Цэргийн жинхэнэ албанд 2023 оны 1, 2 дугаар ээлжээр татагдан алба хааж байгаа 7, 20, 22, 23 дугаар хороодын амьжиргааны түвшин доогуур 4 хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт дулаан хувцасны иж бүрдэл, 13 дүгээр хорооны 5 өрхөд хүнс, гэр ахуйн багц, 24 дүгээр хорооны 2 өрхөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бодлого, шийдвэрийг танилцуулж, алба хаагч нарт хүндэтгэл үзүүлэх; | | | | үзүүлсэн байна | хүнсний багцыг гардуулсан. 2 дугаар хорооноос 2023 оны 1 дүгээр ээлжээр татагдсан 1 байлдагчийн ар гэрт эрүүл мэндийн витамин 5 хайрцаг, малын эм 30 том хайрцгийг гардуулж ар гэрт нь дэмжлэг үзүүлсэн. 2024 оны 2 дугаар ээлжээр Чингэлтэй дүүргээс Зэвсэгт хүчний 016 дугаар ангид татагдан алба хааж буй Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны иргэн, байлдагч А.Хосбаярын ар гэрт хүнс, бараа материалын тусламжийг ар гэрт нь үзүүлсэн. | |
| 168 | ***Арга хэмжээ 3.11.5*** 2024 оны 1, 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг зохион байгуулах; | 90.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд | Жил бүр хийгддэг. | Хуулийн хэрэгжилт хангагдана. | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/399, дүүргийн Засаг даргын А/89 дүгээр захирамжуудыг үндэслэн 2024 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 05 дугаар сарын 04-ний өдрөөс 06-ны өдрүүдэд, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1116, А/1227, дүүргийн Засаг даргын А/312, А/335 дугаар захирамжуудыг үндэслэн 2024 оны 10 дугаар сарын 18-20-ны өдөр, 22-24-ний өдрүүдэд зохион байгуулсан. Дүүргийн 2024 оны 1, 2 дугаар ээлжийн цэргийн жинхэнэ албаны татлагын үеэр цэрэг татлагын товчоогоор эмчийн үзлэгт хамрагдаж буй татагдагч нарын ар гэрийн төлөөллийг Цэрэг татлагын товчооны үйл ажиллагаатай нээлттэй танилцуулж, цэрэг татлагыг шинэлэг хэлбэрээр сурталчилсан. | 70% |
| 169 | ***Арга хэмжээ 3.11.6*** Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, байгууллага аж ахуй нэгжид хүргэх ажлыг зохион байгуулан, | 3.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Ажлын төлөвлөгөө батлагдсан. | Иргэдийн батлан хамгаалах хууль тогтоомжи | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын баталсан “Хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”, дүүргийн Засаг даргын 2024 оны А/04 дүгээр захирамж, удирдамжийн дагуу дүүргийн нутаг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүргэх; | | | | йн мэдлэг дээшилнэ | дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудад батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн үүргийн биелэлтийн хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу нийслэлийн Ерөнхий боловсролын 57 дугаар сургууль, дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, “Жи-Мобайл” ХХК, “Улаанбаатар Синима” ХХК, “Хүрд” ХК-ний ажилчдыг хамруулсан. Тус байгууллагын хүний нөөцийн ажилчидтай 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “Батлан хамгаалах хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт явуулах” тухай сургалтыг зохион байгуулсан. Тус шалгалтад Эдийн засаг, хөгжлийн яам, дүүргийн Биеийн тамир, спортын хороо, нийслэлийн Ерөнхий боловсролын 57-р сургууль, “Улаанбаатар синима” ХХК, “Жи-Мобайл” ХХК, “Хүрд” ХК зэрэг 6 байгууллагын 18-50 насны нийт 125 эрэгтэй ажилтан албан хаагчдын цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалт явуулж, зөрчилтэй 23 иргэнд мөнгөн төлбөр оногдуулан мэдэгдэх хуудас өгснөөс 19 иргэн мөнгөн төлбөрөө тушааж, нийслэлийн төрийн санд 15,232,265 төгрөг төвлөрүүлээд байна. | |
| 170 | ***Арга хэмжээ 3.11.7*** Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн баярыг | 27.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийг хангах | Хөтөлбөр боловсруулагдаж байгаа | 15 арга хэмжээ зохион байгуулна | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/42 дугаар захирамжаар батлагдсан “Иргэн-цэргийн харилцааны өдөрлөгийг зохион байгуулах тухай” | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэх үйл ажиллагааг зохион байгуулах, дайнд оролцсон үе үеийн ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх; | | | | | захирамж, хөрөнгө гаргах тухай ЗДТГ-ын даргын 2024 оны А/46 дугаар тушаал, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн төлөвлөгөөг боловсруулан холбогдох албан тушаалтнуудаар хянуулан батлуулж, төлөвлөгөөт 15 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. | |
| 171 | ***Арга хэмжээ 3.11.8*** Нийслэл, дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулах, оролцох; | 12.2 Дүүргийн төсвийн хөрөнгө | Ахлах ангийн сургуулиудын сурагчдыг бүрэн хамруулах | Холбогдох албан тушаалтнуудад бэлтгэлийг хангах үүрэг өгөгдсөн | Дүүргийн ерөнхий боловсролын ахлах ангийн сургуулиудын сурагчдыг бүрэн хамруулах | Цэрэг-спортын “Дөл” тэмцээний 2 дугаар шатны шалгаруулалтыг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ-ын материаллаг баазыг ашиглан зохион байгуулсан. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг дүүргийн Засаг даргаар батлуулсан удирдамж, зааврын дагуу 14 төрлийн тэмцээнийг бага онооны системээр дүгнэсэн. Тэмцээний нээлтийн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр дүүргийн “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ-ын хөл бөмбөгийн талбайд зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын “Дөл-2024” цогцолбор тэмцээнд оролцож тэргүүлсэн шилдгүүдэд шагнал гардуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр дүүргийн “Тусгаар тогтнолын талбай”-д зохион байгуулсан. Мөн дүүргээс шалгарсан Ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн “Хар сүлд” тасаг нийслэлийн Засаг даргын нэрэмжит цэрэг спортын “Дөл” тэмцээнд оролцож “Тусгай байр”-ын шагнал хүртсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | ***Арга хэмжээ 3.11.9*** Монгол Улсад Генерал цол олгож эхэлсний 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд дүүрэгт оршин суудаг генералуудад хүндэтгэл үзүүлэх, ЕБС-иудын ахлах ангийн сурагчидтай халуун яриа өрнүүлэх; | 8.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилтийг хангах | 2023 онд бүрэн хэрэгжсэн | Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлнэ. | Монгол Улсад генерал цол бий болсны түүхт 80 жилийн ой, Монгол генералын өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын эх орноо батлан хамгаалах, эх оронч үзлийг нэмэгдүүлэх, Төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор “Эх оронч үзэл” уулзалт харилцан яриа өрнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус төлөвлөгөөт ажлын хүрээнд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж. Болдбаатар 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр нийслэлийн Ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн ахлах ангийн 450 гаруй сурагчидтай, Онцгой байдлын Ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нийслэлийн Ерөнхий боловсролын 39, 50, 72, 117, 149 дүгээр сургуулийн 450 гаруй ахлах ангийн сурагчидтай, Батлан хамгаалах яамны Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач, бригадын генерал Х.Батбилэг 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр нийслэлийн Ерөнхий боловсролын 23, 37, 49, 57, 61 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчидтай “Эх оронч үзэл” сэдвээр уулзалт, яриа өрнүүлсэн. | 100% |
| 173 | ***Арга хэмжээ 3.11.10*** Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ой, “Бидний бахархал” арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн ЕБС- | 3.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Ахлах ангийн сургуулиудын сурагчдыг бүрэн хамруулах | Холбогдох албан тушаалтнуудад бэлтгэлийг хангах | Хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзэл хүмүүжил | Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Би эх орны цэрэг” сэдэвт мюзикл дуулаачийн тэмцээнийг 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Ерөнхий боловсролын 61 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иудын сурагчдад сурталчилгааны ажил зохион байгуулах; | | | үүрэг өгөгдөнө | төлөвшүүлнэ. | дүгээр сургуулийн урлагийн зааланд зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 24, 39, 49 дүгээр сургуульд “Эх орончдын хүндэтгэлийн булан”-г байгуулж, хүлээлгэн өгсөн. Дүүргийн Ерөнхий боловсролын сурагчдыг 2024 оны 03 дугаар сарын 06,11-ны өдрүүдэд Монгол цэргийн музей үзүүлсэн. Уг арга хэмжээнд дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 150 орчим ахлах ангийн сурагчид хамрагдсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилсан “Бидний бахархал” арга хэмжээ, “Би эх орны ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд “Эх оронч үзэл ба үндэсний бахархал” хичээлийг дүүргийн ерөнхий боловсролын улсын 13, хувийн өмчит 2 сургуулийн 12 дугаар ангийн сурагчидтай явуулж, тус хөтөлбөрийн дүүрэгт зохион байгуулагдсан 1 дүгээр шатны хаалтын арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль дээр зохион байгуулсан. | |
| 174 | ***Арга хэмжээ 3.11.11*** Цэргийн штабаас 2024 онд зохион байгуулах сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах; | 6.4 Дүүргийн төсвийн хөрөнгө | Цэргийн бэлтгэл сургалтад бүрэн хамруулах | Төлөвлөгөө боловсруулагдаж байна. | Албан тушаалтнуудын мэдлэг дадлага дээшилнэ | Сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2024 оны Зэвсэгт хүчний Жанжин штабын Ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан Стратегийн команд-штабын сургуульд Цэргийн штабын дарга, дайчилгааны офицер нар хамрагдсан. | 100% |
| 175 | ***Арга хэмжээ 3.11.12*** Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа | 13.4 Дүүргийн | Хуулийн болзол шаардлага хангасан иргэнийг | Дүйцүүлэн алба хаах | Хуулийн хэрэгжилт | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/535 дугаар захирамжийн дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэнийг журмын дагуу элсүүлж, бэлтгэл, болон тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг зохион байгуулж, алба хаах хугацааг тооцож бүртгэл мэдээллийг хөтлөх; | төсвийн хөрөнгө | элсүүлж, алба хаалгах | иргэдийн бүртгэл явагдаж байгаа. | хангагдана. | хүсэлт гаргасан 8 иргэнийг хуулийн дагуу элсүүлж, сургалт зохион байгуулж явуулах дүүргийн Засаг даргын 2024 оны А/134 дүгээр захирамжийн дагуу 2024 оны 06 дугаар сарын сарын 03-16-ны өдрүүдэд 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 119 дүгээр ангид цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл сургалтад, хамруулж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх мэдлэг дадлагыг олгосон. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1085 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/316 дугаар захирамжийг тус тус үндэслэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын “Тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Онцгой байдлын гал унтраах, аврах 10 дугаар ангийн материаллаг баазын түшиглэн зохион байгуулсан. Сургалтаар дүйцүүлэх алба хаагчдад гамшгаас хамгаалах болон орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох онолын болон дадлагын мэдлэг, чадвар олгосон.<br>Мөн дүйцүүлэх алба хааж байгаа алба хаагчдын хугацааг тооцож, бүртгэл мэдээллийг тогтмол хөтлөн ажиллаж байна. | |
| 176 | ***Арга хэмжээ 3.11.13***<br>Төрийн болон албаны нууцын тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалахын Төрийн болон албаны нууцыг | 4.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Хууль, журмын зүйл заалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох | Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаж, | Маш нууц, нууц материал алдагдаж үрэгдэхээс сэргийлэгдэнэ. | 2024 оны Цэргийн бүртгэлийн бэлтгэл ажлын хүрээнд 1-24 дүгээр хороодын зохион байгуулагч нарт Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон хорооны цэргийн бүртгэлийн мэдээллийн сан, бүртгэлийн тэмдгийн ашиглалт, хадгалалт, хүний хувийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалах журмын хэрэгжилтийг хангах; | | | хэрэгжих нөхцөл бүрдсэн | | мэдээлэл алдахаас урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хүргэж, төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг Маягт №2 дагуу гаргуулсан. 2024 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2024 оны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Маш нууц, нууц, албан хэрэг, данс бүртгэлийн ангиллыг боловсруулан Цэргийн штабын даргаар хянуулан батлуулсан. | |
| 177 | ***Арга хэмжээ 3.11.14*** Тамгын газар, хорооны ажлын алба болон холбогдох албан тушаалтнуудтай нууц материалын хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, хяналт тавих; | 3.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Монгол Улсын Батлан хамгаалахын Төрийн болон албаны нууцыг хамгаалах журмын дагуу | 100% хэрэгжсэн | Албан тушаалтнуудын мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалтын талаарх мэдлэг, чадвар дээшилнэ. | Цэргийн бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсэг, хороодын зохион байгуулагч, бусад албан хаагчидтай нууц материалын хадгалалт хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын талаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын цэргийн штабын бие бүрэлдэхүүн сургалт, семинар зохион байгуулсан. | 100% |
| 178 | ***Арга хэмжээ 3.11.15*** Архивын хадгаламжийн нэгж үүсгэж, архивд шилжүүлэх; | 1.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зааврын дагуу | 100% хэрэгжсэн | Маш нууц, нууц материал алдагдаж үрэгдэхээс сэргийлсэн | Баримт хүлээн авах хуваарь, архивын хөмрөгийн бүрдүүлэлтийн төлөвлөгөө, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 онд үүссэн 52 баримтаар хадгаламжийн нэгж үүсгүүлэн хүлээн авсан. Байнга болон түр хадгалах баримтын бүртгэлийг нийслэлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЗДТГ-ын Цэргийн штабын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 2024 оны 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгт авсан. Нууц албан хэрэг данс бүртгэлийн ангиллаар үүссэн хадгаламжийн нэгжүүдийг архивлан бүртгэх ерөнхий бүртгэлд бүртгэн 2023 оны ангиллыг хаасан. | |
| **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **НОГООН ХӨГЖИЛ** | | | | | | | |
| **4.1 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилго бүхий “Ногоон дүүрэг-2024” арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 179 | ***Арга хэмжээ 4.1.1*** Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд 7-19 дүгээр хороодын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, борлуулалтын үйл ажиллагааг жигдрүүлнэ; | - | Стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр айл өрхүүдийг хангасан борлуулалтын цэгийн тоо | 2023 онд стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр айл өрхүүдийг хангах 90 борлуулалтын цэг ажилласан | Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэгийг нэмэгдүүлэх | Дүүргийн хэмжээнд 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт шахмал түлш борлуулах 100 борлуулалтын цэг ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнээс гэрээ сунгаж ажиллах 78 цэг, цахимаар хүсэлт гаргасан нийт 14 цэгээс 8 цэгийг сонгон нийт 2024-2025 онд 86 цэг шалгаруулж ажиллуулахаар шийдвэрлэсэн. 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийт 13567.5 тонн сайжруулсан шахмал түлшийг нөөцөлсөн. 2023-2024 онд сайжруулсан шахмал түлш борлуулах нийт 94 цэгт 12596.5 тонн сайжруулсан түлшийг борлуулаад байна. | 100% |
| 180 | ***Арга хэмжээ 4.1.2*** Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Улс, Нийслэл, Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл | Улс, нийслэлийн төсөв | Гэр хорооллын айл өрхөд эко жорлон нэвтрүүлэх | 1000 айл өрхийг төсөлд хамрагдулах | Гэр хорооллын айл өрхөд эко жорлон нэвтрүүлснээр лаг хаягдлыг | Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Барилга, хот байгуулалтын яамнаас Улсын төсвийн хөрөнгөөр 2023-2024 онд он дамжин нийт 4,4 тэрбум төгрөгөөр Ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээг дэмжин ажиллана; | | | | соруулах хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх | жорлонг сайжруулах айл өрхийн байшингийн дулаалга хийх цогц ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд: Дүүргийн 7, 12-19 дүгээр хороодын нийт 150 айл өрх хамрагдан 2023 оны 08 дугаар бүрэн хэрэгжиж дуусан комисс хүлээн аваад байна. Барилга, хот байгуулалтын яамнаас дүүргийн нутаг дэвсгэрт 2023-2024 онд он дамжин хэрэгжиж буй “ЭКО ЖОРЛОН” ажлын хүрээнд “Дархан нэгдэл” ХХК 7, 10, 12-17, 19, нийт 9 хороонд 450 эко жорлон хийгдэхээс 50% болох 890,169.016 сая төгрөгийн санхүүжилт авч 260 орчим ширхэг жорлон тавигдсан. 2023 онд БХБЯ-нд санхүүжилтийн хүсэлт гаргаж 2024 онд санхүүжилт бүрэн тавигдсан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр гэрээний хугацаа дуусаж, ажлаа хүлээлгэн өгсөн. | |
| **4.2 Дүүргийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, цэцэрлэгт хүрээлэн, ойжуулалт, ногоон байгууламжийг бүтээн байгуулна.** | | | | | | | |
| 181 | ***Арга хэмжээ 4.2.1*** Дүүргийн хэмжээний ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ; | - | Тарьж ургуулсан мод, бут, сөөгийн тоо | 2014-2022 онд 358745 ширхэг мод, бут, сөөг тарьж ургуулсан | 20000 ширхгээс доошгүй мод, бут, сөөг тарьж ургуулсан байна. | Хаврын тарилтын хүрээнд дүүргийн 19 хороо, “Хайрхан хөгжил төв” ОНӨТҮГ-т дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад, 1-24 дүгээр хороодын нийт 600 албан хаагч 300 шилмүүст нарс, шинэс, 200 улиас, 3500 хайлаас, тариад байна. Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудаас Геодези усны барилга байгууламжийн газар 50 улиас тариалсан бөгөөд ОСНААУГазар “Хайрхан хөгжил төв” ОНӨТҮГ-ын цэнэг усалгаанд хамтран ажилласан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар 50 гацуур тус тус тариалаад байна. “Тэрбум мод” | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үндэсний аяны хүрээнд дүүргийн 19 дүгээр хороо, “Хайрхан хөгжил-1” төв болон 16 дугаар хороо, “Хоймор хайрхан төв” ахмадын амралтын газар, 84 бичил цэцэрлэгүүдэд, 1-24 дүгээр хороодын авто зам байшин хорооллын дундах нийтийн эзэмшлийн талбайд 61550 шилмүүст мод, навчит бут мод 58269 нийт 119819 мод бут таригдаад байна. Намрын мод тарилтын ажлын хүрээнд “Ногоон төгөл” ХХК-тай гэрээ байгуулан 20ш нарс, 150ш шинэс, 3000ш хайлаас, 2556ш шар хуайс мод, нийт 5726 ширхэг мод бут, сөөгийг 2024 оны 10 дугаар сарын 17-ноос 25-ны өдрийн хооронд авч Сууц өмчлөгчдийн холбоодод хуваарилан өгч холбогдох заавар зөвлөгөөг өгөн арчлалт ургалтын явцад хяналт тавин ажилласан. | |
| 182 | ***Арга хэмжээ 4.2.2*** Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, ногоон байгууламж, ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлнэ; | 100,0 | Цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэгийн ногоон байгууламж, нөхөн сэргээлт, ойжуулалтыг нэмэгдүүлсэн хувь | 2017-2023 онд нөхөн сэргээлт ойжуулалтаар 119514 ширхэг мод, бут, сөөг, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнд 51324 ширхэг мод, бут, | Суурь түвшний 10-с доошгүй хувьд нэмэгдүүлнэ. | “Тэрбум мод” Үндэсний аяны хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Чингэлтэй дүүрэгт хуваарилан өгсөн 2700ш модыг “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК-ний баазаас хороодод хуваарилан өгсөн. 19 дүгээр хороо, “Хайрхан хөгжил-1” төв болон 16 дугаар хороо, “Хоймор хайрхан төв” ахмадын амралтын газар, 84 бичил цэцэрлэгүүдэд, 1-24 дүгээр хороодын авто зам байшин хорооллын дундах нийтийн эзэмшлийн талбайд 61550 шилмүүст мод, навчит бут мод 58269 нийт 119819 мод бут таригдаад байна. Намрын мод тарилтын ажлын хүрээнд “Ногоон төгөл” ХХК-тай гэрээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сөөг тарьж ургуулсан. | | байгуулан 20ш нарс, 150ш шинэс, 3000ш хайлаас, 2556ш шар хуайс мод, нийт 5726 ширхэг мод бут, сөөгийг 2024 оны 10 дугаар сарын 17-ноос 25-ны өдрийн хооронд авч Сууц өмчлөгчдийн холбоодод хуваарилан өгч холбогдох заавар зөвлөгөөг өгөн арчлалт ургалтын явцад хяналт тавин ажилласан. | |
| **ТАВ. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **5.1 “Дүүргийн хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах” ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 183 | ***Арга хэмжээ 5.1.1.*** Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албад, хороодоос авч нэгтгэн боловсруулж, хуулийн хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ; | - | Хүргүүлсэн саналын тоо | 1 | 1 | Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлал”-ын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тусгах “Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж”-ийн нийт 10 саналыг боловсруулан Нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 3/1019 тоот албан бичгээр хүргүүлсэн ба www.pimis.publicinvestment.gov.mn цахим системд саналыг оруулан, үнэлгээг журмын дагуу хийж ажилласан. Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд тусгах шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсвийн нийт 22 саналыг боловсруулан Нийслэлийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 3/1663 тоот албан бичгээр хүргүүлсэн ба | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *www.pimis.publicinvestment.gov.mn* цахим системд саналыг оруулан, үнэлгээг журмын дагуу хийж ажилласан. Дүүргийн төсвийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн тодотголд нийт 119 санал, 09 дүгээр сарын дүүргийн төсвийн тодотголд 83 саналыг хэлтэс, албад, хороодоос авч нэгтгэн Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн. Нийслэлийн төсвийн тодотголд хөрөнгө оруулалтын нийт 7 саналыг албан бичгээр хүргүүлснээс 2 төсөл, арга хэмжээ тодотголд сууж батлагдсан. Нийслэлийн 2025 оны төсвийн төсөлд нэмэлтээр нийт 96 төсөл арга хэмжээний саналыг Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадаас нэгтгэн авч боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |
| 184 | ***Арга хэмжээ 5.1.2***<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг олон нийтийн оролцоог ханган зохион байгуулах, холбогдох тооцоо судалгааг хийж төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг боловсруулна; | - | Санал өгсөн иргэдийн тоо | 60% | 70% | Дүүргийн Засаг даргын 2024 оны “Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг зохион байгуулах тухай” А/91 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, ажлын хэсэг болон дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нарт захирамжийг хүргүүлсэн.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал асуулгыг дүүргийн 1-24 дүгээр хороодод зохион байгуулан *“Чингэлтэй дүүрэг/Chingeltei District”* facebook цахим хуудсаар болон хороодын | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим хаягаар иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Мөн “Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах ажлыг зохион байгуулахад зардал гаргах тухай” Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны А/144 дүгээр тушаал гарч цаасаар санал авсан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хийгдэх төсөл, арга хэмжээнд дүүргийн 1-24 дүгээр хороодын иргэд цахимаар нийт 1096, цаасаар 80277, нийт 81373 санал өгсөн байна. Дүүргийн 1-24 дүгээр хороодын ОНХС-ийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн саналын жагсаалтыг нэгтгэн танилцуулга бэлтгэн ажилласан. | |
| 185 | ***Арга хэмжээ 5.1.3*** Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл бүхий төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлсэн байна; | - | Төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн саналын тоо | 24 | 24 | Дүүргийн 1-24 дүгээр хороодын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн саналын жагсаалтыг нэгтгэн танилцуулга бэлтгэн ажилласан. Нийслэлийн 2025 оны төсөв батлагдан Орон нутгийн хөгжлийн санд тавигдсан төсвийг дүүргийн 1-24 хороодын хийгдэх ажилд хуваарилан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан. | 100% |
| 186 | ***Арга хэмжээ 5.1.4*** Дүүрэгт Улс, нийслэл, дүүргийн төсвийн болон нийслэл, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр | - | Төсөл, арга хэмжээнд хяналт тавьсан тоо | 10 | 12 | Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр 23,536.2 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ, 2023-2024 онд он дамжин хэрэгжиж байгаа 115,089.7 сая төгрөгийн нийт 19 төсөл, арга хэмжээ. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг хянах; | | | | | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 59,552.1 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, 2023-2024 онд он дамжин хэрэгжиж байгаа 36,570.0 сая төгрөгийн нийт 7 төсөл арга хэмжээ, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжих 1,200.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, 2022-2023 онд он дамжин хэрэгжиж байгаа 1,996.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ байна.<br>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжих 23,486.6 сая төгрөгийн 72 төсөл арга хэмжээ, 2023-2024 онд он дамжин хэрэгжиж байгаа 25,884.0 сая төгрөгийн нийт 28 төсөл арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжих 1,950.4 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ, 2022-2023 онд он дамжих хэрэгжиж байгаа 729.14 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ байна.<br>Нийт 181 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас бэлтгэл ажил хийгдэж байгаа 34 төсөл арга хэмжээ, тендерийн шатандаа байгаа 32 төсөл арга хэмжээ, гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа 49 төсөл арга хэмжээ, 100% дууссан 66 төсөл, арга хэмжээ тус тус байна. | |
| **Зорилт 5.2 “Дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийг гаргах” ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 187 | ***Арга хэмжээ 5.2.1***<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны | - | Хүргүүлсэн биелэлтийн тоо | 2 | 2 | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна; | | | | | заалтын биелэлтэд 2024 оны эхний хагас жилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 65%-тай гарсан бөгөөд жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | |
| 188 | ***Арга хэмжээ 5.2.2*** Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна; | - | Хүргүүлсэн биелэлтийн тоо | 2 | 2 | Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дүүрэгт хамааралтай заалтын 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 86%, 03 дугаар улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 90.2% гарсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | 90% |
| 189 | ***Арга хэмжээ 5.2.3*** Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах хариуцлагын гэрээний төсөлд холбогдох хэлтэс, албадаас санал авч дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг даргаар батлуулна; | - | Батлуулах саналын тоо | 1 | 1 | Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах хариуцлагын гэрээний төсөлд холбогдох хэлтэс, албадаас санал авч, нийт 80 заалтыг оруулан дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг даргаар хуулийн хугацаанд батлуулж ажиллуулсан. | 100% |
| 190 | ***Арга хэмжээ 5.2.4*** Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах хариуцлагын гэрээний биелэлтийг нэгтгэн боловсруулна; | - | Хүргүүлсэн биелэлтийн тоо | 2 | 2 | Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг даргын хооронд байгуулсан 2024 оны хариуцлагын гэрээний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 93.4%-тай үнэлэгдсэн бөгөөд биелэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 191 | ***Арга хэмжээ 5.2.5*** Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн дүүрэгт хамааралтай заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулна; | - | Хүргүүлсэн биелэлтийн тоо | 2 | 2 | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн дүүрэгт хамааралтай заалтын 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 83.3%, 03 дугаар улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 96.6% гарсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр бэлтгэл ажлыг хангасан. | 90% |
| 192 | ***Арга хэмжээ 5.2.6*** Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн боловсруулна; | - | Хүрүүлсэн тайлангийн тоо | 4 | 4 | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 79.0%, 03 дугаар улирлын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.5%-иар үнэлэгдэж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдаж тогтоол гарсан. | 100% |
| 193 | ***Арга хэмжээ 5.2.7*** Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй 9 арга хэмжээний биелэлтийг нэгтгэнэ; | - | Хүргүүлсэн тайлангийн тоо | 2 | 2 | Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй 9 арга хэмжээний биелэлтийн 2024 оны жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 89.5%-иар үнэлэгдэж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар батлагдсан. | 90% |
| **Зорилт 5.3 “Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр зорилт арга хэмжээний хүрээнд:** | | | | | | | |
| 194 | ***Арга хэмжээ 5.3.1*** Хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, | 1.0 Дүүргийн төсөв | Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 50 | 60 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангаж ажиллаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт хийж, халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ; | | | | | үүрэг чиглэлийн дагуу 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын “Зах, худалдааны төвүүдэд хяналт хийх тухай” удирдамж батлагдсан. Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 худалдааны төв хяналтад хамрагдсан. Тус байгууллагуудад 2024 оны 02 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга хамтран эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлт, худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, зах, худалдааны төвийн орчимд хүнсний болон хүнсний бус ил задгай худалдаа эрхлэгч нарт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдах борлуулах агентын гэрээ байгуулсан 35 аж ахуйн нэгж, байгууллагад нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран "Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний хяналт, баталгаажуулалт" сэдвээр 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 195 | ***Арга хэмжээ 5.3.2*** Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн харилцаа болон хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулна; | 2.0 Дүүргийн төсөв | Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо | 148 | 200 | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран хамтран дүүргийн 1-24 хороодын нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 42 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт зохион байгуулсан. | 70% |
| 196 | ***Арга хэмжээ 5.3.3*** Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ; | - | Хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах гэрээ байгуулсан тоо | 50 | 60 | Дүүргийн Засаг даргын 2023 оны “Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” А/43 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа, хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 50 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагтай хүнсээр хангах мэргэжлийн ангитай хамтран ажиллах гэрээг нийт 50 аж ахуйн нэгж, байгууллагатай 2 жилийн хугацаатай байгуулсан. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2024 оны 06, 07 дугаар сард үргэлжлэн орсон хур борооны улмаас үерийн нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан дүүргийн шуурхай штаб байгуулагдсан тул хүнсээр хангах мэргэжлийн ангийн гэрээ байгуулсан хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Зочин Бууз” ХХК-тай хамтран нийт 10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагчийг 7 өдрийн турш хоол, хүнсээр хanган ажилласан. | |
| 197 | ***Арга хэмжээ 5.3.4*** "Чингэлтэйд үйлдвэрлэв-2024" арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж хэрэгжилтийг ханган ИТХ-д тайлагнаж ажиллана; | 60.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 5 | 8 | Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн дунд зохион байгуулагдсан "Уран үйлчин-2024" оёдлын салбарын уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 02-ноос 07-ны өдөр хүртэлх хугацаанд 3 үе шаттай зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв" ОНӨТҮГ-т бүртгэлтэй 870 орчим үйлдвэр эрхлэгч үйл ажиллагаа явуулж байгаагаас 429 үйлдвэр эрхлэгч оёдлын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашид кластержин хөгжих бололцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй уралдаан болж өндөрлөсөн.<br><br>Сургалт, өдөрлөг үйл ажиллагааны хүрээнд "Төсөл бичих аргачлал" сургалтад 17 үйлдвэр эрхлэгч, "Энергийн менежмент ба ирээдүйн үр бүтээмжийг нэмэгдүүлэх нь" хувь хүний хөгжлийн сургалтад 27 үйлдвэр эрхлэгч, "Та бол амьдралынхаа гол дүр" хувь хүний хөгжлийн сургалтад 15 үйлдвэр эрхлэгч, "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран Улаанбаатар зочид буудлын сургалтын танхимд зохион байгуулж, 55 үйлдвэр эрхлэгч, "Нягтлан бодогчийн мэдлэг олгох" эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох сургалтад 20 иргэн тус тус хамрагдсан. "Онлайн бизнес" сэдвээр богино хугацааны ур чадвар олгох сургалтад 30 иргэн, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд нийт 9 удаагийн хөгжүүлэх сургалтад хамруулан төслөө хэрхэн бичих, төслийн тооцооллын талаар мэдлэг мэдээлэл олгох, менежментийг сайжруулах чиглэлээр сургалтад нийт 264 үйлдвэр эрхлэгч хамруулсан.<br><br>Гадаад, дотоод үзэсгэлэн худалдаанд хамрагдсан байдал: Оросын Холбооны Улсын Улан-Удэ хотноо Буриад улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Ид шидийн Цагаан сар-2024” –д 9 иргэн-борлуулалт 71,991,000 төгрөг, Ялалтын баярт зориулсан хамтын үзэсгэлэн худалдаанд нийт 8 иргэн-борлуулалт 12,250,000 төгрөг, “Амар байна уу-2024” үзэсгэлэн худалдаа “Шинэ 100 айл” худалдааны төвд 123 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч-борлуулалт 760,862,950 төгрөг, “Их хотын бүсгүйчүүд”–д 3 үйлдвэрлэгч-борлуулалт 2,800,000 төгрөг, “МОНГОЛ ГЭР” үзэсгэлэн арга хэмжээнд 5 иргэн-борлуулалт 16,750,000 төгрөг, “Монгол-Оросын хамтарсан Олон Улсын үзэсгэлэн худалдаа”-д 40 иргэн-борлуулалт 13,250,000 төгрөг, "Жаргалтай инээмсэглэл”-2024 үзэсгэлэн худалдаанд 17 үйлдвэрлэгч-борлуулалт 7,950,000 төгрөг нийт гадаад дотоодын үзэсгэлэн худалдаанд нийт 885,853.950 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 198 | ***Арга хэмжээ 5.3.5*** Нийслэл хотын залуусын дунд үндэсний өв соёл, түүх, ёс заншил агуулсан үндэсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд уриалсан жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн нийгэм дэх байр суурийг нэмэгдүүлэх, борлуулалтад эерэг нөлөө үзүүлэх ач холбогдол бүхий сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ болон контентын ажлыг хийж гүйцэтгэнэ; | 15.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 60 видео танилцуулгыг цувралаар 2 жилийн хугацаанд хийж жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, бүтээгдэхүүн болон байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний давуу талыг олон нийтэд сурталчлан ажилласан. Үүнд: 2022 онд "Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид“ сэдвээр 9 чиглэлийн үйлдвэр эрхлэгчдийн төлөөлөл оролцуулан 50 цуврал видео танилцуулга, 2023 онд "Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн инновац" сэдвээр 10 видео танилцуулгад 30 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг тус тус хамруулсан. Видео танилцуулгууд үзэлтийн тоо 52110, хуваалцсан 514, таалагдсан 1236 үзүүлэлттэй байна. | 30% |
| 199 | ***Арга хэмжээ 5.3.6*** Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулж, хөгжүүлнэ; | 20.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Бизнес эрхлэгчдийг бойжуулсан тоо | 10 | 15% | Зөөврийн ажлын байраар хангах хүрээнд Зөөврийн ажлын байрны дэмжлэгт хамрагдсан 123 байрнаас 118 байрны үйлдвэрлэгчийн ажлын байраар ажлын хэсгийн гишүүд хяналт тавин, ажлын байруудыг коджуулан ажилласан ба 12 үйлдвэрлэгчийн гэнэтийн ослын даатгалыг хийлгүүлж ажилласан. Зориулалтын дагуу ашиглаагүй, үйл ажиллагаатай 14 үйлдвэрлэгчдэд “Мэдэгдэх хуудас” өгч, байгууллагад өргөдөл, хүсэлт ирүүлсэн 7 үйлдвэрлэгчийн хүсэлтийн дагуу, нөхцөл байдлын үнэлгээ хийж, ажлын хэсгийн хурлаар 5 үйлдвэрлэгчийг дэмжин шийдвэрлэж, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжүүлэн байршуулахаар ажиллаж байна. Нийт 109 зөөврийн ажлын байр хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Хөтөлбөрийн биелэлт 90 хувьтай хэрэгжиж байна.<br>“Чингэлтэйд үйлдвэрлэв” байнгын худалдааны цэг: “Чингэлтэйд үйлдвэрлэв” дэлгүүрт шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийн судалгааг хийж, дэлгүүрийн худалдагчидтай уулзалт 2 удаагийн хийж тулгамдаж буй асуудал, борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд авах арга хэмжээ, дэлгүүрт бүтээгдэхүүнээ борлуулж буй үйлдвэрлэгчдэд тавигдах шаардлагын талаар санал солилцсон. Тус дэлгүүрийн хагас жилийн борлуулалтын орлого 70.338.500 төгрөг байна.<br>Түрээсийн хөнгөлөлттэй ажлын байраар хангах хүрээнд: Түрээсийн хөнгөлөлттэй ажлын байранд шинээр орохоор хүсэлт гаргасан 4, салбар-3 байрнаас салбар-2 байранд шилжин орох хүсэлтийн ирүүлсний дагуу зөөврийн ба түрээсийн ажлын байранд сонгон шалгаруулалт хийх, хяналт тавих байнгын ажлын хэсгийн гишүүд тухай бүр нөхцөл байдлын үнэлгээ хийж, 3 удаагийн ажлын хэсгийн гишүүдийн хурлыг зохион байгуулж, ажлын байрны хүсэлт гаргасан үйлдвэрлэгчдийн өргөдлийг шийдвэрлэн, хариу мэдэгдэж, түрээсийн хөнгөлөлттэй ажлын байрны гэрээг төвийн даргаар баталгаажуулан, гэрээг байгуулж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэл эрхлэгчид түрээсийн ажлын байранд орж, үйл ажиллагаагаа явуулж байна. Түрээсийн хөнгөлөлттэй ажлын байрны дэмжлэгт эхний хагас жилд нийт 24 264,100 төгрөгийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан. | |
| 200 | ***Арга хэмжээ 5.3.7*** Нийслэлийн хүн амын 2024 оны хаврын улирлын хэрэгцээнд зориулж дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн махны худалдааг зохион байгуулан ажиллана; | - | Нөөцийн мах худалдан борлуулах агентын гэрээ байгуулсан хүнсний дэлгүүрийн тоо | 35 | 40 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны А/344 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1147 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны “Хүн амын стратегийн хүнсний нөөцийг тогтвортой, тэнцвэртэй байлгах зорилтын хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” А/233 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс нөөцийн мах худалдан борлуулагдаж эхлэхтэй холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулах бэлтгэл ажиллагааг хангах, тавигдах шаардлагын хэрэгжилт, хөргөгч хөлдөөгчийн багтаамж, нөөцлөх боломжтой махны хэмжээ, эрүүл ахуй аюулгүй байдал стандартын шаардлага хангасан 35 аж ахуйн нэгж, байгууллагатай, “ХКҮ” ХХК, “Булган мах маркет” ХХК зэрэг бэлтгэн нийлүүлэгч 2 компанитай “Бэлтгэн нийлүүлэгч, агентын гэрээ” байгуулсан. Нөөцийн мах жижиглэнгээр худалдан борлуулсан 35 хүнсний дэлгүүр нь үхрийн мах 25147 кг, хонины мах 18274 кг, нийт 43421 кг мах худалдан борлуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/69 тушаал "Хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд нөөцийн махны өргөтгөсөн худалдааг дүүргийн 2 дугаар хороо, Алтжин Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбай, 14 дугаар хороо, Далайхүү худалдааны төвийн гадна талбай, 15 дугаар хороо, Хайлаастын 84 автобусны буудал, 20 дугаар хороо, Синго дэлгүүрийн гадна талбай гэсэн 4 байршилд долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв, Бямба, Ням гарагуудад дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчид зохион байгуулан, хяналт тавин ажилласан. Нөөцийн махны өргөтгөсөн худалдаагаар хонины мах 346152 кг, үхрийн мах 71370 кг, ямааны мах 11967 кг, нийт 429489 кг мах худалдан борлуулагдсан байна. | |
| **5.4 Үйлдвэрлэл эрхлэгчдэд: төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 201 | ***Арга хэмжээ 5.4.1***<br>Зочид буудал, аялал жуулчлал, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарт ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөлжсөн сургалтуудыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай | 3.0 Улс, дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 3 | Монголын Тогооч нарын холбооны ерөнхийлөгчийн 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Монгол үндэсний хоол, идээ ундааны улсын аварга тогооч шалгаруулах анхдугаар уралдааны удирдамж”-ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагаас 15 тогооч тус уралдаанд оролцож, туршлага солилцсон. Монголын Ресторан | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран зохион байгуулна; | | | | | зоогийн газрын холбоо, Баар эрхлэгчдийн холбоо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтарсан Монголд зочлох жил арга хэмжээний хүрээнд зочлох үйлчилгээний салбарын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Олон үндэсний хоолны тогооч бэлтгэх” богино хугацааны сургалтад 2024 оны 05 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан ажилласан. | |
| 202 | ***Арга хэмжээ 5.4.2*** Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS4588:2008, амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд ерөнхий шаардлага MNS6043:2009 стандартыг хяналтын хуудасны дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй зочид буудлуудад хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулж, бүртгэл судалгааг сайжруулж, | 3.0 Улс, дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 3 | Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран БНСУ-ын Сэжун их сургуулийн зочлох үйлчилгээний мэргэшсэн эксперт багшийг урьж Зочлох үйлчилгээний ажиллагсдад зориулсан сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуйн нэгж, байгууллага 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс 3 хоногийн хугацаатай хамрагдсан. Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Макс групп” ХХК-ний “Холидай Инн” зочид буудал ажилтнуудынхаа ур чадвар дээшлүүлэх, үйлчлүүлэгчдэд ая тухтай орчин бүрдүүлэх сургалтыг зохион | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартын түвшинд ойртуулна; | | | | | байгуулсан бөгөөд мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх зам талбайг засварлан ашиглалтад оруулан ажилласан байна. | |
| 203 | ***Арга хэмжээ 5.4.3*** Тохирлын гэрчилгээтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээг стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцүүлнэ; | - | Тохирлын гэрчилгээтэй аж ахуйн нэгжийн тоо | 20 | 30 | Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн $19^{2}$.1.1, $19^{2}$.3.2, $19^{2}$.3.3, $19^{2}$.3.6-д зааснаар авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд нь тухай үйлчилгээний ангилал, стандартад тавигдах шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах, эрх бүхий байгууллагаар ангиллаа тогтоолгох үүрэг хүлээсэн байдаг. Авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудад авто үйлчилгээний ангиллын хугацаа дууссан болон ангилал тогтоолгоогүй авто үйлчилгээ эрхлэгч 36 иргэн, аж ахуй нэгж, байгууллагад мэдэгдэл зөвлөмж өгч ажилласан. 2024 оны жилийн эцсийн байдлаар авто үйлчилгээний 9, хоол үйлдвэрлэлийн 11, худалдааны 49, үйлдвэр 2, нийт 71аж ахуйн нэгж, байгууллага тохирлын гэрчилгээнд хамрагдсан байна. | 100% |
| **Зорилт 5.5 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэн, газар тариалангийн бүс нутгийн аймаг, сум, тариалалт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй хамтран ажиллаж органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | | |
| 204 | ***Арга хэмжээ 5.5.1*** Шинэ ургацын төмс, хүнсний ногоо, худалдан борлуулах, мод үр үрслэгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, тариаланч | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбайд "Мод, бут, сөөгийн суулгац, үр үрслэгээ”-ний үзэсгэлэн худалдааг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэдийг дэмжин ажиллана; | | | | | 2024 оны 06, 10 дугаар сард 2 удаа зохион байгуулж, нийт 56 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж, навчит модны үрслэгээ, мандлын цэцгийн үрсэлгээ, ил талбайн болон хүлэмжийн таримлын ногооны үр, үрсэлгээ зэрэг 60 гаруй нэр төрлийн 120,000 ширхэг мод, бутны үрслэгээ худалдаалсан.<br>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, 2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд гарал үүслийн бичиг, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг үндэслэн Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Ховд аймгийн 35 ногоочин иргэдийг хамруулан төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болох "Алтан Намар 2024" арга хэмжээг зохион байгуулж, нийт 77.5 тонн хүнсний ногоо худалдан борлуулж, 300,722,000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | |
| 205 | ***Арга хэмжээ 5.5.2***<br>Ногоо тариалах хүсэлтэй иргэдийг бүлэг үүсгэх замаар төмс, хүнсний ногоо тариалуулж, худаг усжуулалт болон ногоо хадгалах бололцоогоор | 10.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн, Монгол Улсын Засгийн газраас иргэд, тариаланчдын хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 80 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажлын байр бий болгоно; | | | | | хувийн хөнгөлөлттэй үнээр хүнсний ногооны үр олгосонтой холбогдуулан 10 төрлийн хүнсний ногооны үрийн хуваарийг хүргүүлсний дагуу нийт үнэ болох 225360 төгрөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын бараа үйлчилгээний бусад зардлаас гарган шар лууван 1кг, шар манжин 3кг, хүрэн манжин 2кг, урт сонгино 1кг, байцаа1 уут, ил талбайн хэмх 2 уут, бөөрөнхий сонгины төл үр 1уут, саримс 10кг, тарвас 0.1кг, нийт 17.1кг хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй олгох ажлыг 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 7-24 дүгээр хороодын өрхийн тариалан эрхлэгч 48 иргэнд олгож, зохион байгуулан ажилласан. Үнэ төлбөргүй үр олгосон 48 өрхийн тариаланч иргэдээс 2024 оны 10 дугаар 29-ний өдөр тариалалтын мэдээг авч 9 төрлийн хүнс ногооны үрийг тариалж, нийт 2.2 тонн ургац хураасан. | |
| 206 | ***Арга хэмжээ 5.5.3*** Өвлийн хүлэмж, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, иргэдийг амин дэмээр баялаг жимс, хүнсний ногоогоор тогтмол хангах боломжийг бүрдүүлнэ; | 15.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Өвлийн хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлсэн тоо | 2 | 2 | “Хөгжлийн шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрийн хүрээнд “Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал”, "Жижиг дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" 2 удаагийн сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо тариалах хүсэлтэй өрхийн тариалан эрхлэгч 12 иргэнийг хамруулан ажилласан. | 70% |
| 207 | ***Арга хэмжээ 5.5.5*** Органик хүнс, хүнсний ногооны чиглэлээр үйл | 2.0 | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 1 | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын 2024 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг сургалтад хамруулж, зөвлөмж үзүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх талаар арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллана; | Дүүргийн төсвийн хөрөнгө | | | | оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” 118 дугаар тогтоол, органик хүнсний тухай хуулийг сурталчлан таниулах сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр дүүргийн нутаг дэвсгэрт өрхийн тариалан эрхлэгч, органик хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 55 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан зохион байгуулав. Олон Улсын Хөгжлийн агентлаг (USAID)-ийн "Жижиг дунд бизнесийн тогтвортой хөгжлийг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх" (BEST) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч “Хөгжлийн шийдэл” ТББ-аас зохион байгуулсан “Хүлэмжийн аж ахуйн зохистой дадал ба Японы тэргүүн туршлага” сургалтад дүүргийн 18-р хорооны "Өрнөх" бүлгийн тэргүүн Ж.Нацагням хамрагдсан. Тус сургалтад хамрагдаж, эзэмшсэн мэдлэгийн хүрээнд “Жамдал Мандал” ХХК-г байгуулан, хүнсний ногоог хатааж, боловсруулах үйлдвэрлэл эрхлэн ажиллаж байна. | |
| 208 | ***Арга хэмжээ 5.5.6*** Мал, амьтны гоц болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх | 10.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Вакцинд хамрагдсан мал амьтны тоогоор | 6500 | 6600 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/07, дүүргийн Засаг даргын 2024 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээнд мал, амьтныг хамруулж, өвчлөлийг бууруулна; | | | | | A/03 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр, хориглосон бүсэд мал, амьтан орж ирснээр малын халдварт болон гоц халдварт өвчин дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүс нутагт гаргах, эздийг олж тогтоон, хүлээлгэн өгөх, зөрчлийг тухай бүр арилгах зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд 7 хоногийн 2 өдөр 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хяналт тавьж, нийт 1096 литр шатахуун зарцуулан, 3451 тооны адуу малыг дүүргийн нутаг дэвсгэрээс гарган ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны A/410 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны A/127 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй гэрийн тэжээвэр амьтдыг халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, туулгалт, боловсруулалт хийх ажлыг дүүргийн мал эмнэлгийн газар болох “Содхан” ХХК-тай хамтран 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 3599 нохой, муурыг вакцинд хамруулан, 7198мл вакцин зарцуулсан. | |
| **Зорилт 5.6 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшнийг дээшлүүлэх талаар анхаарч ажиллана.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 209 | ***Арга хэмжээ 5.6.1.*** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын чанар хүртээмжийг сайжруулах, зорилгоор худалдаа үйлчилгээний чиглэлээр шинээр гарсан болон дагаж мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудын талаар хэрэглэгчдэд зориулсан гарын авлага, материал бэлтгэж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад олгоно; | 6.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 3 | 3 | Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох тухай” А/1467 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Цагдаагийн газартай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 186 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 18 нас хүрээгүй иргэнд электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, захирамжийг танилцуулан ажилласан. “Онлайн бизнес төв” платформын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-д хэрхэн бүртгүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, бүртгэл үүсгэхэд дэмжлэг үзүүлэн, заавар гарын авлагыг 250 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад, "Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам"-ын гарын авлагыг 200 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тараан ажилласан. Техникийн зохицуулалт батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор “Мах, махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалт” сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нийслэлийн Мал эмнэлгийн газар, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүнс | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 171 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулсан. | |
| 210 | ***Арга хэмжээ 5.6.2*** Нийслэлийн хүн амын ихээр үйлчлүүлдэг томоохон цэгүүдээс (зах, худалдааны төв, супермаркет) өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн судалгааг хийж, үр дүнг боловсруулан, танилцуулан тархаана; | - | Судалгааны давтамж | 52 | 52 | Дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8 аж ахуйн нэгж, байгууллагаас гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөц болон үнийн нийт 52 удаагийн судалгааг долоо хоног бүрийн баасан гарагт авч, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллаж байна. Томоохон зах, худалдааны төвөөс авсан гол нэрийн 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийн индекс дунджаар 12.3 хувиар өссөн. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт хэвийн байна. | 100% |
| 211 | ***Арга хэмжээ 5.6.3*** Нийслэлийн Засаг дарга 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад ногоон байгууламжийг нэмэгдүүлэх боломжит байршил, төрийн өмчит байгууллагуудыг | 40.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 0 | 2 | Нийслэлийн Засаг дарга 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулсан нийт 25 түргэн үйлчилгээний цэгийг албадан буулгаж, газар чөлөөлсөн. Газар чөлөөлсөн дүүргийн 1 дүгээр хороо, Барилгачдын талбай, 5 дугаар хороо, Тэнгис кино театрын зүүн талын гудамж, талбайд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэстэй хамтран тохижилт, ногоон байгууламж бий болгох ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуваарилан хэрэгжилтийн хангуулна; | | | | | “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 93 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн хариуцах орчны 50 метрт цэцгийн мандал зэрэг ногоон байгууламж хийж тохижуулсан. | |
| 212 | ***Арга хэмжээ 5.6.4*** Дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өөрт хамаарах барилга, байгууламжийн орчныг сайжруулах зорилгоор хотын стандартад нийцсэн ногоон байгууламж бий болгох, нэмэгдүүлэх талаар уриалга, сургалт хийнэ; | 10.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 0 | 2 | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/57 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны А/93 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчлийг арилгах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий 38 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд зөвшөөрөлгүй самбар байрлуулсан, гадна зар сурталчилгааны өнгө үзэмж нь алдагдсан урагдаж гэмтсэн самбарыг сольж шинэчлэх, буулгах 3 хоногийн хугацаатай мэдэгдэх хуудсыг 215 иргэн, аж ахуй нэгж, байгууллагад хүргүүлж 2024 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдөр зөрчлөө арилгаагүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын 125 тулгуурт самбар, гадна зар сурталчилгааны самбарын буулгалтыг хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын орлогчийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдөр баталсан удирдамжаар "Тохилог Чингэлтэй" аян | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулагдаж хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 150 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зураглалаар тогтоосон орчны 50 метр хүртэлх талбайг тохижуулах, өнгө үзэмжийг сэргээх, засвар үйлчилгээ хийх, ногоон байгууламж бий болгох, шарилж зэрлэгийг зулгаах, хог хаягдлыг цэвэрлэх талаар мэдэгдэж, хэрэгжилтийг 87 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ханган ажиллалаа. | |
| **Зорилт 5.7 Гэр хороололд нийтийн ахуйн үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдийг байгуулж, хөрөнгө оруулалтын төсөл, иргэдийн санал санаачилгыг дэмжин ажиллана.** | | | | | | | |
| 213 | ***Арга хэмжээ 5.7.1*** Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн өмчлөлд байгаа халуун усны газруудын үйл ажиллагаа, ашиглалтыг сайжруулах замаар хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын ажил хэрэгжүүлнэ; | 5.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар | 50% | 70% | Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 3/234 дүгээр албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт улс болон нийслэлийн хөрөнгөөр баригдсан нийтийн халуун усны газруудын өмчийн мэдээллийг гарган ирүүлэх хүсэлт илгээсний дагуу Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2023 оны 3/197 дугаартай албан бичгээр дүүргийн нутаг дэвсгэрт 6 байршилд нийт 499,842,927.10 төгрөгийн өртөг бүхий нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилгууд бүртгэлтэй байгаа талаар мэдээллийг ирүүлсэн. Дүүргийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8, 10, 14, 17, 20 дугаар хороодын нутаг дэвсгэрт байрлах нийтийн халуун усны барилгуудын ашиглалтыг сайжруулах зорилгоор дүүргийн Засаг даргын 2024 оны А/192 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 214 | ***Арга хэмжээ 5.7.2***<br>Гэр хорооллын нийтийн ахуйн үйлчилгээний төвлөрсөн бичил төвүүдэд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана; | 1.5 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 2 | Дүүргийн 18-р хороо, гэр хорооллын бүсэд үйл ажиллагаа зогссон нийтийн ахуйн үйлчилгээний бичил төвд 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсээс нөхцөл байдалтай танилцахад тус нийтийн ахуйн үйлчилгээний төвүүд нь ахуйн үйлчилгээний стандарт хангахгүй, цэвдэгтэй, бохирын шугам хөлдсөн гэх шалтгаанаар үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан. Цаашид зориулалтын дагуу засвар хийж ашиглахад их хэмжээний хөрөнгө шаардлагатай байгаа тул зориулалтыг нь өөрчилж, ашиглалтад оруулахаар дүүргийн Засаг даргын 2024 оны А/192 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | 70% |
| 215 | ***Арга хэмжээ 5.7.3***<br>Дүүргийн тэжээвэр амьтадын тооллогыг зохион байгуулах, хяналт мониторинг явуулах, үр дүнг танилцуулах; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Тооллогод хамрагдсан хувь | 100 | 100 | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 01 албан даалгавар, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/26 тушаал, Нийслэлийн Засаг даргын А/419 дүгээр захирамж, дүүргийн Засаг даргын А/126 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн мал эмнэлгийн албан хаагчид шувуутай өрхийн судалгааг шинэчлэн гаргаж 48 өрхийн шувууны байр орчин 1920 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, мал амьтны халдварт, гоц халдварт өвчний талаар сэрэмжлүүлэн зөвлөмж хүргүүлсэн. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мах хадгалах зоорь агуулах, заал лангуу орчин 1600 м2, мах ангилан худалдаалах, бууз, банш цехийн 800 м2, дайвар бүтээгдэхүүн ангилал, толгой шийр хуйхлах цэгийн 400 м2, нийтийн эзэмшил, мал амьтны гаралтай түүхий эдийн хаягдал, сэг зэм 600 м2, талбайд цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг холбогдох журам зааврын дагуу хийж нийт 5320 м2 талбайг хайкоф 1:2000, сүперкелл 1:1000 уусмалаар автомаксаар шүрших, хлорын шохойн бэлдмэлээр хуурай цацаж ариутгаж халдваргүйжүүлсэн. Дүүргийн Статистикийн хэлтэстэй хамтран 2024 оны 08 дугаар сард дүүргийн тэжээвэр амьтны тооллогыг зохион байгуулж нохой 6240, муур 280, тахиа 361 тус тус тоологдсон байна. | |
| **Зорилт 5.8 Авто үйлчилгээний салбарт тавих стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэж, хяналт шалгалтыг сайжруулах замаар тохирлын үнэлгээнд бүрэн хамруулж, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 216 | ***Арга хэмжээ 5.8.1.*** Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуй нэгжид холбогдох дүрэм, журам мөрдөгдөж байгаа эсэхэд хяналт, шалгалт зохион байгуулж сургалтад хамруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана; | 1.25 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 4 | Нийслэлийн Нийтийн тээврийн газрын даргын 2024 оны 03 дугаар арын 27-ны өдрийн "Нийслэлийн нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах, үзлэг шалгалтын удирдамж"-ын дагуу нийслэлийн Нийтийн тээврийн газар, Ус сувгийн удирдах газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран 2024 оны 04 дүгээр сарын 09-15-ны хооронд дүүргийн нутаг нутаг дэвсгэрт авто угаалгын чиглэлээр 28 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 3 угаалга саарал усны тоног төхөөрөмж ашиглаж, 2 авто угаалга түр хугацаанд ажиллахгүй, 8 авто угаалга зөөврийн ус ашиглаж байна. УСУГ-тай цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээтэй 14, ОСНААУГ-тай гэрээтэй 1, цэвэр ус, бохир ус зөөврөөр хэрэглэдэг 6, нийт 21 авто угаалгын газарт хяналт шалгалт хийв. Хэрэглэсэн усаа цэвэршүүлэн дахин ашиглах тоног төхөөрөмжтэй 3 машин угаалга байна. Хяналт шалгалтын үр дүнд 4 авто угаалгын хаягийн зөрчил арилгуулж, 6 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ангиллын гэрчилгээ, онлайн бизнес төвд бүртгүүлэн ажилласан. | |
| **Зорилт 5.9 Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнс, худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэнэ.** | | | | | | | |
| 217 | ***Арга хэмжээ 5.9.1.*** Худалдаа, нийтийн хоолны салбарт тавигдах стандартын хэрэгжилтийг хангуулж, хяналт шалгалт, мэргэжил арга зүйн удирдлагаар байгууллагуудыг хангаж ажиллана; | 2.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 2 | 3 | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/35 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт баар/тайчих клубийн чиглэлээр 9, алжаал тайлах төвийн чиглэлээр 11 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт, шалгалтыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтаар хүнсний аюулгүй байдал хангаагүй 3 аж ахуйн нэгж, байгууллага тус бүрийг 3000 нэгж буюу нийт 9000000 төгрөгөөр торгож хэргийн материалын прокурорт хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явуулдаг буюу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт ирүүлсэн нийт 364 хуулийн этгээдэд стандартын хэрэгжилтийг хангуулахад хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 42 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран “Гадна орчны тохижилт”, “Орчны аюулгүй байдал” сэдвээр 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр сургалт зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр баталсан “Сургалт зохион байгуулах тухай” удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Чингэлтэй дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлага болох 161 албан хаагчдад “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандарт, шим тэжээлийн байдал, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдээллийг өгөх, хоолны цэс төлөвлөлт, технологийн картыг хоол үйлдвэрлэлд нэвтрүүлэх сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 26-ний өдөр зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2024 оны "Хяналт, шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай" А/289 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн 20 сургууль, 37 цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, хүнсний эрүүл ахуй, стандартын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 218 | ***Арга хэмжээ 5.9.2.*** Хүнсний худалдаа, үйлдвэр үйлчилгээний газруудад Хүнсний аюулгүй байдал, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний сонголт, эрүүл ахуйн зохистой дадлыг хэрэгжүүлэх нь" салбарын сургалт зохион байгуулна; | 3.0 Дүүргийн төсвийн хөрөнгө | Зохион байгуулсан ажлын тоо | 1 | 2 | "Хүнсний хангамж, аюулгүй байдал" Үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас хэвлүүлсэн "Хүнсний хувьсгал №4" сэтгүүлийг дүүргийн нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 100 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тараасан. Чингэлтэй дүүргийн сургуулийн өмнөх боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлага болох нийт 90 албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолын хүрээнд "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага" стандарт, шим тэжээлийн байдал, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдээлэл, хоолны цэс төлөвлөлт, технологийн картыг хоол үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. "Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн зохистой дадал, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний сонголт" сэдвээр 2024 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 11 дүгээр сарын 07-ны өдөр нийслэлийн Мал эмнэлгийн газар, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт хүнс худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 171 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сургалт зохион байгуулсан. | |
| **ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ** | | | | | | **94.8%** | |

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН В.УРАНЧИМЭГ